



МОНГОЛБАНК

**ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН
ТАЛААР 2015 ОНД БАРИМТЛАХ
ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСӨЛ**

**УЛААНБААТАР
2014 он**



МОНГОЛБАНК

**ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН
ТАЛААР 2015 ОНД БАРИМТЛАХ
ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСӨЛ**

**Улаанбаатар
2014**



ГАРЧИГ

I. ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2015 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ	5
II. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ӨНӨӨГИЙН БОЛОН ОЙРЫН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТАЛААР ХИЙСЭН ТООЦОО СУДАЛГАА	18
2.1 ДОТООД ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТ	21
2.1.1 Оюу толгой, Таван толгойн үйлдвэрлэл	22
2.1.2 Үйлдвэрлэлийн зөрүү	23
2.2 УЛСЫН ТӨСӨВ	24
2.3 МӨНГӨНИЙ ЗАХ	27
2.3.1 Мөнгөний үзүүлэлтүүд	27
2.3.2 Мөнгөний зах, хүүгийн түвшин	29
2.4 ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ, ГАДААД ЗАХ ЗЭЭЛ	33
2.4.1 Төгрөгийн гадаад валюттай харьцах хани	33
2.4.2 Монгол Улсын гадаад секторын төлөв байдал	34
2.4.2.1 Монгол Улсын төлбөрийн тэнцэл	34
2.4.3 Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц	40
2.4.4 Монгол Улсын нийт гадаад өр	42
2.4.5 Гадаад секторын 2015 оны төлөв	43
2.5 ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ	45
2.6 БАНКНЫ САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ	46
2.7 ЗЭЭЛ	54
2.8 ИНФЛЯЦИ, ТҮҮНИЙ ХҮЛЭЭЛТ БОЛОН ОЙРЫН ТӨЛӨВ	57
III. ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2014 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ БАТЛАХ ТУХАЙ УИХ-ЫН 62 ДУГААР ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ	63
IV. ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2014 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ	79

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2014 оны ... сарын ... өдөр

Дугаар ...

**Төрөөс мөнгөний бодлогын талаар 2015 онд
баримтлах үндсэн чиглэл батлах тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2015 онд баримтлах үндсэн чиглэлийг хавсралтаар баталсугай.

2. Санхүүгийн болон макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эдийн засгийн дархлааг сайжруулах зорилгоор нэгдсэн төсвийн зохистой бодлогоор төсвийн тогтвортой байдлыг хангаж, гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлэн, дотоодын үйлдвэрлэлийг дэмжих арга хэмжээ авахыг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/-т, эдийн засгийн бодит секторыг мөнгөний бодлоготой уялдуулан дэмжиж ажиллахыг Монголбанк /Н.Золжаргал/-нд тус тус даалгасугай.

3. Эдийн засгийн тогтвортой өсөлтийн суурийг бэхжүүлэх, дотоодын хуримтлалыг нэмэгдүүлэх, санхүүгийн зах зээлийн хөгжлийг дэмжих зорилгоор төлбөрийн тэнцлийн тогтвортой, эерэг орчинг бүрдүүлж, нийгмийн даатгал, тэтгэврийн сангийн тогтолцооны шинэчлэлийг эрчимжүүлэх, баялгийн сангийн эрх зүйн орчинг бүрдүүлэх, институциональ хөрөнгө оруулалтын сангуудыг шинээр бий болгох, тэдгээрийг үе шаттай хөрөнгөжүүлэх цогц арга хэмжээ авахыг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/-т, эдгээр үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллахыг Монголбанк /Н.Золжаргал/, Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/-нд тус тус даалгасугай.

4. Энэ тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулахыг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/, Монголбанк /Н.Золжаргал/, Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/-нд тус тус даалгасугай.

5. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Б.Гарамгайбаатар/-нд үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА****З.ЭНХБОЛД**

Монгол Улсын Их Хурлын 2014 оны ... сарын ...-ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2015 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Мөнгөний бодлогын үндсэн зорилт нь эдийн засгийн гадаад тэнцвэрийг хангах, инфляцийг нам, тогтвортой түвшинд байлгах, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, эдийн засаг дунд, урт хугацаанд тэнцвэртэй бөгөөд тогтвортой өсөх орчинг бүрдүүлэхэд чиглэнэ.

1. Мөнгөний бодлогын зорилтын хүрээнд:

1.1 Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг 2015 оны эцэст 7 хувьд, 2016-2017 онд энэ түвшинд тогтворжуулсны үндсэн дээр иргэдийн бодит орлогыг хамгаалж, эдийн засаг тогтвортой өсөх нөхцөлийг бүрдүүлнэ.

1.2 Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь санхүүгийн болон макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эдийн засгийн гадаад тэнцвэрийг дэмжихүйц уян хатан тогтож, дунд хугацаанд дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, ажлын байрыг хамгаалахтай нийцтэй байх зарчим баримтална.

2. Банкны салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэх хүрээнд:

2.1 Банкуудын төлбөрийн чадварыг хадгалах хүрээнд өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх замаар системийн болзошгүй эрсдэлээс хамгаалах чадварыг нэмэгдүүлж, санхүүгийн салбарын дархлааг сайжруулна.

2.2 Олон улсад мөрдөгдөж байгаа хяналт шалгалтын зарчим, зохицуулалтын арга хэрэгслийг банкны салбарын үйл ажиллагааны онцлогтой уялдуулан эрсдэлийн үнэлгээнд суурилсан хяналт шалгалтыг үргэлжлүүлнэ.

2.3 Банкны үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг төрөлжүүлэн олгох хууль эрх зүйн орчинг сайжруулах боломжийг судалж, дотоод, гадаадын эрх бүхий байгууллагуудтай хамтран үр нөлөөтэй хяналт шалгалтыг боловсронгуй болгох чиглэлд ажиллана.

3. Санхүүгийн зах зээлийн дэд бүтэц, түүний институцийг бэхжүүлэх хүрээнд:

3.1 Монгол Улсын төлбөр тооцооны системийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хангаж, дэвшилтэт технологид суурилсан банкны шинэлэг үйлчилгээг олон нийтэд хүртээмжтэй болгох чиглэлээр ажиллана.

3.2 Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн банкны зах зээлд оролцогчдын эрх ашгийг хамгаалах, олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх цогц арга хэмжээг эрчимжүүлнэ.

3.3 Мөнгөний бодлогын шийдвэр гаргах үйл ажиллагааг улам боловсронгуй болгон, мөнгөний бодлогын үндсэн зорилт, хэрэгжилтийг олон нийтэд тогтмол тайлагнах ажлыг үргэлжлүүлж, Төв банкны нээлттэй, ил тод байдлыг хадгална.

I. ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2015 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Макро эдийн засгийн тогтвортой байдал нь төлбөрийн тэнцлийн эерэг орчин, инфляцийн нам, тогтвортой түвшин, бодит эдийн засаг тэнцвэртэй бөгөөд тогтвортой өсөх орчин бүрдсэнээр хангагдана. Эдийн засгийн гадаад, дотоод тэнцвэртэй байдал нь эдийн засгийн шингээх чадвар, хуримтлал, хөрөнгө оруулалтын оновчтой бодлого, төлбөрийн тэнцлийг тогтвортой сайжруулах бодлого болон төсөв, мөнгөний зохистой бодлогын хослолын үр дүнгээс хамаарна. Иймд Монголбанк 2015 оны мөнгөний бодлогыг эдийн засгийн гадаад тэнцвэрийг хангах, инфляцийг дунд хугацаанд нам, тогтвортой түвшинд байлгах, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэх, улмаар эдийн засаг дунд, урт хугацаанд тэнцвэртэй бөгөөд тогтвортой өсөх орчинг бүрдүүлэхэд чиглүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Монгол Улсын төлбөрийн тэнцэлд 2012 оны сүүлийн хагасаас эхэлж үүссэн дарамт нь 2013 онд хямралын шинжтэй болж, улмаар төлбөрийн тэнцлийн хүндрэл 2014 оны туршид үргэлжилж байна. Сүүлийн 19 сарын хугацаанд төлбөрийн нийт тэнцэл -2845 сая¹ ам.доллар (ДНБ-ий 24%)-ын алдагдалтай гарч, Монгол Улсын гадаад цэвэр актив (ГЦА) сүүлийн 17 сарын турш огцом буурсаар байна. Тухайлбал, Засгийн газрын үнэт цаасыг гадаад зах зээлд арилжаалсан 2012 оны 12 дугаар сараас хойшхи 20 гаруй сарын хугацаанд ГЦА 5.3 их наяд төгрөгөөр буюу ДНБ-ий 29%-тай тэнцэх хэмжээгээр буурчээ. 2011-2012 оны дунджаар гадаадын шууд хөрөнгө оруулалт ДНБ-ий 40 гаруй хувийг² эзэлж байсан бол 2013 онд 16 хувь, 2014 оны эхний хагаст ердөө 8 хувьтай тэнцэх болов.

Ийнхүү төлбөрийн тэнцэлд 2012 оноос эхэлж үүссэн дарамт нь эдийн засгийн 2013-2014 оны хүндрэлийн суурь шалтгаан болсон бөгөөд гадаадын шууд хөрөнгө оруулалт огцом буурсан, гадаад худалдааны нөхцөл муудсан, томоохон төслүүдийн хэрэгжилт он дамнан удааширч тодорхой бус байдал эрс нэмэгдсэн, гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлэх, төлбөрийн тэнцлийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээний нөлөөлөл нь хангалттай бус байсан, Монгол Улсын зээлжих зэрэглэл буурсан зэрэг туйлын сөрөг орчинд Монголбанк мөнгөний бодлогыг хэрэгжүүлж, төлбөрийн тэнцлийн хүндрэлийн үед эдийн засгийг бүхэлд нь тогтворжуулах, эдийн засгийн суурь бүтэц, ажлын байрыг хамгаалах арга хэмжээ авсан юм. Монголбанк 2012 оны сүүлчээс эхлэн төрийн мөнгөний бодлогыг үнийн тогтвортой байдлын зорилтыг хангахын сацуу эдийн засгийн тогтвортой өсөлт, бүтцийн шинэчлэл, бодит секторын идэвхжилийг дэмжих, хуримтлал, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд тус тус чиглүүлсэн билээ. Төлбөрийн тэнцлийн хямралтай орчинд төрийн мөнгөний бодлого нь дараах үе шаттайгаар хэрэгжлээ. Үүнд:

Нэгд, “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах хөтөлбөр”-ийг Засгийн газартай хамтран хэрэгжүүлснээр мах, гурил, жижиглэнгийн худалдааны шатахуун зэрэг иргэдийн хэрэглээний суурь бүтээгдэхүүний үнийн өсөлтийг эрс бууруулах, тогтвортой байлгах, дундаж давхаргын бодит орлогыг хамгаалах, хэрэглээний суурь бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх зэрэг үр дүнд хүрлээ. Хөтөлбөрт хамрагдсан барааны үнийн өсөлт нь

¹ ДНБ-ий 23%-тай тэнцэхүйц хэмжээ буюу сар бүр дунджаар -150 сая ам.долларын алдагдал хүлээж байна.

² Гадаадын шууд хөрөнгө оруулалтын ДНБ-д эзлэх хувь 2010 онд 22%, 2011 онд 44%, 2012 онд 35% байв.

2010-2012 онд дунджаар нийт инфляцийн 35%-ийг эзэлдэг байсан бол түүний инфляцид үзүүлэх шууд нөлөөлөл нь 2013-2014 онд 5.5 дахин буурч, инфляцийн бүтцэд тогтвортой, эерэг өөрчлөлт гарсаар байна.

Хоёрт, санхүүгийн салбарт зээлийн тасалдал үүсч болзошгүй байсныг урьдчилан харж, Монголбанкнаас банкуудад хугацаатай хадгаламж байршуулан, банкуудын төлбөрийн чадварыг хадгалах арга хэмжээ авснаар системийн хэмжээнд итгэлийг сэргээж, банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжсэн бөгөөд санхүүгийн салбарыг бүхэлд нь хамгаалав. Банкны системийн хэмжээнд өөрийн хөрөнгийн хүрэлцээ 17 орчим хувь, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 38 гаруй хувьтай байгаа нь Монголбанкнаас тавьдаг зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн хамгийн бага шаардлагаас харгалзан 5 нэгж хувь, 13 нэгж хувиар өндөр болж, санхүүгийн салбарын эрсдэл даах чадвар сайжирсан.

Гуравт, инфляцийн хэтийн хандлага нь зорилтот түвшинтэй нийцтэй байсан үед мөнгөний бодлогын хүүг 2013 оны 1, 4, 6 дугаар саруудад, нийт 2.75 нэгж хувиар бууруулж, эдийн засгийн идэвхжилийг дэмжин, мөнгөний нийлүүлэлтийг бодит секторт эргэлтийн хөрөнгийн зээл олгох хэлбэрээр нэмэгдүүлсэн нь ДНБ-ий бодит өсөлтийг тогтворжуулах, ажлын байрыг хамгаалахад голлох нөлөө үзүүлсэн. Судалгааны³ үр дүнгээс харахад 2013 онд ДНБ-ий бодит өсөлт 11.7%-тай гарсны 8.6 нэгж хувь (73% нь)-ийн өсөлт нь мөнгөний уламжлалт бус тэлэх бодлогын нөлөөгөөр бий болжээ.

Дөрөвт, “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлснээр дундаж давхаргын хуримтлалыг нэмэгдүүлж, төлбөрийн тэнцлийн хүндрэлээс шалтгаалж өрхийн төсөвт учрах нэмэлт ачааллыг нь зөөлрүүлсний зэрэгцээ өрхийн зардлын бүтцийг зохистой болгох, дунд, урт хугацаанд инфляци буурах, эдийн засаг тогтвортой өсөх нөхцөлийг бүрдүүлэх бүтцийн шинэчлэлийг эхлүүлээд байна. Хөтөлбөр хэрэгжсэнээс хойшхи 13 сарын хугацаанд орон сууцны ипотекийн зээлийн үлдэгдэл 2492 тэрбум төгрөгт хүрч ДНБ-ий 13%-тай тэнцэх хэмжээнд, зээлдэгчдийн тоо 59,756 боллоо.

Тавд, гадаад валютын орох урсгалыг дэмжих, эдийн засаг дахь урт хугацаатай гадаад валютын эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор олон улсын зах зээл дээрээс 3 болон түүнээс дээш жилийн хугацаатай бонд болон зээл хэлбэрээр банкны татсан гадаад валютын эх үүсвэрийг Заавал байлгах нөөц (ЗБН)-ийн шаардлагаас чөлөөлсөн.

Зургаад, Монголбанк төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцэж, уян хатан тогтох зарчмыг тууштай баримтлан ажиллаж байна. 2013-2014 оны төлбөрийн тэнцлийн хүндрэлээс шалтгаалсан ханшийн өөрчлөлт нь богино хугацаанд тодорхой зардлыг дагуулсан хэдий ч, урт хугацаанд манай эдийн засгийн өрсөлдөх чадвар болон экспортын боломжийг алдагдуулахгүй байх, гадаад валютын улсын нөөцийг хамгаалах, гадаад худалдаа, урсгал тэнцлийн алдагдлыг бууруулах, макро эдийн засгийн гадаад тэнцвэрийг дэмжих, дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, ажлын байрыг хамгаалахад нийцтэй байсан бөгөөд улмаар эдийн засагт бүтцийн шинжтэй томоохон шинэчлэл хийх урьдач нөхцөлийг хангахад чухал үүрэгтэй байсан юм. Нөгөө талаас гадаад худалдааны эргэлт нь ДНБ-ээс давсан нээлттэй эдийн засагт валютын ханшийн хэт огцом өөрчлөлт нь эдийн засгийн тогтвортой байдалд сөрөг нөлөөтэй тул

³ Монголбанкны эмпирик судалгаа (2014).

Монголбанк ханшийн өөрчлөлтийн хандлагыг өөрчлөлгүйгээр, зөвхөн огцом хэлбэлзлийг зөөлрүүлэх зорилгоор валютын захад оролцох бодлогыг үргэлжлүүлэн ажиллав. Ингэснээр санхүүгийн салбарт үүсч болзошгүй сөрөг нөлөөг зөөлрүүлж, дунд хугацаанд макро эдийн засгийн тогтвортой байдал болон ажлын байрыг хамгаалах, дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн болно.

Долоод, эдийн засгийн дунд хугацааны бүтцийн өөрчлөлт, дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, ашигт малтмалын бус салбарын экспортыг нэмэгдүүлэх зорилгоор ноолуурын үйлдвэрлэл, экспорт, алт олборлолтыг дэмжих, барилгын материалын импортыг дотоодын үйлдвэрлэлээр орлуулахад чиглэсэн арга хэмжээг Засгийн газартай хамтран хэрэгжүүлж байна.

Дээр дурдсан арга хэмжээнүүдийн үр дүнд эдийн засгийг тогтворжуулж, 2013-2014 онуудад санхүүгийн салбарт зээлийн тасалдал үүсэх, нийт М2 мөнгөний нийлүүлэлт огцом буурах, санхүүгийн салбарт системийн шинжтэй тогтворгүй байдал бий болох, эдийн засгийн хямрал нүүрлэх эрсдэлээс урьдчилан сэргийлж чадсан.

Гэвч гадаадын шууд хөрөнгө оруулалт, гадаад цэвэр актив огцом буурсан хандлага тасралтгүй үргэлжилж, төсөвтэй адилтгах хөрөнгө оруулалтын зарцуулалтууд буурахгүй байсны зэрэгцээ эдийн засагт орж ирэх гадаад валютын урсгал, төлбөрийн тэнцэл сайжрахгүй хэвээр байна. Хэрэв энэхүү сөрөг хандлагыг сөрсөн зохистой бодлогын арга хэмжээ авахгүй бол төлбөрийн тэнцлийн “хямралт” нөхцөл байдал нь санхүүгийн тогтворгүй байдалд хүргэж болзошгүй байв. Иймд, Монголбанк төлбөрийн тэнцлийн хүндрэлийг зөөлрүүлэх, инфляцийг эрчимжүүлэхгүй байлгах, дунд болон урт хугацаанд санхүүгийн тогтвортой байдлыг хангах, макро эдийн засгийн тогтвортой байдалд учирч болзошгүй эрсдэлээс сэргийлэх, иргэдийн бодит орлогыг хамгаалах зорилгоор 2014 оны 7 дугаар сард мөнгөний бодлогын хүүг 1.5 нэгж хувиар нэмэгдүүлж 12% болгов.

Үүний зэрэгцээ гадаад валютын зээлийн эрсдэлээр жигнэх хувь хэмжээг нэмэгдүүлэх, гадаад валютын зээлийн эрсдэлийг бууруулах, долларжилт нэмэгдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр *“Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-д,* санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилтын хүрээнд активын ангилалд эрсдэлийн санг нэмж байгуулах чиглэлээр *“Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д* тус тус нэмэлт, өөрчлөлт оруулаад байна.

Монгол Улсын төлбөрийн тэнцэл өндөр алдагдалтай, гадаад цэвэр актив огцом буурсан хандлага үргэлжилж, макро эдийн засгийн гадаад тэнцвэргүй байдал удаан үргэлжилж байгаа нь цаашид мөнгөний бодлогоор эдийн засгийн бодит секторын идэвхжил, ДНБ-ий бодит өсөлтийг дэмжих боломжийг хязгаарлаж байна. Түүнчлэн, экспортын орлого, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар эдийн засаг дахь гадаад валютын орох урсгалыг эрс сайжруулахгүйгээр улсын төсвийн зардал болон төсвөөс гадуурх зарцуулалтыг нэмэгдүүлэх нь макро эдийн засгийн гадаад, дотоод тэнцвэрт сөргөөр нөлөөлөх үр дагавартай байна.

Эдийн засгийн бодит өсөлт 2014 оны эхний хагаст 5.3 хувьд хүрч саарсан бөгөөд Монгол Улсын гадаад, дотоод эрэлт буурч, эдийн засаг, бизнесийн идэвхжил удааширч байна. Эдийн засагт орж ирэх гадаад валютын урсгал, тэр дундаа гадаадын шууд хөрөнгө оруулалт буурч, Монголбанкнаас эдийн засгийг тогтворжуулах зорилгоор мөнгөний уламжлалт бус бодлогын хүрээнд эдийн засгийн бодит сектор

2013 онд хийсэн мөнгөний нийлүүлэлт нь хөтөлбөрүүдийн зээлийн эргэн төлөлтөөр алгуур буурч байгаа нь эдийн засагт үзүүлэх нийт хөрөнгө оруулалтын нөлөөг бууруулах, эдийн засгийн өсөлтийг сулруулах, мөнгө, зээлийн үзүүлэлтүүдийн өсөлт саарахад тус тус нөлөөлж байна.

2015 онд гадаад валютын орох урсгал мэдэгдэхүйц нэмэгдэж, төлбөрийн тэнцэл эрс сайжрахгүй байх тохиолдолд эдийн засгийн бодит секторыг мөнгөний бодлогоор дэмжих боломж улам бүр хязгаарлагдах, эдийн засгийн тогтвортой өсөлтөд шаардагдах мөнгөний нийлүүлэлтийн хэмжээ дутагдах, улмаар төлбөрийн тэнцлийн хямралаас шалтгаалж эдийн засагт үүссэн хүндрэл ужиграх эрсдэлтэй гэж үзэж байна.

Эдийн засгийн өсөлтийн ойрын төлвийг нийт эрэлт болон үйлдвэрлэлийн салбараар авч үзвэл өрхийн болон Засгийн газрын хэрэглээ, гадаад болон дотоод хөрөнгө оруулалт буурахаар байгаатай уялдан дотоод эрэлт, нийт хуримтлал багасах хүлээлттэй байгаа тул ДНБ-ий бодит өсөлт 2014 оны эцэст өмнөх оноос буурч гарахаар хүлээгдэж байна. Хэрэв ирэх онд төлбөрийн тэнцэл сайжрахгүй, мөнгөний нийлүүлэлтийн бүтэц дэх гадаад цэвэр актив огцом нэмэгдэхгүй, хэрэглээ, хөрөнгө оруулалт буурч байгаа хандлага үргэлжлэх тохиолдолд нийт эрэлтийг тэтгэх, хөрөнгө оруулалтыг нөхөх гол бүрэлдэхүүн нь цэвэр экспорт л байх төлөвтэй болов.

АНУ-ын эдийн засгийн төлөв 2014 оны эхний хагаст хүлээгдэж байснаас илүү хурдан сайжирч, эерэг үр дүн гарч эхэлж байгаа нь бусад орны эдийн засагт эерэгээр нөлөөлөх төлөвтэй байна. Холбооны нөөцийн банкнаас (ХНБ) эдийн засгаа дэмжих QE3 хөтөлбөрийг аажмаар бууруулж, энэ оны 10 дугаар сард бүрэн зогсоох хэдий ч, бодлогын хүүг 2014 онд өөрчлөхгүй төлөвтэй байна. Манай улсын гадаад худалдааны гол түнш Хятадын эдийн засгийн өсөлт 7 хувь болж буурсан хэдий ч, энэхүү өсөлтийг тогтвортой хэмээн үзэж байгаа бөгөөд АНУ-ын эдийн засгийн сэргэлтээр тэжээгдэх боломжтой гэж үзэж байна. Гэхдээ тус улсын эдийн засгийн дотоод эрсдэлээс шалтгаалан эдийн засгийн өсөлт буурах магадлал байгааг шинжээчид дурдаж байна. Мөн Хятадын үл хөдлөх хөрөнгийн салбарын идэвхжил буурснаас шалтгаалж дотоодын хөрөнгө оруулалт саарсан, банкны зээлийн чанар муудаж байгаа болон орон нутгийн засаг, захиргааны гаргасан бондын санхүүжилт зэрэг нь олон улсын худалдаа болон түүхий эдийн үнэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй гэж үзэж байгаа юм. Хятад улс санхүүгийн зах зээлээ чөлөөлж, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэн, үргүй зардлыг бууруулах, экспортоос дотоодын хэрэглээг урамшуулахад шилжих замаар эдийн засгийн өсөлтийн загвараа өөрчилж байгаатай уялдан аж үйлдвэрлэлийн өсөлт нь саарч, ДНБ-ий бодит өсөлт нь 2015-2016 онд 7 орчим хувь байхаар төсөөлөгдөж байна. Үүнтэй холбоотойгоор манай улсын гол экспортын бүтээгдэхүүнүүдийн үнэ өсөхгүй байх, улмаар буурах, ингэснээр гадаад худалдааны нөхцөл төдийлөн сайжрахгүй байх эрсдэл ажиглагдаж байгаа юм. Тухайлбал, зэсийн үнэ өмнөх оноос буурч оны эцэст 6800-6850\$/тн-д, алтны үнэ 2014 оныг дуустал 1255\$/унц-д, нүүрсний үнэ 2014 онд 15%-иар тус тус буурахаар шинжээчид төсөөлж байна. Үндсэндээ (i) АНУ 2015 оноос мөнгөний бодлогоо чангатгах төлөвтэй байгаа, (ii) манай орны экспортын гол зах зээл болох БНХАУ-ын эдийн засгийн өсөлт удааширч байгаа зэргээс үзэхэд 2015 онд экспортын түүхий эдийн гадаад эрэлт мэдэгдэхүйц сайжрах боломж бага гэж үзэж байна.

Макро эдийн засгийн гадаад тэнцвэргүй байдал 2015 онд үргэлжилбэл татварын орлогын тасалдлаар дамжин улсын нэгдсэн төсөв хүндэрч болзошгүй. Төсөвтэй

адилтгах хөрөнгө оруулалтын зарцуулалт нь 2013 онд гадаад цэвэр активын огцом бууралтын эдийн засаг дахь сөрөг нөлөөг саармагжуулахад зарим эерэг нөлөө үзүүлсэн. Гэвч цаашид гадаад валютын орох урсгал, төлбөрийн тэнцлийг сайжруулалгүйгээр улсын төсвийг тэлэх, төсөвтэй адилтгах зарцуулалтыг үргэлжлүүлэх нь урсгал тэнцлийн алдагдлыг нэмэгдүүлэх, төлбөрийн тэнцлийн хүндрэлийг даамжруулах, макро эдийн засгийн гадаад тэнцвэрийг алдагдуулах, улмаар дотоод тэнцвэрт сөргөөр нөлөөлж инфляцийг өсгөх, санхүүгийн системийн тогтвортой байдалд эрсдэл учруулах, улсын зээлжих зэрэглэлийг бууруулах зэрэг эрсдэл дагуулж болзошгүй байна.

Ирэх оны макро эдийн засгийн төлөв нь УИХ-ын 2014 оны 34 дүгээр тогтоолын хэрэгжилт, түүний дотор эдийн засагт үлэмж нөлөө бүхий том төслүүд, хөгжлийн санхүүжилтийн боломж, гадаад валютын орох урсгал, төлбөрийн тэнцлийг сайжруулах арга хэмжээний үр дүн, хөрш орнуудын айлчлалын хүрээнд хэрэгжих гэрээ хэлцлүүд, Япон улстай байгуулах Эдийн засгийн түншлэлийн гэрээ, түүний нөлөөлөл зэргээс ихээхэн хамаарахаар байна.

Өмнө дурдсан эрсдэлүүдээс урьдчилан сэргийлэх, санхүүгийн болон макро эдийн засгийн тогтвортой байдлыг алдагдуулахгүй байлгах, эдийн засгийг хүндрэлээс гаргаж сэргээхийн тулд бодлогын дараах арга хэмжээг хэрэгжүүлэх нь туйлын чухал болоод байна:

- (i) Засгийн газар экспортын орлого, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар гадаад валютын орох урсгал, төлбөрийн тэнцлийг эрс сайжруулж, нэгдсэн төсвийн зохистой бодлого хэрэгжүүлэн, төсвийн тогтвортой байдлыг тууштай хангах,
- (ii) Монголбанк дунд хугацаанд инфляцийг нам, тогтвортой түвшинд байлгаж, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэн дархлааг нь сайжруулах.

Эдгээр цогц арга хэмжээний үр дүнд макро эдийн засгийн гадаад, дотоод тэнцвэр хангагдаж, эдийн засаг дунд, урт хугацаанд тэнцвэртэй бөгөөд тогтвортой өсөх орчин бүрдэнэ.

1. МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

1.1 Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг 2015 оны эцэст 7 хувьд, 2016-2017 онд энэ түвшинд тогтворжуулсны үндсэн дээр иргэдийн бодит орлогыг хамгаалж, эдийн засаг тогтвортой өсөх нөхцөлийг бүрдүүлнэ.

Төв банк инфляцийг нам, тогтвортой түвшинд байлгах замаар иргэдийн бодит орлогыг хамгаалах, хөрөнгө оруулалт болон зохистой хэрэглээг дэмжих, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, эдийн засгийн тогтвортой өсөлтийн орчинг бүрдүүлэхийг зорьж байна. Инфляцийг бууруулж, нам түвшинд тогтворжуулах нь эдийн засаг дахь тодорхой бус байдлыг багасгаж, нөөцийн үр ашигтай хуваарилалтыг дэмжинэ.

Сүүлийн 2 жил орчмын хугацаанд гадаадын шууд хөрөнгө оруулалт, гадаад цэвэр

актив тасралтгүй буурч, төсөвтэй адилтгах зарцуулалтууд дорвитой буурахгүй байгаа орчинд Монголбанк төлбөрийн тэнцлийн хүндрэлийг зөөлрүүлэх, санхүүгийн тогтвортой байдлыг үргэлжлүүлэн хадгалах зорилгоор 2015 онд инфляцийг 7 хувьд, цаашид энэ түвшинд нь тогтворжуулах зорилт тавьж байна.

2014 оны 8 дугаар сарын эцэст улсын инфляци жилийн 13.7%, Улаанбаатар хотын инфляци 13.6%-д хүрээд байгаа нь энэ оны зорилтот түвшнээс өндөр байна. Иргэдийн нэрлэсэн цалин оны эхний хагаст өмнөх оны мөн үеэс 8 орчим хувиар өссөн хэдий ч, инфляцийн түвшнээс бага байгаа нь бодит цалингийн өсөлт он гарсаар сөрөг⁴ болоход нөлөөлөв. Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах хөтөлбөрийн нөлөөгөөр инфляци 2013 оны эхнээс 7 дугаар сарыг дуустал хугацаанд тасралтгүй буурч байсан ч, нэг талаас гадаад валютын орох урсгал, гадаад цэвэр актив тасралтгүй буурч, төлбөрийн тэнцлийн хүндрэл ужгирсан, нөгөө талаас төсөвтэй адилтгах зарцуулалт зэрэг эрэлтийн хүчин зүйлээс шалтгаалж улсын хэмжээнд жилийн инфляци 2013 оны 10 дугаар сараас 2014 оны 8 дугаар сарыг дуустал хугацаанд 10.8-14.9 хооронд хэлбэлзэж байв. Ялангуяа төлбөрийн тэнцлийн хүндрэлээс шалтгаалж импортын барааны үнэ өссөний зэрэгцээ төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээний үнэ нэмэгдсэн нь суурь инфляци⁵-ийн түвшин 2014 оны эхнээс өндөр байх, улмаар иргэдийн бодит орлогын өсөлтийг сааруулахад нөлөөлөв. Түүнчлэн, импортын хэрэглээ огцом бус, алгуур саарч байгаа нөхцөлд импортын бараа, үйлчилгээний үнэ инфляцид нөлөөлж байна.

Гадаад валютын орох урсгал нэмэгдэхгүй, гадаад цэвэр актив буурсаар буй орчинд мөнгөний нийлүүлэлтийг огцом тэлэхээс зайлсхийж, мөнгөний бодлогыг төсвийн болон макро зохистой бодлоготой уялдуулах замаар төлбөрийн тэнцлийн хүндрэлийг зөөлрүүлэх, инфляцийг тогтворжуулснаар иргэдийн бодит орлогыг хамгаалах, макро эдийн засгийн гадаад, дотоод тэнцвэрийг дэмжиж, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хадгалах нь 2015 оны хувьд эн тэргүүний зорилт гэж Монголбанк үзэж байна.

Сүүлийн жилүүдэд инфляцийн түвшин тогтмол хоёр оронтой тоогоор илэрхийлэгдсээр ирсэн нь нийлүүлэлтийн буюу зардлын шалтгаантай хүчин зүйлс, тэр дундаа хүнс, шатахууны нийлүүлэлтийн тасалдал, дэд бүтцийн саад, хязгаарлалттай шууд холбоотой байв. Эдгээр асуудлуудыг шийдвэрлээгүй, бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт, хангамжийн зах зээлийн зарчимд суурилсан тогтвортой тогтолцоог бүрдүүлээгүй тохиолдолд инфляцийг бууруулж, нам түвшинд тогтворжуулах боломж туйлын хомс, цаашлаад эдийн засгийн тэнцвэртэй бөгөөд тогтвортой өсөлтийн орчинг бүрдүүлэх боломжгүй байв. Иймд өнгөрсөн 2 жилд Монголбанк мөнгөний бодлогын уламжлалт болон уламжлалт бус арга хэрэгслүүдийг ашигласнаар нийлүүлэлтийн гаралтай инфляцийн дарамтыг эрс буурууллаа. Энэ хүрээнд Монголбанк “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөр”-ийг Засгийн газартай хамтран хэрэгжүүлсний үр дүнд хөтөлбөрт хамрагдах барааны үнийн өсөлтийн инфляцид үзүүлэх шууд нөлөөллийг 2010-2012 оны дунджаас 5.5 дахин бууруулаад байна. Түүнчлэн, үнийн савалгаа, хэлбэлзэл ихтэй байдаг байсан махны үнэ хөтөлбөр хэрэгжсэн 2013 онд 10.5 хувиар, 2014 оны эхний хагаст 6.8 хувиар өссөн нь 2010-2012 оны махны үнийн жилийн дундаж өсөлтөөс харгалзан 3.0 болон 4.6 дахин бага болж буурчээ.

Энэхүү дунд хугацааны хөтөлбөр нь иргэдийн суурь хэрэглээний бүтээгдэхүүн болох

⁴ Бодит цалингийн өсөлт 6 дугаар сарын эцэст -5% байна.

⁵ Суурь бараа, үйлчилгээний үнэ гэдэгт суурь инфляци буюу үнэ нь өндөр хэлбэлзэлтэй мах, сүү болон бусад хүнсний бараа, нийтдээ 29 ширхэг барааг ХҮИ-ээс хасч тооцсон инфляцийг ойлгоно.

шатахуун, мах, гурилын жижиглэнгийн худалдааны үнийн өсөлтийг тогтворжуулах замаар инфляцийг бууруулах, мөн дунд хугацаанд зах зээлийн зарчим, хувийн хэвшилд суурилсан агуулахын санхүүжилтийн тогтвортой тогтолцоог шинээр бий болгоход чиглэсэн бөгөөд хэрэглээний суурь бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн байнгын тогтолцоог бүрдүүлэхэд зохих хувь нэмрээ оруулав. Уг хөтөлбөрт тусгагдсанаар Монголбанк анхнаасаа хөтөлбөрт байнга оролцох бус харин түлхэц өгөх, эхлүүлэх байдлаар оролцож байна. Цаашид хөтөлбөрүүдийг зах зээлийн зарчимд суурилсан хэлбэрт шилжүүлэх хүрээнд Монголбанк 2014 оны эхнээс оролцоогоо багасгах, өмчлөлийг нь Засгийн газарт шилжүүлэх шат дараатай арга хэмжээ авч ажиллаж байна.

Гадаад валютын орох урсгал 2014 он гарсаар нэмэгдээгүй тул төлбөрийн нийт тэнцэл сайжраагүй, түүнчлэн төсөвтэй адилтгах хөрөнгө оруулалтын зарцуулалт өндөр хэвээр байсан нь суурь инфляцийн өсөлтөөр дамжин ХҮИ-ээр илэрхийлэгдэх инфляцийг өсгөх эрсдэлийг бий болгосон. Иймд гадаад валютын орох урсгал, гадаад цэвэр актив тасралтгүй буурч, төлбөрийн тэнцэл сайжрахгүй байгаа өнөөгийн нөхцөлд Монголбанк орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөрөөс бусад хөтөлбөрийн зээлийг бууруулах замаар тэдгээр хөтөлбөрөөс үе шаттай гарах зарчим баримталж байна.

Инфляцийг нам, тогтвортой түвшинд байлгах нь санхүүгийн тогтвортой байдалд онцгой ач холбогдолтой билээ. Ялангуяа төлбөрийн тэнцлийн хүндрэлтэй байгаа өнөөгийн орчинд макро эдийн засгийн зохистой бодлогыг мөнгөний бодлогын арга хэрэгсэлтэй нягт уялдуулах замаар эдийн засгийн дотоод, гадаад тэнцвэртэй орчинг бүрдүүлэх нь туйлын чухал байна. Үнийн тогтвортой байдал нь санхүүгийн салбар, түүний дотор банкны систем дэх иргэд аж, ахуй нэгжийн хуримтлал тогтвортой өсөн нэмэгдэхэд нөлөөлж, санхүүгийн салбарын найдвартай, аюулгүй байдалд чухал үүрэг гүйцэтгэдэг билээ. Монголбанк эрсдэлд суурилсан макро зохистой бодлогын арга хэрэгслийг мөнгөний бодлоготой нягт уялдуулснаар зээлийн идэвхжилийг сэргээх, санхүүгийн салбарт эрсдэл хуримтлагдахаас сэргийлэх, уг салбарын дэд бүтцийг хөгжүүлэхэд анхаарч ажиллана. Ялангуяа валютын зээлийн эрсдэлийг бууруулах, зээлийн төвлөрлийг сааруулах, зээлийн багцын чанарыг сайжруулах, банкуудын валютын ханшийн эрсдэлийг удирдах чадавхийг бэхжүүлэхэд макро болон микро зохистой бодлогын арга хэмжээг чиглүүлнэ.

Эдийн засгийн мөчлөгийг сөрөх мөнгөний болон макро зохистой бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх нь ирээдүйд учирч болзошгүй эдийн засгийн тогтворгүй байдлын эрсдэлээс сэргийлэхэд туйлын чухал юм.

Монголбанк санхүүгийн бүтээгдэхүүнүүдийг илүү боловсронгуй болгож, тэдгээрийн зах зээл дэх хэрэглээг нь нэмэгдүүлэх замаар зах зээлд оролцогчдын валютын ханшийн болон хүүгийн эрсдэлээ удирдах боломжийг сайжруулна. Мөн банкны салбарын төлбөрийн чадварыг хамгаалах, системийн хяналт шалгалт, зохистой харьцааны дүрэм, журмыг сайжруулах, банкны салбарт учирч болзошгүй эрсдэлээс сэргийлэх замаар ард иргэдийн санхүүгийн салбарт итгэх итгэлийг хадгалахад онцгой анхаарч ажиллана.

Орон сууцны ипотекийн санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бүрдүүлж, дундаж давхаргын хуримтлалыг тууштай нэмэгдүүлэх замаар дотоодын зээл, хуримтлал, хөрөнгө оруулалтыг урамшуулж, эдийн засгийн дархлааг сайжруулах бодлогоо Монголбанкнаас Засгийн газар, банкууд, МИК-тай хамтран үргэлжлүүлэх болно.

Монголбанк макро эдийн засгийн ирээдүйн төлөвт суурилан, ирээдүйд чиглэсэн

мөнгөний бодлогыг хэрэгжүүлж хэвших, инфляцийн зорилтыг хангах замаар инфляцийн хүлээлтийг төлөвшүүлэхэд онцгойлон анхаарч ажиллаж байна. Энэ хүрээнд Монголбанк ЕСБХБ-ны техник туслалцаатайгаар Чех улсын OGRsearch байгууллагатай хамтран “Төсөөлөл бодлогын шинжилгээний систем (FPAS)”-ийг хөгжүүлэн ажиллаж байна. Энэхүү улирлын төсөөллийн загвар нь микро эдийн засгийн үндсэн шинж чанаруудыг агуулахын сацуу хүлээлтийг хамруулдаг нь ирээдүйд чиглэсэн эдийн засгийн бодлогын шинжилгээнд чухал ач холбогдолтой. Үүний зэрэгцээ бодлогын шийдвэр гаргалтыг сайжруулах, эдийн засгийн мөчлөгийн учир шалтгаан, бүтцийн шинж чанартай бодлогын өөрчлөлтүүдийн эдийн засагт үзүүлэх дунд, урт хугацааны нөлөөг илүү өргөн хүрээтэй шинжилж боловсруулах, үр дүнг мөнгөний бодлогын шийдвэрт ашиглах зорилгоор Азийн хөгжлийн банкны техник туслалцаатайгаар DSGE загварыг Төв банкин дээр хөгжүүлж байгаа бөгөөд үүнтэй уялдан мөнгөний бодлого боловсруулах болон бодлогын шийдвэр гаргах үйл ажиллагаа улам сайжрах нөхцөл бүрдэх юм.

Монголбанк гадаад, дотоод хүчин зүйлсийн инфляци, эдийн засгийн өсөлт, төлбөрийн тэнцэлд үзүүлэх нөлөөллийг анхааралтай ажиглан, инфляцийг зорилтот түвшинд хүргэх замаар эдийн засгийн тэнцвэртэй бөгөөд тогтвортой өсөлтөд дэмжлэг үзүүлэх мөнгөний бодлогыг хэрэгжүүлнэ. Гэхдээ энэхүү бодлого нь нэгдсэн төсвийн зохистой бодлого, макро зохистой бодлоготой уялдаж байж илүү үр дүнтэй хэрэгжихийг Монголбанк онцлон тэмдэглэж байна.

1.2 Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь санхүүгийн болон макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эдийн засгийн гадаад тэнцвэрийг дэмжихүйц уян хатан тогтож, дунд хугацаанд дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, ажлын байрыг хамгаалахтай нийцтэй байх зарчим баримтална.

2013-2014 онд экспортын голлох бүтээгдэхүүний эрэлт, гадаад худалдааны нөхцөл муудаж, гадаадын шууд хөрөнгө оруулалт огцом буурснаар валютын орох урсгал эрс татарлаа. Үүнээс шалтгаалан эдийн засагт төлбөрийн тэнцлийн хүндрэл үүсч, төгрөгийн гадаад валюттай харьцах ханш сулрах дарамттай байв.

Ийм орчинд Монголбанкнаас төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцтэйгээр уян хатан тогтох зарчмыг баримталж, гадаад худалдаанд шаардлагатай тохиргоо хийгдэх нөхцөлийг бүрдүүлсэн. Үүний үр дүнд удаан эдэлгээтэй хэрэглээний бараа, бүтээгдэхүүний импорт энэ оны 7 дугаар сарын байдлаар 13 хувиар, түүний дотор автомашины импорт 21 хувиар, гэр ахуйн цахилгаан хэрэгсэл, тавилгын импорт 6 хувиар тус тус буурлаа. Түүнчлэн экспортын болон дотоодын үйлдвэрлэлийн өрсөлдөх чадвар нэмэгдэх, дунд хугацаанд ажлын байрыг хамгаалах орчин бүрдэж байна.

Монголбанк банкуудын гадаад зах зээлээс урт хугацаатай эх үүсвэр татах үйл ажиллагааг урамшуулах зорилгоор гурав болон түүнээс дээш жилийн хугацаатай бонд болон зээлийн эх үүсвэрийг заавал байлгах нөөцийн шаардлагаас чөлөөлж, нэг жилээс дээш хугацаатай гадаад валютын эх үүсвэрт урт хугацаатай своп хэлцэл хийх замаар ханшийн эрсдэлийг бууруулж байна. Мөн хувийн хэвшилд валютын ханш, зах зээлийн өөрчлөлтөд дасан зохицох, эрсдэлээ удирдах боломжийг олгох зорилгоор ханшийн хэт хэлбэлзэл, валютын хомсдол үүссэн үед валютын захад тогтмол оролцож, эдийн засаг, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг дэмжиж ажиллалаа.

Цаашид гадаадын шууд хөрөнгө оруулалт, экспортын голлох бүтээгдэхүүний эрэлт, валютын орох урсгал сайжрахгүй тохиолдолд 2014-2015 онд төлбөрийн тэнцлийн хүндрэл үргэлжилж, гадаад валютын улсын нөөцөд учрах дарамт өсч, эдийн засгийн эмзэг байдал нэмэгдэх, улмаар улсын зээлжих зэрэглэлд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй байхаар байна.

Иймд Монголбанкнаас 2015 онд макро эдийн засгийн гадаад тэнцвэртэй байдлыг хангах орчинг бүрдүүлэхийн тулд төгрөгийн гадаад валюттай харьцах ханш макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцтэйгээр уян хатан тогтох зарчмыг үргэлжлүүлэн баримтлах бөгөөд ингэснээр дунд, урт хугацаанд экспортыг урамшуулах, дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, ажлын байрыг хамгаалах, хөрөнгө оруулалт болон төлбөрийн тэнцэл сайжрах эерэг орчинг бүрдүүлэх, гадаад валютын улсын нөөцийг хамгаалах, эдийн засгийн дунд, урт хугацааны тогтвортой өсөлтөд дэмжлэг үзүүлнэ.

Хэдийгээр ханш уян хатан тогтох боловч зах зээлд ханшийн огцом хэлбэлзэл, валютын хомсдол үүсч, гадаад валютаар төлбөр түргэн гүйцэтгэх чадварт сөргөөр нөлөөлөх эрсдэл үүссэн тохиолдолд Монголбанк эдийн засаг, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах зорилгоор валютын захад шаардлагатай тухай бүр оролцоно. Ингэснээр иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад ханшийн эрсдэлээ удирдан бууруулах, үйл ажиллагаагаа зохистойгоор төлөвлөх боломж олгож, зээлийн чанар муудах эрсдэлийг багасгах эерэг нөлөөтэй байх болно.

Монголбанк нь ханшийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бий болгох зорилгоор зах зээлд оролцогчдын мэдлэгийг нэмэгдүүлэх чиглэлд “Валютын зээл хүссэн иргэд, аж ахуйн нэгжүүдэд ханшийн эрсдэлийг санхүүгийн үүсмэл хэрэгсэл ашиглан бууруулах зөвлөмж”, “Валютын зээл хүсэгчдэд зориулсан гарын авлага”-ыг банкуудаар дамжуулан тэдгээрийн харилцагчдад хүргүүлсэн. Цаашид ханшийн эрсдэлийг бууруулахын тулд санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийг макро зохистой бодлоготой уялдаатайгаар үр дүнтэй хэрэгжүүлэх болно.

2. БАНКНЫ САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД:

2.1 Банкуудын төлбөрийн чадварыг хадгалах хүрээнд өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх замаар системийн болзошгүй эрсдэлээс хамгаалах чадварыг нэмэгдүүлж, санхүүгийн салбарын дархлааг сайжруулна.

Монголбанк банкуудад тавигдах зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд, хувь нийлүүлсэн хөрөнгийн шаардлагыг олгож буй зээлийн өсөлттэй нь уялдуулан⁶ шат дараатайгаар нэмэгдүүлсний үр дүнд системийн төлбөрийн чадварын үзүүлэлтүүд тогтворжиж байгаа бөгөөд уг шаардлагуудыг цаашид ч эдийн засгийн нөхцөл байдал, банкуудын эрсдэлийн түвшинд үндэслэн өөрчлөх арга хэмжээг үргэлжлүүлж, банкуудын эрсдэл даах чадварыг нэмэгдүүлнэ. Банкны системийн тогтвортой байдлыг хангах, активын өсөлтийг өөрийн хөрөнгөтэй нийцүүлэх хүрээнд банкуудын өөрийн хөрөнгийн зохистой харьцааны үзүүлэлтүүд болон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг шат дараатайгаар нэмэгдүүлэх талаар судалж, зохих арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

⁶ 2014 оны 2 дугаар улирлын байдлаар банкны системийн нийт цэвэр зээл болон нийт өөрийн хөрөнгө нь өмнөх оны мөн үеэс харгалзан 42.3 хувь болон 41.6 хувиар тус тус өссөн байна.

Банкны зээл, бусад актив хөрөнгийг ангилах стандарт, тооцох аргачлалыг боловсронгуй болгох ажлыг үргэлжлүүлэх, активыг эрсдэлээр жигнэхдээ банкны ерөнхий эрсдэлийн түвшинд нийцүүлэх зэрэг хяналт шалгалтын эрх зүйн орчинг сайжруулах болно.

Гадаад валютын ханшийн хэлбэлзэл болон бусад төрлийн эрсдэлүүдээс шалтгаалан зээлийн чанар муудахаас сэргийлэх, банкуудын зээлийн багц эдгээр эрсдэлд өртөмтгий эдийн засгийн салбаруудад голчлон төвлөрөх үзэгдлийг бууруулах зорилгоор банкуудын үйл ажиллагаа, удирдлага зохион байгуулалтын онцлогтой нь уялдсан эрсдэлийн удирдлагыг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Санхүүгийн нэгдэл хэлбэрээр зохион байгуулагдсан банкинд учрах эрсдэл нь дангаар үйл ажиллагаа явуулж буй банкнаас өндөр байдаг тул Монголбанкнаас бусад эрх бүхий байгууллагуудтай хамтран санхүүгийн нэгдэлд хийх хяналт шалгалтын аргачлалыг нэвтрүүлэх, шаардлагатай тохиолдолд банкны тухай хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах ажлыг эхлүүлнэ.

Монголбанкны зээлийн мэдээллийн санд төвлөрөх мэдээллийн бүтцийг системийн болон гишүүн байгууллага тус бүрийн хувьд үүсэх зээлийн эрсдэлийг үнэлэх боломжтой байхаар өөрчилж, төвлөрүүлэх ажлыг эхлүүлнэ. Ингэснээр банкуудын зээлийн эрсдэлийг зохистой, оновчтойгоор үнэлэх боломж бүрдэхээс гадна цаашид Базел стандартын зээлийн эрсдэлийг тооцох дотоод үнэлгээний суурь аргачлалд шаардагдах үзүүлэлтүүд болох зээлийн төлбөр төлөгдөхгүй байх магадлал⁷ (PD-Probability of default), чанаргүй зээлээс хүлээх алдагдал (LGD-loss given default), чанаргүй активын эргэн төлөлтөөс орох орлого болон нийт хүлээгдэж байгаа алдагдал (EL-Expected loss)-ыг тооцох, банкууд зээлийн эрсдэлээ ахисан түвшинд үнэлэх боломжийг бүрдүүлэх юм.

2.2 Олон улсад мөрдөгдөж байгаа хяналт шалгалтын зарчим, зохицуулалтын арга хэрэгслийг банкны салбарын үйл ажиллагааны онцлогтой уялдуулан эрсдэлийн үнэлгээнд суурилсан хяналт шалгалтыг үргэлжлүүлнэ.

Монголбанкнаас хяналт шалгалтын чиглэлээр 2013-2019 онд хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийг боловсруулсан бөгөөд уг баримт бичигт тусгасан ажлын төлөвлөгөөний дагуу санхүүгийн байгууллагуудад хийх хяналт шалгалтын үндсэн зарчмууд, өөрийн хөрөнгө болон бусад зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдэд тавигдах нэгдсэн стандартыг шат дараатайгаар нэвтрүүлэх ажлыг үргэлжлүүлнэ.

Олон улсад түгээмэл мөрдөгддөг Базелийн цуврал стандартад заасан зохистой харьцаа, ерөнхий эрсдэлийг тооцох тоон үнэлгээний аргачлалыг нэвтрүүлж банкуудад мөрдүүлж ирсэн бөгөөд цаашид уг стандартад тусгасан тоон үнэлгээгээр үнэлэхэд хүндрэлтэй бусад төрлийн эрсдэлийг тооцох чанарын үнэлгээний аргачлал (pillar II, III)-ыг судалж, банкуудад мөрдүүлэх ажлыг хэрэгжүүлэх болно.

Банкуудад хэрэгжүүлж буй одоогийн хяналт шалгалтын аргачлал нь голдуу гүйцэтгэлд суурилсан буюу хууль тогтоомж, заавар, журмын биелэлтэнд (compliance-

⁷ Банкууд PD-ээ өөрсдөө тооцох бөгөөд Монголбанкнаас тооцох үзүүлэлтийг банкны үзүүлэлттэй харьцуулах зорилгоор давхар үнэлж болох юм.

based supervision) тулгуурлаж, өнгөрсөн хугацаанд банкуудын үйл ажиллагаанд бодитоор бий болсон эрсдэлүүдийг нээн илрүүлэхэд чиглэгдэж байлаа. Энэхүү аргачлалыг банкуудын ирээдүйд хүлээж болзошгүй эрсдэл, хохирлыг урьдчилан тооцох буюу эрсдэлд суурилсан аргачлалтай хослуулах замаар хяналт шалгалтын үйл ажиллагааны арга барилыг сайжруулна.

Шинэчлэн боловсруулсан банкны зохистой засаглалын үндсэн зарчмуудын хэрэгжилтийг хангах, турших ажлыг эхлүүлж, үнэлгээний үнэн зөв байдлыг Монголбанкнаас банкуудад хийх хяналт шалгалтаар давхар баталгаажуулна. Түүнчлэн зохистой засаглалын зарчмуудыг байгууллагын бүх түвшинд түгээн дэлгэрүүлж, хэрэгжилтийг ханган ажиллах талаар банкуудад үүрэг өгч ажиллах юм.

Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон хяналт шалгалтын стандартуудтай нийцсэн “Банкны нягтлан бодох бүртгэлийн багц материал”-ын дагуу бэлтгэх санхүүгийн тайлан болон бусад төрлийн мэдээллийг нэг эх сурвалжид төвлөрүүлсэн нээлттэй удирдлагын мэдээллийн системийг нэвтрүүлэх, туршилт хийж суурилуулах ажлыг эхлүүлнэ. Ингэснээр санхүүгийн байгууллагуудын мэдээллийг нэгдсэн стандарт хэлбэрээр төвлөрүүлэх, боловсруулах, судалгаа хийх, мэдээллийн төвлөрсөн баазыг бий болгох, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах боломж бүрдэх юм.

2.3 Банкны үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг төрөлжүүлэн олгох хууль эрх зүйн орчинг сайжруулах боломжийг судалж, дотоод, гадаадын эрх бүхий байгууллагуудтай хамтран үр нөлөөтэй хяналт шалгалтыг боловсронгуй болгох чиглэлд ажиллана.

Банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг үйл ажиллагааны чиглэл, цар хүрээний хувьд төрөлжүүлэн олгох боломжийг судалж, эрх зүйн орчинг боловсронгуй болгох ажлыг эхлүүлнэ. Ялангуяа, банк, түүний хараат болон охин компанийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход тавигдах шаардлага, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдэд тавигдах шалгуур болон санхүүгийн үйл ажиллагааны хязгаарлалтыг нийтлэг болон төрөлжсөн банкны хувьд дотоодын санхүүгийн зах зээл дэх гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлэх боломжтой уялдуулан ялгаатайгаар тогтоох нөхцөлийг Санхүүгийн зохицуулах хороотой хамтран судалж, бүрдүүлэх ажлыг эхлүүлнэ.

Монголбанкнаас гадаадын санхүүгийн хяналт шалгалтын эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллах, хяналт шалгалтын үр нөлөөтэй аргачлалыг хэрэгжүүлэх, боловсронгуй болгох, шалгалтад хамрагдаж буй байгууллагуудын талаар мэдээлэл солилцох, хянан шалгагчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлж, харилцан туршлага солилцох (supervisory college) чиглэлээр хамтын ажиллагааг идэвхжүүлэх болно.

3. САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ДЭД БҮТЭЦ, ТҮҮНИЙ ИНСТИТУЦИЙГ БЭХЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД:

3.1 Монгол Улсын төлбөр тооцооны системийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хангаж, дэвшилтэт технологид суурилсан банкны шинэлэг үйлчилгээг олон нийтэд хүртээмжтэй болгох чиглэлээр ажиллана.

Монгол Улсын эдийн засаг, санхүүгийн зах зээлийн өсөлттэй холбоотойгоор төлбөр тооцооны системээр дамжин хийгдэж буй банк хоорондын гүйлгээний тоо жилээс жилд өсөн нэмэгдэж байна.

Төлбөрийн системийн оролцогч хооронд 2014 оны эхний хагас жилийн байдлаар 28.3 их наяд төгрөгийн 9.6 сая ширхэг гүйлгээ хийгдсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс гүйлгээний дүн 12.8 хувиар буюу 6 их наяд төгрөгөөр, гүйлгээний тоо 30 хувиар буюу 1.1 сая ширхэгээр өссөн үзүүлэлттэй байна. Төлбөрийн картаар 2014 оны эхний хагас жилд нийт 717.7 тэрбум төгрөгийн, 14.4 сая ширхэг гүйлгээ хийгдэж, өмнөх оны мөн үеийнхээс картын гүйлгээний дүн 206 тэрбум төгрөг буюу 40.3 хувиар, картын гүйлгээний тоо 3.7 сая ширхэг буюу 34.6 хувиар тус тус өсчээ.

Одоогийн банк хоорондын бага дүнтэй гүйлгээний дэд бүтцийг ашиглаж, банкуудын дэвшилтэт технологид суурилсан шинэлэг үйлчилгээг олон нийтэд хүртээмжтэй болгон, аливаа төлбөрийн сувгаар төлбөр гүйцэтгэх боломжоор хангах замаар банкны үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. Тухайлбал, төрийн үйлчилгээний байгууллагуудын цахим нэхэмжлэлийн нэгдсэн санг байгуулж, татвар, торгууль, даатгалын хураамжийг аль ч банкны салбар, интернет, мобайл банкны үйлчилгээг ашиглаж төлөх боломжийг бүрдүүлнэ.

Иймд, эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих, мөнгөний эргэлтийг хурдасгах, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад төлбөр тооцооны системийн найдвартай, тасралтгүй ажиллагаа нэн чухал юм.

3.2 Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн банкны зах зээлд оролцогчдын эрх ашгийг хамгаалах, олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх цогц арга хэмжээг эрчимжүүлнэ.

Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор банк, санхүүгийн байгууллагаас үзүүлж буй үйлчилгээг олон талт байдлаар иргэдэд хүргэх, гарах эрсдэлийг бууруулах, санхүүгийн үйлчилгээний эрэлтийг тодорхойлж, түүнтэй уялдуулж нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, төрийн болон хувийн хэвшлийн оролцоог тодорхой болгох талаар судалгаа хийж, хэрэгжүүлэх боломжийг тодорхойлно.

Түүнчлэн, иргэдийн санхүүгийн салбарын талаарх мэдлэгийг дээшлүүлж, санхүүгийн оновчтой шийдвэр гаргах чадварыг бүрдүүлэх, санхүүгийн сахилга батыг сайжруулах, санхүүгийн салбарт итгэх иргэдийн итгэлийг бэхжүүлэх чиглэлд хийгдэж буй арга хэмжээг үргэлжлүүлэх болно. Энэ хүрээнд төр захиргааны байгууллагуудтай хамтран иргэдийн боловсролын түвшинтэй уялдсан “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийг боловсруулах ажлыг 2014 онд эхлүүлсэн бөгөөд бусад орны туршлагад үндэслэн өөрийн орны зах зээлийн нөхцөлд тохирсон хөтөлбөрийг боловсруулж, цогц байдлаар хэрэгжүүлэх болно.

3.3 Мөнгөний бодлогын шийдвэр гаргах үйл ажиллагааг улам боловсронгуй болгон, мөнгөний бодлогын үндсэн зорилт, хэрэгжилтийг олон нийтэд тогтмол тайлагнах ажлыг үргэлжлүүлж, Төв банкны нээлттэй, ил тод байдлыг хадгална.

Орчин үеийн Төв банкны салшгүй хэсэг нь олон нийттэй харилцах харилцаа, нээлттэй ил тод байдал билээ. Төв банкнаас эдийн засгийн нөхцөл байдлыг үнэлэн, бодлогын арга хэмжээнүүдийг тайлбарлах нь мөнгөний бодлогын үндэслэл, хариу үйлдлийг зөв ойлгох боломж төдийгүй Монголбанкны мөнгөний бодлогыг дунд хугацаанд таамаглагдахуйц болгох ач холбогдолтой. Монголбанкнаас өнгөрсөн жилүүдэд мөнгөний бодлогын зорилт, шилжих механизм, шийдвэр гаргах явц, мөнгөний бодлогын шийдвэрийн ил тод байдлыг эрс нэмэгдүүлж, олон нийтэд тогтмол тайлагнаж ажиллалаа.

2015 онд мөнгөний бодлогын шийдвэр гаргах үйл ажиллагааг улам боловсронгуй болгохын тулд Төв банкны тухай хуульд өөрчлөлт оруулах, Монголбанкны үйл ажиллагааны ил тод байдлыг хангах хүрээнд бодлогын хэрэгжилтийг олон нийтэд тайлбарлан таниулах, мөнгөний бодлого, макро эдийн засгийн талаарх иргэдийн эдийн засгийн мэдлэгийг ахиулахад үргэлжлүүлэн анхаарах болно. Монголбанкны бодлого, үйл ажиллагааг олон нийтэд хүргэхэд хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтарч ажиллахын зэрэгцээ ард иргэдэд нам, тогтвортой инфляцийн ач холбогдлыг тайлбарлан таниулах, их дээд сургуулийн оюутан, сурагчдад мөнгөний бодлогын талаар сургалт хийж мэдээлэл өгөх зэрэг ажлуудыг цаашид ч үргэлжлүүлнэ.


“Мөнгөний бодлогын мэдэгдэл”-ийн агуулгад анхаарч мөнгөний бодлогын мэдэгдэлд Төв банк юу хийж байгаагаа, ямар шийдвэрийг юуны учир гаргаснаа тайлбарлаад зогсохгүй бодлогын боломжит хувилбарууд дотроос чухам алийг нь ямар үндэслэлээр сонгосон, энэ нь инфляцийн зорьсон түвшинд хүрэх зорилготой хэрхэн уялдаж байгаа талаар илүү нээлттэй тайлагнадаг болохоор төлөвлөж байна. Монголбанк цаашид банкны төдийгүй, иргэдийн, бизнесийн төлөөлөлтэй ч ажил хэргийн уулзалт хийх, эргэх холбоог сайжруулах ажлыг хийж, өөрийн үйл ажиллагааны нээлттэй ил тод байдлыг хадгалан, Төв банкинд итгэх итгэлийг нэмэгдүүлнэ.

II. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ӨНӨӨГИЙН БОЛОН ОЙРЫН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТАЛААР ХИЙСЭН ТООЦОО, СУДАЛГАА

ХУРААНГУЙ

Инфляци 2014 оны эцэст 12.1%, 2015 оны эцэст 9.5% гарахаар төсөөлөгдөж байна. 2014 оны эхнээс үйлдвэрлэлийн зөрүү сөрөг болж, үйлдвэрлэлийн өсөлт саарч байгаа нь инфляцийг бууруулах чиглэлд нөлөөлөхөөр байгаа ч, төлбөрийн тэнцэлд 2012 оноос үүссэн дарамт нь 2013 онд хямралын шинжтэй болж, Монгол Улсын гадаад цэвэр актив сүүлийн 20 сарын хугацаанд 5.3 их наяд төгрөгөөр огцом буурсны зэрэгцээ төсвөөс гадуурх зарцуулалтыг оруулж тооцсон төсвийн алдагдал өндөр хэвээр байгаа нь инфляцид сөргөөр нөлөөлж байна. 2015 онд эрэлтийн гаралтай инфляцийн дарамт бага байх төлөвтэй хэдий ч, гадаад валютын орох урсгал нэмэгдэхгүй, төлбөрийн тэнцэл ихээхэн алдагдалтай, макро эдийн засгийн гадаад тэнцвэр сайжрахгүй байгаагаас үзэхэд суурь инфляци өсч, инфляцийн дарамт төдийлөн буурахгүй байж болзошгүй байна.

Зураг 1. Инфляци



Зураг 2. Эдийн засгийн бодит өсөлт



Эх сурвалж: Монголбанк

Эдийн засгийн өсөлт 2014 онд 3.6%, 2015 онд 6.1% гарах урьдчилсан тооцоотой байна. 1) Гадаад эрэлт сэргэх төлөвгүй, 2) өрхийн өр, орлогын харьцаа нэмэгдсэн нь хувийн хэрэглээг хязгаарласан, 3) төсвийн орлогын тасалдлаас шалтгаалж төсвийн зардлыг бууруулах шаардлага өссөн, 4) Монгол Улсын гадаад цэвэр актив буурч байгаа нь эдийн засгийн бодит секторын идэвхжил, дотоод эрэлтийг дэмжих бодлогын орон зайг олгохгүй байна.

Төсөөллийн тодорхой бус байдал: Инфляцийн төсөөллийг хийхдээ эрэлтийн талыг голчлон авч үзсэн бөгөөд нийлүүлэлтийн гаралтай инфляци болон аливаа гадаад, дотоод гэнэтийн шок нь төсөөллийн тодорхой бус байдлыг нэмэгдүүлнэ. Ялангуяа макро эдийн засгийн гадаад болон дотоод тэнцвэрийг хангах асуудал нь бодлогын үндсэн сорилт болж буй нөхцөлд эдийн засаг, санхүүгийн салбарт учирч болзошгүй эрсдэлүүд нь төсөөллийн тодорхой бус байдлыг нэмэгдүүлнэ.

Хүснэгт 1. Макро эдийн засгийн гол үзүүлэлтүүд - 1

		2013				2014				2012	2013	2014*
		QI	QII	QIII	QIV	QI	QII	QIII*	QIV*			
ДОТООД ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТ												
Төсөв - Нийт орлого												
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	тэрбум төгрөг	1103.4	1401.6	1431.8	1944.0	1149.4	1580.0	-	-	4864.8	5880.7	6133.8
Төсөв - Нийт зарлага												
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	тэрбум төгрөг	1019.7	1618.2	1429.7	2110.3	1287.0	1683.0	-	-	6116.7	6177.98	6543.8
Урсгал зардал	тэрбум төгрөг	986.9	1366.9	813.0	1392.5	1142.3	1431.7	-	-	4452.1	4559.34	5218.9
Хөрөнгийн зардал	тэрбум төгрөг	37.2	215.7	545.2	649.3	136.5	249.6	-	-	1575.3	1447.34	1356.4
Тэнцвэржүүлсэн тэнцэл												
Нийт тэнцвэржүүлсэн тэнцэл	тэрбум төгрөг	83.6	-216.6	2.1	-166.4	-137.6	-103.0	-	-	-1251.9	-297.3	-410.0
Төсөвтэй адилтгах зардал	тэрбум төгрөг	-	-	-	-	-	-	-	-	488.4	1667.2	1223.3
Төсөвтэй адилтгах зардлыг оруулсан төсвийн тэнцэл	тэрбум төгрөг	-	-	-	-	-	-	-	-	-1740.2	-1964.5	-1633.3
Төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь												
Нийт тэнцвэржүүлсэн тэнцэл	%	-	-	-	-	-	-	-	-	-7.5%	-1.6	-1.9
Төсөвтэй адилтгах зардал	%	-	-	-	-	-	-	-	-	2.9%	8.7	5.7
Төсөвтэй адилтгах зардлыг оруулсан төсвийн тэнцэл	%	-	-	-	-	-	-	-	-	-10.4%	-10.3	-7.6
Дотоодын нийт бүтээгдэхүүн												
Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт, үйлдвэрлэл	%, жилийн, бодит	7.2	9.2	20.5	8.7	7.5	3.8	-	-	12.3	11.6	3.2
Уул уурхайн дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт	%, жилийн, бодит	6.7	4.7	34.9	27.6	24.5	9.5	-	-	8.3	19.4	10.9
Уул уурхайн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт	%, жилийн, бодит	7.3	10.2	17.4	4.0	3.1	2.6	-	-	13.3	9.8	1.3
Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт, эрэлт	%, жилийн, бодит	8.6	9.9	14.7	12.5	7.6	3.4	-	-	12.5	11.7	3.2
Эцсийн хэрэглээний ДНБ-ий өсөлтөд эзлэх нэгж хувь	%, жилийн, бодит	4.6	14.5	8.4	9.9	4.9	9.9	-	-	9.5	9.7	4.3
Хөрөнгийн нийт хуримтлалын ДНБ-ий өсөлтөд эзлэх нэгж хувь	%, жилийн, бодит	-9.6	-10.2	2.4	15.5	-5.7	-22.8	-	-	10.2	0.4	-14.3
Цэвэр экспортын ДНБ-ий өсөлтөд эзлэх нэгж хувь	%, жилийн, бодит	13.5	5.6	3.9	-12.9	8.4	16.3	-	-	-7.2	1.5	13.1
ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ												
Ажилгүйдлийн түвшин	%	9.3	7.3	7.6	7.8	9.4	8.4	-	-	7.9	7.8	-
Ажиллагсдын өсөлт	%, жилийн өсөлт	-0.1	7.3	-2.6	2.0	1.9	-2.9	-	-	-0.8	2.0	-
Ажиллах хүчний оролцооны түвшин	%	61.5	63.7	62.1	60.9	56.4	57.3	-	-	61.6	60.9	-
Улсын дундаж цалин	мянган төгрөг,	692.3	729.0	722.5	758.2	762.9	786.7	-	-	598.5	758.2	-
ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ												
Урсгал тэнцэл	сая ам.доллар	-771.9	-836.1	-808.0	-776.1	-320.6	-474.1	-407.9		-3362	-3192	
Хөрөнгө ба санхүүгийн тэнцэл	сая ам.доллар	657.6	257.1	45.7	477.8	258.4	-254.7	634.4		4929	1438	
Нийт төлбөрийн тэнцэл	сая ам.доллар	-397.8	-585.4	-435.8	-448.3	-307.8	-607.3	196.6		1369	-1867	
Экспорт (Ф.О.Б)	сая ам.доллар	809.2	1214.6	1074.1	1171.2	986.9	1493.9	1317.3		4385	4269	
Чулуун нүүрс	сая ам.доллар	209.4	333.1	240.5	333.0	206.2	241.6	217.2		1880	1116	
	мянган тонн	3445.2	4038.7	3872.7	6831.6	3734.6	5613.7	4647.4		20547	18188	
Эсийн баяжмал	сая ам.доллар	209.4	194.8	275.4	269.3	349.2	636.7	561.1		839	949	
	мянган тонн	140.0	142.8	186.4	180.6	214.1	369.4	311.9		574	650	
Төмрийн хүдэр	сая ам.доллар	125.9	224.9	127.3	176.3	81.4	126.7	119.5		533	654	
	мянган тонн	1121.6	2075.7	1491.8	2035.4	908.6	1689.5	1767.8		6416	6724	
Боловсруулаагүй нефть	сая ам.доллар	93.7	108.8	146.5	166.4	157.6	162.7	153.8		336	515	
	мянган тонн	137.4	161.8	195.3	239.1	1608.3	1585.0	1455.7		499	734	
Мөнгөжөөгүй алт	сая ам.доллар	42.7	92.8	110.4	63.9	89.8	0.0	85.6		122	310	
	нэг тонн	1.0	2.2	2.7	1.6	2.2	0.0	2.3		3	8	
Бусад	сая ам.доллар	128.1	260.2	173.9	162.3	102.6	326.2	180.2		675	725	
Импорт (Ф.О.Б)	сая ам.доллар	1044.5	1625.1	1568.4	1351.6	915.1	1488.3	1346.4		5938	5590	
Шууд хөрөнгө оруулалт	сая ам.доллар, цэвэр	843.9	399.7	409.6	445.0	292.8	175.4	227.0		4408	2098	
Тухайн жилийн ДНБ-д эзлэх хувь												
Урсгал тэнцэл	%	-6.3	-6.8	-6.5	-6.3	-2.7	-4.1	-3.5		-27.5	-25.9	
Хөрөнгө ба санхүүгийн тэнцэл	%	5.3	2.1	0.4	3.9	2.2	-2.2	5.4		40.3	11.7	
Нийт төлбөрийн тэнцэл	%	-3.2	-4.7	-3.5	-3.6	-2.6	-5.2	1.7		11.2	-15.1	

Эх сурвалж: Монголбанк

Жич: 2014 оны төсөөлөл нь суурь хувилбар бөгөөд төлбөрийн тэнцлийн дарамт оны сүүлийн 4 сард мэдэгдэхүйц буурах магадлал бага гэсэн нөхцөлд үндэслэсэн болно. Зах зээлийн хүлээлтэд сөргөөр нөлөөлөхүйц үзүүлэлтүүдийг уг хүснэгтэд оруулаагүй болно.

Хүснэгт 2. Макро эдийн засгийн гол үзүүлэлтүүд – 2

		2013				2014				2012	2013	2014*	2015*
		QI	QII	QIII	QIV	QI	QII	QIII*	QIV*				
ГАДААД ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН													
<i>Гадаад эдийн засгийн өсөлт</i>													
БНХАУ	%, жилийн, бодит	7.7	7.5	7.5	7.3	7.4	7.5	7.4	7.4	7.7	7.7	7.4	7.2
<i>Түүхий эдийн үнэ</i>													
Эсэ	\$/тн	7509.8	6731.0	7290.3	7375.8	6650.0	6771.0	6845.3	6849.7	8064	7227	6779	6974
Алт	\$/унц	1592.9	1342.4	1348.8	1225.4	1291.8	1279.1	1285.0	1256.7	1676	1377	1278	1260
Нүүрс	\$/тн	80.3	74.2	76.0	85.1	72.9	73.9	74.5	77.0	91	79	75	79
Төмрийн хүдэр	\$/тн	137.3	116.5	131.4	134.2	116.8	93.8	100.0	100.0	133	130	103	103
Газрын тос (Урал)	\$/баррель	108.6	101.7	106.5	106.9	102.9	104.2	105.4	104.4	110	106	104	102
МӨНГӨ, САНХҮҮ													
<i>Мөнгөний нийлүүлэлт</i>													
M2 мөнгөний жилийн өөрчлөлт	%	19.6	13.5	19.3	24.1	35.8	26.3	22.1	5.2	18.8	24.1	5.2	-
Нөөц мөнгөний жилийн өөрчлөлт	%	36.0	53.8	22.4	54.0	26.7	-17.9	-0.4	-11.1	30.5	54.0	-11.1	-
<i>Эзэл</i>													
Эзэлийн жилийн өөрчлөлт	%	27.8	36.2	50.8	54.0	54.0	42.9	23.7	18.8	23.9	54.0	18.8	-
Хугацаа хэтэрсэн эзэлийн нийт эзэлд эзлэх хувь	%	1.4	1.7	1.5	1.1	2.5	3.6	-	-	1.6	1.1	-	-
Хугацаа хэтэрсэн эзэлийн өөрчлөлт	%	62.5	189.2	31.2	6.9	180.0	192.7	-	-	50.0	6.9	-	-
<i>Хүү</i>													
Төгрөгийн хадгаламж	%, хүүний түвшин	11.8	12.1	12.0	12.2	12.2	12.2	-	-	11.3	12.0	-	-
Төгрөгийн эзэл	%, хүүний түвшин	19.2	18.5	18.4	17.8	19.0	19.1	-	-	18.1	18.5	-	-
Банк хоорондын зах	%, хүүний түвшин	12.7	10.8	9.6	9.2	9.5	10.1	-	-	13.3	10.6	-	-
Бодлогын хүү	%, хүүний түвшин	12.5	11.2	10.5	10.5	10.5	10.5	-	-	13.0	11.2	-	-
<i>Валютын ханш</i>													
Төгрөгийн ам.доллартай харьцах МБ-наас зарласан ханш	тогрөг	1397.0	1431.2	1569.0	1698.6	1746.2	1807.3	-	-	1359.2	1523.9	-	-
ИНФЛЯЦИ													
Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индекс	улирлын нөлөө арилгасан	10.1	7.9	6.9	9.5	12.1	13.8	14.7	12.1	13.8	9.5	12.1	-
Хүсний үнийн өсөлтийн инфляцид эзлэх нэгж хувь	%, улирлын нөлөө арилгасан	3.6	2.4	1.3	2.9	3.5	3.7	4.1	3.2	6.2	2.9	3.2	-
Хүсний бүс бүтээгдэхүүний үнийн өсөлтийн инфляцид эзлэх нэгж хувь	%, улирлын нөлөө арилгасан	6.4	5.6	5.7	6.6	8.5	10.2	10.6	8.8	7.8	6.6	8.8	-
Улаанбаатар хотын суурь инфляци	%, жилийн	9.1	21.1	8.4	10.8	12.8	14.6	-	-	11.1	10.8	-	-

Эх сурвалж: Монголбанк

II.1 ДОТООД ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТ

Нийт үйлдвэрлэл

Монгол Улсын эдийн засаг⁸ 2014 оны эхний хагас жилд 5.3 хувиар өслөө. Хөдөө аж ахуй, уул уурхай, тээвэр ба агуулахын салбарууд 16.3, 16.1, 11.9 хувиар тус тус өсч хамгийн өндөр өсөлтийг үзүүлсэн бол бөөний болон жижиглэнгийн худалдаа (-12.3%), барилгын салбар (-1.8%), бүтээгдэхүүний цэвэр татвар (-3.3%) бууралттай байв. 2014 оны эхний хагаст эдийн засгийн өсөлт (5.3)-ийн 3.0 нэгж хувийг уул уурхай, 2.4 нэгж хувийг үйлчилгээ, 1.9 нэгж хувийг хөдөө аж ахуйн салбарууд бүрдүүлэв. 2014 оны эхний хагаст уул уурхайн салбар 16.1 хувиар өссөн бөгөөд үүний 11.2 нэгж хувийг Оюу толгойн үйлдвэрлэл бүрдүүлжээ.

Хүснэгт 3. Эдийн засгийн бодит өсөлт (%), салбараар


	2011	2012	2013	2014 эхний хагас
Эдийн засгийн өсөлт	17.3	12.3	11.6	5.3
Хөдөө аж ахуй	-0.3	21.1	19.3	16.3
Уул уурхай	7.7	8.3	19.4	16.1
Боловсруулах	7.9	8.7	10.9	0.3
Цахилгаан, хий	6.1	4.2	5.1	1.3
Барилга	22.7	85.3	8.2	-1.8
Худалдаа	46.4	12.0	6.5	-12.3
Тээвэр ба агуулах	15.1	8.1	-1.7	11.9
Мэдээлэл, холбоо	5.8	16.2	13.2	2.5
Үйлчилгээ	4.7	9.0	9.0	7.2
Бүт.цэвэр татвар	62.9	7.2	12.9	-3.3

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо (ҮСХ)

Эдийн засгийн бодит өсөлтөд худалдааны салбар -1.5, боловсруулах салбар 0, бүтээгдэхүүний цэвэр татвар -0.5 нэгж хувиар тус тус буурах нөлөө үзүүлжээ. 2014 оны эхнээс эдийн засгийн идэвхжил суларч дотоод эрэлт буурсан, төлбөрийн тэнцлийн хямралт нөхцөл байдал нь эдийн засагт хүндрэл үүсгэснээр худалдаа, боловсруулах салбарын өсөлт ийнхүү өмнөх оноос буураад байна. 2013 онд 66%-иар өсч байсан барилгын салбарын үйлдвэрлэл бодит дүнгээр 2014 оны эхний хагаст -1.8 хувиар буурлаа. Улсын төсвийн орлого тасарч байгаагаас бүтээгдэхүүний цэвэр татвар буурч, эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлөв.

Ойрын төлөв: 2014 оны туршид хөдөө аж ахуй, уул уурхай, үйлчилгээний зарим салбар эдийн засгийн өсөлтөд эерэгээр нөлөөлөхөөр байгаа бол барилга, худалдаа, бүтээгдэхүүний цэвэр татвар сөрөг нөлөөтэй байхаар байна. Зэсийн баяжмал, газрын тос, төмрийн хүдэр нь уул уурхайн салбарын өсөлтийг голлон бүрдүүлэх бол боловсруулах болон цахилгаан, дулаан, уур, ус хангамж зэрэг бусад аж үйлдвэрлэлийн салбар эдийн засгийн өсөлтөд бага нөлөө үзүүлэхээр байна.

Зураг 3. Үйлдвэрлэл талаас тооцсон ДНБ-ий өсөлт



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо (ҮСХ)


⁸ 2010 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон Бодит дотоодын нийт бүтээгдэхүүн

Үйлчилгээний салбаруудаас авто замын тээврийн үзүүлэлтүүд өндөр байгаа нь тээврийн салбар эдийн засгийн өсөлтөд эерэгээр нөлөөлөх нөхцөлийг бий болгохоор байгаа бол бөөний ба жижиглэн худалдааны салбарын хувьд энэ оны сүүлийн хагаст бууралттай хэвээр байж, эдийн засгийн өсөлтийг сааруулах эрсдэлтэй байна.

Нийт эрэлт

Эдийн засгийн нийт эрэлт талаас тооцсон бодит ДНБ 2014 оны эхний хагасын урьдчилсан гүйцэтгэлээр өмнөх оны мөн үеэс 5.1%-иар өсчээ. Энд өрхийн хэрэглээ 10.3%, засгийн газрын хэрэглээ 9.4%-иар өсч, гадаад худалдааны алдагдал 85%-иар буурсан бол нийт хуримтлал 32.4%-иар буурсан байна. Өрхийн хэрэглээ сүүлийн 4 жилийн турш эдийн засгийн өсөлтөд 7-8 нэгж хувийн эерэг нөлөө үзүүлсэн бол 2014 оны эхний хагаст 6.5 болж буураад байна. Харин нийт хуримтлал нь 2014 онд гадаадын шууд хөрөнгө оруулалт огцом багассан болон Монголбанкнаас мөнгөний уламжлалт бус бодлогын хүрээнд эдийн засгийн бодит секторт хувийн хэвшлээр дамжуулж хийсэн мөнгөний нийлүүлэлт буурсны нөлөөгөөр ийнхүү буурчээ. 2014 оны эхний хагаст экспорт 22.6%-иар өсч, импорт 14.1%-иар буурснаар, цэвэр экспорт 13.1 нэгж хувийн эерэг нөлөө үзүүлжээ.

Зураг 4. Эрэлт талаас тооцсон ДНБ-ий өсөлт



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо (ҮСХ)

Ойрын төлөв: Хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдлаас харахад 2014 онд өрхийн орлого нэмэгдэхээргүй байгаа, өрхийн өр, орлогын харьцаа өсч байгаа нь өрхийн хэрэглээг хумих чиглэлд нөлөөлөхөөр байна. Улсын төсвийн орлогын гүйцэтгэл дутуу, төсвийн алдагдлыг ДНБ-ий 2%-иас хэтрүүлэхгүй байлгах хуулиар тогтоосон тусгай шаардлагатай зэргийн улмаас Засгийн газрын хэрэглээ ирэх 2 улиралд дотоод эрэлтэд нөлөө үзүүлэхээргүй байна. Гадаад болон дотоод хөрөнгө оруулалт буурах хүлээлттэй тул нийт хуримтлал оны сүүлийн хагаст мөн буурахаар байна. Иймд 2014 оны туршид нийт эрэлтийг тэтгэх, хөрөнгө оруулалтын бууралтыг нөхөх гол хүчин зүйл нь цэвэр экспорт байх төлөвтэй.


II.1.1 Оюу толгой, Таван толгойн үйлдвэрлэл

Оюу толгойн үйлдвэр 2014 оны эхний хагас жилийн байдлаар 61.5 мянган тонн цэвэр зэс, 5.1 тонн алт, 11.1 тонн мөнгөний агууламж бүхий нийт 242.9 мянган тонн зэсийн баяжмал үйлдвэрлэж, 279.6 мянган тонн зэсийн баяжмал экспортод гаргасан мэдээтэй байна. 2014 оны үлдсэн хугацаанд хүдрийн агууламж өндөртэй хэсэгт олборлолт явуулах тул 81.4 мянган тонн цэвэр зэс, 11.2 тонн алт, 17.2 тонн мөнгөний агууламж бүхий 304.8 мянган тонн зэсийн баяжмал үйлдвэрлэх төлөвлөгөөтэй байна. Энэ нь уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын өсөлтийн 3.1 орчим нэгж хувийг бүрдүүлэхээр байгаа юм. Борлуулалтын гэрээг энэ оныг дуусталх хугацаагаар байгуулсан тул оны сүүлийн хагаст 471.9 мянган тонн зэсийн баяжмал экспортолж, улмаар агуулах дахь борлуулагдаагүй нөөц буурахаар байна. 2015 онд Оюу толгойн

ордоос 219.6 мянган тонн цэвэр зэс, 20.3 тонн алт, 46.2 тонн мөнгөний агууламж бүхий 850.8 мянган тонн зэсийн баяжмал үйлдвэрлэж, 856.8 мянган тонн зэсийн баяжмал экспортлох төлөвлөгөөтэй байна.

Эрдэнэс Таван толгой ХК-ийн зүүн болон баруун Цанхийн уурхайгаас 2014 оны эхний хагас жилд 1.8 сая тонн нүүрс олборлосон бол оны сүүлийн хагаст 5.5 сая тонн нүүрс олборлохоор төлөвлөжээ. Энэ нь уул уурхай, олборлох салбарын үйлдвэрлэлийг 0.8 орчим нэгж хувиар өсгөх төлөвтэй. 2015 онд тус ордоос 12 сая орчим тонн нүүрс олборлох төлөвлөгөөтэй байна.

Зураг 5. Оюу толгой, Таван толгойн үйлдвэрлэл болон экспортын хэмжээ




Эх сурвалж: Компаниудаас авсан мэдээлэл

II.1.2 Үйлдвэрлэлийн зөрүү

Үйлдвэрлэлийн зөрүү 2014 оны 3 дугаар улиралд сөрөг утгатай байхаар төсөөлөгдөж байна. 2012 оны сүүлийн хагасаас гадаад эрэлт муудаж эхэлсэн нь үйлдвэрлэлийн зөрүүг бууруулсан ч, Монголбанк 2013 оны эхний хагаст мөнгөний бодлогын хүүг шат дараатай бууруулахын сацуу эдийн засгийг тогтворжуулах бодлогын арга хэмжээ хэрэгжүүлсэн, Засгийн газраас бондын эх үүсвэрээр тодорхой төслүүдийг санхүүжүүлсэн зэрэг нь дотоод цэвэр активыг нэмэгдүүлж, дотоодын эрэлтийг дэмжсэнээр төлбөрийн тэнцлийн

Зураг 6. Үйлдвэрлэлийн зөрүү сөрөг хэвээр байна



Эх сурвалж: Монголбанк

“хямрал”-ын эдийн засаг дахь сөрөг нөлөөллийг зөөлрүүлж, эдийн засгийн өсөлтийг тогтворжуулахад голлох үүрэг гүйцэтгэсэн. Гэвч 2014 он гарсаар төлбөрийн тэнцэл мэдэгдэхүйц сайжраагүй, гадаад цэвэр актив үргэлжлэн буурсан, эдийн засгийн идэвхжил суларсан, Монголбанкны хөтөлбөрүүдийн зээлийн үлдэгдэл буурснаар банкны салбарын зээлийн өсөлт болон нийт M2 мөнгөний өсөлтүүд саарсан, өрхийн өр ба орлогын харьцаа өссөн зэргээс шалтгаалж иргэдийн зээл 2015 онд өсөхөөргүй байна. Түүнчлэн, хувийн хэрэглээний өсөлт саарсан, төсвийн орлогын тасалдлаас

шалтгаалж ЗГ-ын хэрэглээ, хөрөнгө оруулалтын өсөлт буурч, Хөгжлийн банкны хөрөнгө оруулалтууд хойшлогдохоор хүлээгдэж байгаа зэрэг нь эдийн засгийн өсөлтийг сааруулж, улмаар ажил эрхлэлтийг бууруулж болзошгүй. Иймд 2014 оны 3-4 дүгээр улиралд эдийн засаг мөчлөгийн буурах үедээ байх төлөвтэй байна. Эдийн засгийн өсөлтөд Оюу толгой төслийн үзүүлэх нөлөө 2014 оны 2-р улирлаас эхлэн багасах ба үүнтэй уялдан потенциал ДНБ-ий өсөлт нь дараагийн улирлуудад буурах хандлагатай байна.

II.2 УЛСЫН ТӨСӨВ

2014 оны эхний 8 сарын төсвийн гүйцэтгэл: Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2014 оны эхний 8 сарын байдлаар 3798.0 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 3951.0 тэрбум төгрөгт хүрч, тэнцвэржүүлсэн төсвийн нийт тэнцэл -153.0 тэрбум төгрөгийн алдагдалтай байв.

Төсвийн орлого: Төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 3798.0 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 10.1 хувь буюу 347.8 тэрбум төгрөгөөр их байна. Харин урсгал орлого (төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн 99%) 10.1 хувь буюу 347.3 тэрбум төгрөгөөр нэмэгджээ. Урсгал орлогыг бүрэлдэхүүн хэсгүүдээр тайлбарлавал татварын орлого (урсгал орлогын 85.2%) 6.7 хувь буюу 203.0 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 3233.6 тэрбум төгрөг, татварын бус орлого 34.4 хувь буюу 144.3 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 563.2 тэрбум төгрөг байв. Татварын бус орлого өндөр өсөлттэй гарахад газрын тосны орлогын өсөлт⁹ голчлон нөлөөлжээ.

Төсвийн зарлага: Төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 2014 оны эхний 8 сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 369.6 тэрбум төгрөгөөр өсч 3951.0 тэрбум төгрөгт хүрчээ. Бүрэлдэхүүн тус бүрээр нь тайлбарлавал урсгал зардал 15.0 хувь буюу 422.8 тэрбум төгрөгөөр өсч 3238.9 тэрбум төгрөг, хөрөнгийн зардал 1.3 хувь буюу 9.3 тэрбум төгрөгөөр буурч 708.7 тэрбум төгрөг, эргэж төлөгдөх цэвэр зээл 92.8 хувь буюу 43.9 тэрбум төгрөгөөр буурч 3.4 тэрбум төгрөг байв.

Санхүүжүүлэх эх үүсвэр: 2014 оны эхний 8 сарын байдлаар гадаад зээлийн үндсэн төлбөрт 71.2 тэрбум, дотоод зээлийн үндсэн төлбөрт 83.7 тэрбум, Засгийн газрын урт хугацаат дотоод бондын үндсэн төлбөрт 439.4 тэрбум, богино хугацаат бондын үндсэн төлбөрт 495.6 тэрбум төгрөгийг тус тус төлж, 100.1 тэрбум төгрөгийн гадаад төслийн зээл авч, Засгийн газрын 860.8 тэрбум төгрөгийн богино хугацаат, 230.7 тэрбум төгрөгийн урт хугацаат бондыг тус тус арилжаалсан гүйцэтгэлтэй байв.

2014 оны төсвийн хүлээгдэж буй гүйцэтгэл: Эдийн засгийн идэвхжил буурч, оны эхний 8 сард төсвийн орлого 623 тэрбум төгрөгөөр дутсан бол он дуустал нэмж 130 тэрбум орчим төгрөгөөр¹⁰ тасрах эрсдэлтэй байна. Урсгал зардлыг 100 тэрбум төгрөгөөс илүүгээр бууруулах боломжгүй байх тохиолдолд “Төсвийн тогтвортой байдлын тухай хууль”-ийн тэнцвэржүүлсэн төсвийн алдагдлыг 2%-иас хэтрүүлэхгүй гэсэн заалтыг биелүүлэхийн тулд хөрөнгө оруулалтыг 650 тэрбум төгрөгөөр танах шаардлага үүсэхээр байна.

⁹ Газрын тосны орлого өмнөх оны мөн үеэс 59.5 хувь буюу 59 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн.


¹⁰ Нийтдээ 750 тэрбум төгрөгөөр төсвийн орлого дутахаар байна.

Хүснэгт 4. 2014 оны эхний 8 сарын улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл (тэрбум төгрөг)

	2013 I-VIII		2014 I-VIII		I-VIII 2014/2013
	Гүйцэтгэл	Хувийн жин	Гүйцэтгэл	Хувийн жин	
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	3484	100%	3842	100%	110%
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	34	1%	44	1%	128%
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	3450	99%	3798	99%	110%
А. УРСГАЛ ОРЛОГО	3450	99%	3797	99%	110%
I. ТАТВАРЫН ОРЛОГО	3031	87%	3234	84%	107%
1 Орлогын албан татвар	672	19%	634	17%	94%
2 Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	528	15%	600	16%	114%
3 Өмчийн татвар	22	1%	26	1%	123%
4 Дотоодын бараа, үйлчилгээний татвар	1184	34%	1215	32%	103%
5 Гадаад худалдааны орлого	232	7%	244	6%	105%
6 Бусад татвар	393	11%	514	13%	131%
II. ТАТВАРЫН БУС ОРЛОГО	419	12%	563	15%	134%
Б. ХӨРӨНГИЙН ОРЛОГО	1	0%	1	0%	184%
В. ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	0	0%	0	0%	0%
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3581	100%	3951	100%	110%
А. УРСГАЛ ЗАРДАЛ	2816	79%	3239	82%	115%
1 Бараа, үйлчилгээний зардал	1440	40%	1592	40%	111%
2 Зээлийн үйлчилгээний төлбөр	128	4%	245	6%	190%
3 Татаас ба шилжүүлэг	1247	35%	1403	35%	112%
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	718	20%	709	18%	99%
В. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	47	1%	3	0%	7%
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН УРСГАЛ ТЭНЦЭЛ	633		558		
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-131		-153		


Эх сурвалж: Сангийн яам, УСХ

Зураг 7. Төсвийн нийт орлого ба тусламж



Эх сурвалж: Сангийн яам, УСХ

Зураг 8. Төсвийн нийт зарлага ба цэвэр зээл




ДНБ-ий 2013 оны гүйцэтгэл шинэчлэгдэв: Нэрлэсэн ДНБ-ий 2013 оны гүйцэтгэл 1.6 их наяд төгрөгөөр нэмэгдэн 19.1 их наяд төгрөг болж шинэчлэгдэв¹¹. 2014 оны 5-р сарын төсвийн тодотголд нэрлэсэн ДНБ-ийг 2014 онд 20.5 их наяд төгрөг байхаар төсөөлсөн, үүнийг шинэчилбэл төсөвт ойролцоогоор 20 тэрбум төгрөгийн, Засгийн газрын зээлд 400 тэрбум төгрөгийн нэмэлт орон зай үүсэхээр байна.

Дээрхээс үзэхэд 2014 оны улсын нэгдсэн төсвийн зардлыг 730 орчим тэрбум төгрөгөөр танах шаардлага үүсч байна.

Хүснэгт 5. 2013, 2014 оны төсөв

Тэрбум төгрөг	2014.08 Гүйц.	2014 Төс.	2014 ХБГ	2015 ТХМ
Тогтворжуулалтын сан	44	30		
Тэнцвэржүүлсэн орлого	3798	6884	6134	7201
Тэнцвэржүүлсэн зардал	3951	7294	6544	7691
Тэнцвэржүүлсэн тэнцэл	-153	-410	-410	-490

Зураг 9. Төсөвтэй адилтгах зардлыг оруулснаар



Эх сурвалж: Сангийн яам, УСХ, Хөгжлийн банк

Хөгжлийн банкны зарцуулалт буюу төсөвтэй адилтгах зардал: МУХБ 2012 онд 488.4 тэрбум төгрөг, 2013 онд 1667.3 тэрбум төгрөг, энэ оны эхнээс 7-р сарын 24-ний өдөр хүртэлх хугацаанд 499.4 тэрбум төгрөгийн санхүүжилт хийжээ. Томоохон төслүүдээс дурдвал орон нутаг болон нийслэлийн авто зам барихад 722 тэрбум төгрөг (нийт МУХБ-ны санхүүжилтийн 27.2%), шинэ төмөр замын төсөлд 310 тэрбум төгрөг, ХАА, хөнгөн үйлдвэрийн 6 төсөлд 271 тэрбум төгрөгийн санхүүжилт тус тус олгожээ. МУХБ-ны мэдээгээр 2014 он дуустал 723.9 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөсөн. Үүнээс үзвэл 2014 онд улсын төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал ДНБ-ий 1.9%, төсөвтэй адилтгах зардлыг оруулснаар 7.6%-д хүрэх тооцоотой байна.

Хүснэгт 6. МУХБ-ны зарцуулалт томоохон төслүүдээр

ТЭРБУМ ТӨГРӨГ	2012	2013	2014	Нийт
	Гүйц	Гүйц	Гүйц /7.24/ Төс /7.25-12.31/ Нийт /2014/	
АВТО ЗАМЫН ТӨСӨЛ	202	432	88	205
СУУРЬ ДЭД БҮТЭЦ, ГУДАМЖ ТӨСӨЛ	0	144	72	160
ЭРДЭНЭС ТАВАН ТОЛГОЙ	139	139	0	0
ХАА, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН 6 ТӨСӨЛ	0	271	0	0
ШИНЭ ТӨМӨР ЗАМ	0	272	38	38
БУСАД	147	409	302	820
НИЙТ	488	1667	499	1223

Эх сурвалж: Хөгжлийн банк

¹¹ УСХ-ны 7-р сарын бюллетень

2015 оны төсөв: 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэлд төсвийн тэнцвэржүүлсэн орлого 7.2 их наяд төгрөг, нийт төсвийн зардал 7.7 их наяд төгрөг байхаар төсөөлсөн. Харин 2015 оны төсвийн тэнцвэржүүлсэн орлого нь 2014 оны батлагдсан төсвийн орлогоос 317.2 тэрбум төгрөгөөр, хүлээгдэж буй бодит гүйцэтгэлээс 1 их наяд орчим төгрөгөөр өндөр байгаа нь төлбөрийн тэнцлийн хүндрэл арилаагүй, гадаад цэвэр активын бууралт үргэлжилсэн, эдийн засгийн идэвхжил суларч байгаа өнөөгийн нөхцөлд хэт өөдрөг төсөөлөл гэж үзэж байна.

Хүснэгт 7. Төсвийн хүрээний мэдэгдэл (тэрбум төгрөг)

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Төсвийн хүрээний мэдэгдэл	Төсвийн төсөөлөл	
	2015 он	2016 он	2017 он
1 Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлт /хувь/	10.2	7.0	5.9
2 Хэрэглээний үнийн индексийн түвшин	7.0	6.0	6.0
3 Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого /тэрбум төгрөг/ -Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	7,201.1 29.4	7,322.2 26.5	7,793.0 25.6
4 Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/ -Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	7,690.9 31.4	7,874.9 28.5	8,400.7 27.6
5 Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлт /тэрбум төгрөг/ -Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	378.5 1.5%	184.0 0.7%	525.8 1.7%
6 Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/ -Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	-489.8 -2.0%	-552.7 -2.0%	-607.7 -2.0%
7 Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/ -Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	1,967.3 8.0%	2,026.3 7.3%	2,127.7 7.0%
8 Улсын өрийн нийт хэмжээ, ӨҮЦ-ээр /тэрбум төгрөг/ -Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	9,796.5 40.0%	11,054.6 40.0%	12,154.5 40.0%

Эх сурвалж: Сангийн яам

II.3 МӨНГӨНИЙ ЗАХ

II.3.1 Мөнгөний үзүүлэлтүүд


Мөнгөний нийлүүлэлт: Гадаадын хөрөнгө оруулалт буурч, гадаад валютын орох урсгал эрс багассанаар эдийн засагт хөрөнгийн дутагдал бий болж зээл олголт тасалдах, нийт мөнгөний нийлүүлэлт абсолют дүнгээрээ буурах, улмаар ДНБ-ий бодит өсөлт сөрөг утгатай болж эдийн засгийн хямрал нүүрлэх эрсдэлтэй байсан тул Монголбанк эдийн засгийг тогтворжуулах хөтөлбөр хэрэгжүүлсний үр дүнд мөнгө, зээлийн өсөлтийг тогтворжуулсан. Тухайлбал, 2012 оны 4 дүгээр улиралд 4.4 их наяд төгрөгтэй тэнцэж байсан гадаад цэвэр актив (ГЦА) 2013 оны эцэст 934 тэрбум төгрөг, 2014 оны 8 дугаар сарын байдлаар -902 тэрбум төгрөг болж огцом буурсан бол мөн хугацаанд дотоод цэвэр актив (ДЦА) харгалзан 2012 оны эцсийн 3.2 их наяд төгрөгөөс 2013 оны эцэст 8.5 их наяд төгрөгт, 2014 оны 8 дугаар сарын байдлаар 11 их наяд төгрөгт хүрч өссөн байна. Ингэснээр нийт М2 мөнгөний өсөлт 2012 оны эцэст 18.7% болж суларч байснаа 2013 оны эцэст 24.2% болж тогтворжин, улмаар 2014 оны 8 дугаар сард 20.5%-тай гарсан бол, эдгээр хугацаанд нийт зээлийн өсөлт харгалзан 23.9%, 54%, 26.1% байжээ.

Хэрэв цаашид гадаад валютын орох урсгал нь экспортын орлого, гадаадын шууд хөрөнгө оруулалтаар дорвитой нэмэгдэхгүй, төлбөрийн тэнцэл сайжрахгүй, ГЦА өсөхгүй тохиолдолд мөнгөний нийлүүлэлтийг ДЦА-аар нэмэгдүүлбэл нэг талаар


эдийн засгийн бодит секторын идэвхжилд эерэгээр нөлөөлөх хэдий ч, нөгөө талаар төгрөгийн гадаад валюттай харьцах ханш сулрах дарамтыг нэмэгдүүлэхээр байна. Иймд Монголбанк анх төлөвлөснийхөө дагуу хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдээс үе шаттай гарах зарчмаар ажиллаж байгаа бөгөөд хөтөлбөрүүдийн зээлийг нэмэгдүүлэхгүй, эдийн засгийн эрсдэлийг харгалзан банкууд зээлийн нөхцөлүүдээ чангатгаж, зээл олголтыг хумина гэж үзвэл 2014 оны эцэст M2 мөнгөний өсөлт ердөө 5%-д, зээлийн жилийн өсөлт 18% болж эрс саарах төлөвтэй байна. Өөрөөр хэлбэл, 2014 оны эцэст M2 мөнгөний өөрчлөлтөд ДЦА 38 нэгж хувийн өсгөх, ГЦА 32 нэгж хувийн бууруулах нөлөө үзүүлэхээр байна. Харин M2 мөнгөний 2015 оны өөрчлөлтөд ДЦА 6, ГЦА 5 нэгж хувийн нөлөө үзүүлэхээр байгаа юм.

Эдгээрээс дүгнэхэд мөнгө, зээлийн өсөлтийг тогтвортой байлган, эдийн засгийн тэнцвэртэй өсөлтийг хангаж, санхүүгийн болон эдийн засгийн болзошгүй эрсдэлээс сэргийлэх зайлшгүй нөхцөл нь гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлэх, нэгдсэн төсвийн зохистой бодлогоор төсвийн тогтвортой байдлыг хангах, төсвийн хэмнэлтийн горимд шилжих зэргээр төлбөрийн тэнцлийг эрс сайжруулах явдал хэвээр байсаар байна.


Зураг 10. M2 мөнгө болон зээлийн өсөлт, ГЦА, ДЦА-ын түвшин (тэрбум төгрөг)




Зураг 11. M2 мөнгөний өсөлт, бүрэлдэхүүнээр (актив)



Зураг 12. M2 мөнгөний өсөлт, бүрэлдэхүүнээр (пассив)



Зураг 13. Мөнгө, зээлийн өсөлт (орон сууцны ипотекийн зээлийг хассанаар)



Хүснэгт 8. Мөнгөний үзүүлэлтүүд /2008-2015/*

Мөнгөний тойм	(өөрөөр заагаагүй бол тэрбум төгрөг)														
	2008	2009	2010	2011	2012	2013				2014				2015	
	Q4	Q4	Q4	Q4	Q4	Q1	Q2	Q3	Q4	Q1	Q2	Aug	Q3	Q4	Q4
	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц				Гүйц				Төс	
M2 мөнгө	2270	2880	4680	6412	7617	7301	8004	8482	9451	9949	10107	10136	10352	9946	11090
M1 мөнгө	647	651	1158	1741	1835	1589	2027	2017	2083	1737	1862	1875	1871	1798	2005
Банкнаас гадлуурх мөнгө	329	285	388	517	603	483	600	597	582	550	571	616	629	604	674
Харилцах ₮	319	366	769	1224	1232	1107	1426	1419	1501	1188	1291	1259	1242	1193	1331
Бараг мөнгө	1623	2229	3522	4671	5782	5711	5977	6465	7368	8212	8245	8261	8481	8148	9085
Дотоод цэвэр актив	1587	1347	1941	3345	3215	3370	5224	6547	8517	9460	10792	11038	10937	12070	12684
Дотоодын цэвэр зээл	2062	1938	2430	4271	3949	4380	6075	8089	9921	11394	12698	12881	12766	13284	14135
ЗГ-ын цэвэр зээл	-574	-717	-835	-1370	-3040	-3011	-2533	-2270	-1048	-646	-257	-314	-386	51	51
Банк бусаас авах авлага	2636	2655	3265	5641	6988	7391	8608	10358	10969	12040	12954	13195	13152	13234	14085
Үүнээс зээл				5641	6988	7391	8608	10153	10764	11381	12302	12385	12342	12239	13260
Үүнээс хөтөлбөрийн зээл				0	193	251	699	1346	1601	1782	1997	1921	1991	1618	1256
Бусад зээл				0	6796	7140	7909	8808	9163	9599	10305	10417	10569	10838	12013
Бусад санхүүгийн байгууллагаас авах авлага (МИК, ХДК, МУХБ-аас авах авлага)								205	205	659	652	810	810	995	825
Бусад цэвэр зүйл	-475	-591	-489	-926	-733	-1009	-851	-1542	-1404	-1934	-1906	-1843	-1830	-1214	-1451
Төв банк															
Нөөц мөнгө	634	733	945	1660	2166	2468	3509	2943	3335	3127	2882	2815	2932	2965	2953
Дотоод цэвэр актив	-171	-805	-1584	-1384	-2999	-2318	-281	21	1394	1550	2397	2623	2417	2759	2901
ЗГ-ын цэвэр зээл	-183	-265	-492	-714	-2774	-2917	-2728	-2418	-1685	-1250	-853	-821	-663	-505	-600
Хөгжлийн банкны цэвэр зээл	0	0	0	0	-32	-1	0	-1	0	-1	-2	161	-47	-47	-9
Банкинд олгосон зээл	243	198	131	342	401	1215	2883	3592	4297	3020	2914	2638	2708	2406	2143
Үнэ тогтворжуулах хөтөлбөр	0	0	0	0	205	254	888	1002	1229	1186	1355	1107	1137	934	572
Ипотекийн зээл	0	0	0	0	0	0	0	1410	1541	1268	1204	1287	1327	1157	1157
Монголбанкнаас банкуудад байршуулсан хадгаламж	0	0	0	0	0	850	900	900	405	150	100	0	0	0	0
Бусад	0	0	0	0	196	111	103	280	1122	417	255	245	245	315	415
МИК бонд, ХДК-ын зээл	0	0	0	0	0	0	0	205	205	659	652	640	640	825	825
Хасах нь: ТБҮЦ	120	393	1101	879	752	743	668	1543	1627	1103	854	576	794	617	156
Бусад цэвэр зүйл	-112	-346	-122	-133	158	129	233	187	205	224	540	580	573	698	698

Меморандум үзүүлэлтүүд:

M2 мөнгөний жилийн өөрчлөлт (%)	34.6	26.9	62.5	37.0	18.8	19.6	13.5	19.3	24.1	36.3	26.3	20.5	22.1	5.2	11.5
Нөөц мөнгөний жилийн өөрчлөлт (%)	19.7	15.7	29.0	75.5	30.5	36.0	53.8	22.4	54.0	26.7	-17.9	8.2	-0.4	-11.1	-0.4
M2 мөнгөний үржүүлэгч (нэгжээр)	3.58	3.93	4.95	3.86	3.52	2.96	2.28	2.88	2.83	3.18	3.51	3.60	3.53	3.35	3.76
Зээлийн жилийн өөрчлөлт (%)	41.7	0.7	23.0	72.8	23.9	27.8	36.2	50.8	57.0	62.9	50.5	26.1	27.0	20.6	6.4
Хөтөлбөрөөс бусад зээлийн өсөлт(%)	-	-	-	-	20.5	23.5	25.2	28.3	34.8	34.4	30.3	21.0	17.3	18.3	10.8
Зээл/M2 мөнгө	1.16	0.00	0.00	0.88	0.92	1.01	1.08	1.20	1.14	1.14	1.22	1.22	1.19	1.23	1.20
Зээл/ДНБ	0.40	0.40	0.39	0.51	0.42	0.43	0.49	0.56	0.57	0.61	0.88	0.83	0.77	0.62	0.57
Мөнгөний эргэлтийн хурд	2.89	2.63	2.39	1.97	2.46	2.41	2.40	2.42	2.36	2.25	1.56	1.63	1.62	2.13	2.23
Төгрөгийн ам.доллартай харьцах ханш (хугацааны эцэст)	1268	1443	1256	1396	1392	1410	1444	1646	1659	1783	1826	1818			
Нэрлэсэн ДНБ /тэрбум төгрөг/	6556	6591	8415	11088	16688	17010	17557	18490	19118	19741	14650	15813	17069	21259	24746
Бодит ДНБ-ий жилийн өсөлт (%)	8.9	-1.3	6.4	17.5	12.3	10.3	9.8	13.7	11.6	11.6	10.1		5.3	3.3	6.1
Уул уурхайн ДНБ	-1.6	5.8	3.6	7.3	8.4	7.4	5.3	15.1	19.4	22.9	24.0		16.3	10.9	8.1
Уул уурхайн бус ДНБ	11.3	-2.7	7.0	19.7	13.3	11.0	10.9	13.4	9.8	9.0	6.9		2.6	1.3	5.4
Жилийн инфляци (%)	23.2	1.9	14.3	9.4	14.2	8.3	6.5	6.9	11.2	11.9	15.1	15.4	15.4	13.4	10.5

*Төсөөлөл нь бодлогын өөрчлөлт тусгагдаагүй суурь төсөөлөл болно.

Тэмдэглэл: Зах зээлийн хүлээлтэд сөргөөр нөлөөлж болзошгүй зарим үзүүлэлтийг хүснэгтэд тусгаагүй болно.

Эх сурвалж: Монголбанк

II.3.2 Мөнгөний зах, хүүгийн түвшин

Санхүүгийн зах зээлийн 90 гаруй хувийг банкны салбар дангаараа бүрдүүлдэг манай орны хувьд богино хугацаат буюу нэг хүртэлх жилийн хугацаатай хэлцлүүд хийгдэж байдаг мөнгөний захын хөгжил нь хөрөнгийн захтай харьцуулахад маш идэвхтэй юм.


Гадаад эдийн засагт 2012 оны эхнээс бий болсон сөрөг үзэгдлүүд, гадаад худалдааны нөхцөл муудсан орчин, дотоодын эрх зүй, хөрөнгө оруулалтын орчинд 2012-2013 онд үүссэн тодорхой бус байдал, томоохон төслүүдийн хэлэлцээр удааширсан нөхцөл зэргээс эдийн засагт орж ирэх гадаад валютын урсгал огцом буурч, санхүүгийн салбарт эх үүсвэр хомсдох, зээлийн тасалдал үүсэх, улмаар эдийн засгийн хямрал болох эрсдэл 2012 оны сүүлч, 2013 оны эхний хагаст тулгарч байлаа. Тиймээс Төв банк эдийн засгийн удаашралын мөчлөгийг сөрж мөнгө, зээлийн өсөлтийг тогтворжуулах, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хадгалах, иргэдийн бодит орлогыг хамгаалах, бодит секторын идэвхжилийг дэмжих, хөрөнгө оруулалт, хуримтлалыг нэмэгдүүлэх, дунд хугацааны бүтцийн шинэчлэлийг эхлүүлэх, эдийн

засгийн суурь бүтэц, ажлын байрыг хамгаалахад тус тус чиглэж ажилласан.

Гадаадын хөрөнгө оруулалт тасралтгүй буурч байсан орчинд эдийн засгийг бүхэлд нь тогтворжуулах, санхүүгийн болон эдийн засгийн болзошгүй хямралын эрсдэлээс сэргийлэх, төлбөрийн тэнцлийн хямралын орчинд эдийн засгийн суурь бүтэц, ажлын байрыг хамгаалах хүрээнд Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөлөөс бодлогын хүүг шат дараатай бууруулах, хүүний коридор нэвтрүүлэх, банкуудад хадгаламж байршуулах, Засгийн газартай хамтран “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах”, “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх” хөтөлбөрүүдийг тус тус хэрэгжүүлж, зохих үр дүнд хүрсэн билээ.


Гэвч гадаад валютын орох урсгал огцом буурсан хандлага удаан хугацаанд үргэлжилсэн, төсөвтэй адилтгах зарцуулалтууд буурахгүй байснаас Монголбанк эдийн засгийн бодит секторын идэвхжилийг мөнгөний бодлоготой уялдуулан дэмжих боломж нь гадаад валютын улсын нөөцөөр хязгаарлагдсан юм. Иймд Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөл төлбөрийн тэнцлийн хүндрэлийг зөөлрүүлэх, инфляцийг эрчимжүүлэхгүй байлгах, дунд болон урт хугацаанд санхүүгийн тогтвортой байдлыг хангах, макро эдийн засгийн тогтвортой байдалд учирч болзошгүй эрсдэлээс сэргийлэх зорилгоор 2014 оны 7 дугаар сард мөнгөний бодлогын хүүг 1.5 нэгж хувиар нэмэгдүүлэн 12% болгосноор мөнгөний бодлогод цаг үеийн шинжтэй, зайлшгүй тохиргоог хийв. Үүний зэрэгцээ банкуудын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдэд гадаад валютын зээлийн эрсдэлийг бууруулах, гадаад валютын зээлийг хумих, санхүүгийн салбарт учирч болзошгүй эрсдэлийг бууруулах чиглэл бүхий зарим өөрчлөлтүүдийг оруулаад байна.

Зураг 14. Банкуудын илүүдэл нөөцийн хэмжээ (сарын дундаж)



Эх сурвалж: Монголбанк

Зураг 15. Хадгаламж, зээлийн хүү




2014 оны 8 дугаар сарын байдлаар төгрөгийн хадгаламжийн дундаж хүү 12.2 хувь, төгрөгийн зээлийн дундаж хүү 17.6 хувь (Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах хөтөлбөрийн зээлийг оруулан тооцсоноор) байна. Оны эхнээс төгрөгийн хадгаламжийн хүү 0.1 нэгж хувиар өссөн бол зээлийн хүү 2.7 нэгж хувиар нэмэгдсэн нь Монголбанкны мөнгөний уламжлалт бус бодлогын хүрээнд хэрэгжүүлж буй хөтөлбөрийн зээлийн үлдэгдэл нь эргэн төлөлтийн дүнгээрээ буурч байгаа, мөнгөний бодлогыг чангаруулсан зэрэгтэй холбоотой юм. Банкуудын олгосон валютын хадгаламжийн хүү 5.5 хувь, зээлийн хүү 13.5 хувь байна.

Монголбанк мөнгөний бодлогын хүүг ашиглан банк хоорондын захын хүүг удирдах


замаар банкуудын зээл, хадгаламжийн хүү, нийт мөнгөний нийлүүлэлт, улмаар эдийн засгийн бодит салбарт нөлөөлөхийг зорьдог. Харин банкууд илүүдэл нөөцөө Төв банк болон бусад банкууд гэсэн боломжит эх үүсвэрээс аль өндөр хүүтэй активт байршуулдаг бөгөөд Төв банкны мөнгөний бодлогын хүү өсөх тохиолдолд банкуудын ТБҮЦ-ны эрэлт өснө. Өөрөөр хэлбэл, банк хоорондын захын хүү нь бодлогын хүүг даган хөдөлдөг, бодлогын хүүний шилжих механизм, нөлөөлөл нь хүүний коридор нэвтрүүлснээр илүү хүчтэй болсон гэсэн үг юм. Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөлөөс богино хугацаат хүүг илүү үр дүнтэй удирдан хэлбэлзлийг нь бууруулах, хүүний сувгийн нөлөөг сайжруулах зорилгоор 2013 оны 2 дугаар сард 4 нэгж хувийн өргөнтэй хүүний коридорыг нэвтрүүлэх шийдвэр гаргасан билээ. Үүнтэй холбоотойгоор банк хоорондын захын хүүгийн хэлбэлзэл буурч, мөнгөний бодлогын хүүтэй ойролцоо түвшинд байсаар байна.

Зураг 16. БХЗ-ын жигнэсэн дундаж хүү



Эх сурвалж: Монголбанк

Зураг 17. Банк хоорондын захын арилжааны хэмжээ /тэрбум төгрөг/



Банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү 2014 оны 8 дугаар сард 12.4 хувь болж, оны эхнээс 3.5 нэгж хувиар өссөн нь Бодлогын хүүгийн өсөлтөөс гадна банкуудын илүүдэл нөөц буурч, БХЗ дээр нөөцийн түр хугацааны эрэлт өссөнтэй холбоотой байв. 2014 оны 8 дугаар сарын байдлаар БХЗ-ын арилжааны хүү болох репо санхүүжилтийн хүү 12.0, овернайт зээлийн хүү 12.4, ТБҮЦ-ны 2-догч захын арилжааны хүү 12.2, банк хоорондын хадгаламжийн хүү 12.6 хувь байна. Бодлогын хүү нэмэгдсэн болон Монголбанкнаас банкуудад олгосон хөтөлбөрийн зээлийн үлдэгдэл буурч байгаа тул банк хоорондын захын хүү богино хугацаанд өсөх төлөвтэй байна.

Банкуудын илүүдэл нөөцийн хэмжээ буурахын хэрээр банк хоорондын зах идэвхжиж, арилжааны тоо өснө. Банкууд банк хоорондын захаас эх үүсвэр татахдаа хадгаламж, зээлээс гадна репо санхүүжилт, овернайт болон ТБҮЦ-ны хоёрдогч захын арилжаа зэргийг ашиглах боломжтой юм. БХЗ-ын арилжааны сарын дундаж хэмжээ 2012 онд 348.1 тэрбум төгрөг байсан бол 2013 онд 417.4 тэрбум, 2014 оны эхний 8 сарын байдлаар 715.6 тэрбум төгрөг болж тус тус нэмэгдсэн байна. 2012 оны 2 дугаар хагасаас эхэлсэн төлбөрийн тэнцлийн хүндрэл одоо ч үргэлжилж байгаа нь банкуудын төгрөгийн нөөц буурах, банк хоорондын зах дээрх эх үүсвэр өнгөрсөн 3 дугаар сараас хумигдахад нөлөөлсөөр байна.


Банкууд 2012-2014 онд богино хугацааны нөөцийн хэрэгцээг банк хоорондын репо, ТБҮЦ-ны хоёрдогч захын арилжаа, банк хоорондын хадгаламжаар хангах сонирхол өндөртэй байсан нь системийн илүүдэл нөөц, ТБҮЦ-ны үлдэгдэл өндөр байсантай холбоотой байв. Гэвч 2014 оны 5 дугаар сараас банкуудын төгрөгийн нөөцийн бууралтаас хамааран хүү өсч, барьцаагүй овернайт зээлийн арилжаа БХЗ дээр идэвхжиж байна.

Банк хоорондын зах дээр хийгдэж буй нийт арилжааны хэмжээ 2014 оны 8 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулбал 90.1 тэрбум төгрөгөөр буюу 17.7 хувиар өсч, 602.1 тэрбум төгрөгт хүрчээ. БХЗ-ын нийт арилжааны 58.6 хувийг овернайт зээл, 22.3 хувийг банк хоорондын хадгаламж, 10.0 хувийг ТБҮЦ-ны хоёрдогч захын арилжаа, 9.1 хувийг банк хоорондын репо арилжаа тус тус эзэлж байна.

Шигтгээ 1. Боломжгүй гурвал юу өгүүлнэ вэ?

Дэлхийн төв банкууд 1) аливаа гадаад гүйлгээнд хязгаарлалтгүй буюу валютын орох, гарах урсгал нээлттэй, 2) үндэсний валютын нэрлэсэн ханшаа тогтвортой, 3) мөнгөний бодлогоо бусад улс орноос хараат бусаар хэрэгжүүлэхийг зорьж байсан тохиолдол олон байдаг. Мөнгөний бодлогын хараат бус байдал гэдэг нь өөр улс орноос үл хамааран дотоодын инфляцийг удирдах чадвар юм.

Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр дээрх зорилтууд өөр хоорондоо зөрчилдөх нь олон орны жишээн дээр харагдаж байсан бөгөөд 1960 онд Роберт Мюнделл, Маркус Флеминг нар эдгээр 3 зорилт нэгэн зэрэг хангагдах ямар ч боломжгүй, зөвхөн аль нэг хос зорилт л хангагдах боломжтой гэсэн үндэслэл гаргаснаар “Боломжгүй гурвал” гэсэн ойлголт бий болжээ.



Тухайлбал, Төв банк А хувилбарт хамаарах 2 зорилтыг зэрэг хэрэгжүүлэх гэвэл хараат бус мөнгөний бодлогоос татгалзах шаардлагатай болно гэсэн үг юм.

А-хувилбар: Тогтмол ханш болон Хөрөнгийн чөлөөтэй урсгал

А-хувилбарыг сонгох тохиолдолд Төв банк бие даасан хараат бус мөнгөний бодлогыг хэрэгжүүлж чадахгүй. Жишээ нь хөрөнгийн урсгал гадагшилж эхэлсэн (хөрөнгийн урсгал чөлөөтэй тул) гэж саная. Нэгэнт валют гадагшлах тул дотоодын валютын ханшид сулрах дарамт ирнэ. Ханшийг сулруулахгүйн тулд Төв банк хүүг өсгөх шаардлагатай болно. Гэтэл энэ үед бизнесийн идэвхжилийг дэмжихийн тулд хүүг бууруулах шаардлага байсан бол энэ нь эдийн засгийн өсөлтөд шууд сөргөөр нөлөөлөх болно. Эндээс Төв банк нь мөнгөний бодлогоо хараат бусаар хэрэгжүүлэх ямар ч сонголтгүй, зөвхөн дотоодын валютын ханшийг хамгаалах чиглэлд хүүгээ хөдөлгөхөөс өөр сонголтгүй болох нь харагдаж байна. Нөгөө талд ханшийн сулралтыг хүүгээр бус валютын интервенц хийх замаар зогсоох

гэж оролдож болох ч, энэ нь валютын нөөцөө алдах, улмаар ханшаа тогтмол барих гэж оролдоод нийт эдийн засгаа хямралд өртүүлэх явуур муутай үйлдэл болох юм. Ялангуяа гадаад валютын нөөц, валютын орлого багатай, урсгал тэнцэл нь алдагдалтай, үндэсний хуримтлал бүрдээгүй, эдийн засгийн дархлаа султай орны хувьд А хувилбар хэзээ ч тохирохгүй.

Б-хувилбар: Хараат бус мөнгөний бодлого ба Хөрөнгийн чөлөөт урсгал

Төв банк Б-хувилбарыг сонговол чөлөөт ханшийн дэглэмтэй байна (Тухайлбал, АНУ-ын ХНБ). Эдийн засгийн нөхцөл байдал муудсанаас шалтгаалан Төв банк мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэн, хүүний түвшинг бууруулсан гэе. Энэ тохиолдолд хөрөнгө оруулагчид өгөөж багатай дотоодын валютыг бус харин илүү өгөөжтэй гадаад валютыг илүүд үзэх тул дотоодын валютын ханш сулрах дарамттай тулгарна. Засгийн газрын хувьд эдийн засгийн өсөлт юу юунаас чухал тул хүүг бага түвшинд хадгалж ханшаа сулруулахаас өөр аргагүйд хүрнэ. Ханшийн сулралтыг зогсоохын тулд валютын нөөцөөс зарж болох ч, энэ хувилбарын хувьд интервенц нь ханшийг хамгаалахад бус, зөвхөн хэлбэлзлийг зөөлрүүлэхээр хязгаарлагдана. Иймд дотоодын валютын ханш нь эдийн засгийн суурь нөхцөлөөс хамаарч уян хатан тогтох ба ингэснээр гадаад орчны сөрөг өөрчлөлтийн дотоодын эдийн засаг дахь таагүй нөлөөллийг ханш өөртөө шингээгч нь болох юм. Хөрөнгө оруулалт ихээр шаардлагатай, нээлттэй бөгөөд чөлөөт эдийн засагтай, гадаад зах зээлээс хамаарал өндөртэй, хараат бус мөнгөний бодлого бүхий орны хувьд энэ хувилбар хамгийн тохиромжтой.

В-хувилбар: Тогтмол ханш ба Хараат бус мөнгөний бодлого

Хэрвээ Төв банк мөнгөний бодлогоо бусад улсын Төв банкнаас хараат бусаар хэрэгжүүлээд ханшаа тогтмол түвшинд барих сонирхолтой бол хөрөнгийн урсгалд зайлшгүй хязгаарлалт тогтоох шаардлагатай болно (Тухайлбал, Хятадын Төв банк). Эдийн засгийн нөхцөл байдал муудсанаас шалтгаалан Төв банк мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэн, хүүний түвшинг бууруулсан гэе. Нөгөө талаас дэлхийн санхүүгийн хямрал нь дотоодын валютын ханш сулруулах дарамтыг бий болгож болно. Энэ нөхцөлд ханшийг тогтмол барих цорын ганц арга зам нь хөрөнгийн гадагшлах урсгалыг хүчээр зогсоож хяналт тавихад оршино. Урсгал тэнцэл, улмаар төлбөрийн тэнцэл нь байнгын ашигтай байдаг, дотоодын үйлдвэрлэл, экспортын чадамж үлэмж хөгжсөн, үндэсний хуримтлал ихтэй, гадаад валютын хэрэгцээ шаардлага багатай, дархлаа сайтай эдийн засагт энэ нь байж болох хувилбар боловч манайх шиг эдийн засагт огт тохирохгүй хувилбар.


II.4 ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ, ГАДААД ЗАХ ЗЭЭЛ

II.4.1 Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2014 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн байдлаар 1,811.03 төгрөгт хүрч, тайлант оны эхнээс 7.9 хувиар буюу 132.66 төгрөгөөр суларчээ. Төлбөрийн тэнцлийн урсгал данс 2011-2013 онд ”3 жил дараалан 3 орчим тэрбум ам.долларын алдагдалтай гарч байсан бөгөөд уг алдагдлыг 2011-2012 онуудад хөрөнгө, санхүүгийн дансны ашгаар нөхөж ирсэн. Гэвч 2012 онд 4.9 тэрбум ам.доллар байсан хөрөнгө ба санхүүгийн дансны ашиг 2013 онд 1.4 тэрбум ам.доллар болж 3.5 дахин, 2014 оны эхний 8 сард ердөө 140 сая ам.доллар болж өмнөх оны мөн үеэс 6.7 дахин буурснаар урсгал тэнцлийн алдагдлыг нөхөж чадахгүйд хүрсэн. Ийнхүү төлбөрийн нийт тэнцэл 2013 онд 1.9 тэрбум ам.долларын, 2014 оны эхний 8 сард 963 сая ам.долларын алдагдалтай гарсан нь төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг сулруулах нөлөө үзүүлж байна.


Монголбанкнаас төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн огцом хэлбэлзлийг зөөлрүүлэх зорилгоор 7 хоног бүрийн Мягмар, Пүрэв гарагт гадаад валютын дуудлага худалдаа зохион байгуулж, шаардлагатай үед валютын захад ам.доллар болон юань нийлүүлж байгаа бөгөөд Монголбанкны оролцооны үр дүнд 2014 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн байдлаар төгрөгийн ам.доллартай харьцах ханш нэг өдөрт хамгийн ихдээ 1.97%-иар чангарч, 1.66%-иар суларч, нэг өдөрт ногдох дундаж хэлбэлзэл нь 0.20% байна. Мөн хугацаанд ханшийн өдрийн хэлбэлзэл нийт өдрийн 90%-д нь 0.4% дотор, үлдсэн 10%-д нь хамгийн ихдээ 1.97%-иар хэлбэлзжээ. Ханшийн нэг өдөрт ногдох дундаж хэлбэлзэл 0.20% байгаа нь 2012, 2013 оны мөн үеэс ердөө 0.02 нэгж хувиар их байна.

Зураг 18. Төгрөгийн ам.доллартай харьцах Монголбанкнаас зарласан ханш



Эх сурвалж: Монголбанк

Зураг 19. Ханшийн өдрийн хэлбэлзлийн хистограм




II.4.2 Монгол Улсын гадаад секторын төлөв байдал /өөрөөр заагаагүй бол оны эхний хагас жилийн байдлаар/

II.4.2.1 Монгол Улсын төлбөрийн тэнцэл

2014 оны эхний 7 сарын урьдчилсан гүйцэтгэлээр төлбөрийн тэнцлийн урсгал дансны алдагдал өмнөх оны мөн үеэс 50.5 хувиар буурч -946.7 сая ам.доллар, хөрөнгө ба санхүүгийн дансны ашиг 87.3 хувиар буурч 123.1 сая ам.долларт хүрсэн бөгөөд нийт төлбөрийн тэнцэл 977.7 сая ам.долларын алдагдалтай байна.


Урсгал данс: Урсгал тэнцлийн хувьд экспортын орлого өсч, импорт буурч байгаа дүр зураг ажиглагдаж, ирэх улирлуудад энэ төлөв хадгалагдахаар байна. Урсгал дансны алдагдал буурахад барааны гадаад худалдааны алдагдал өмнөх оны мөн үеэс 108.6 хувь буюу 931.9 сая ам.доллараар буурч, хувь хүмүүс, ажиллагсдын гадаад руу шилжүүлэх гуйвуулга 18 хувиар буюу 21 сая ам.доллараар буурсан нь голчлон нөлөөлжээ. Барааны гадаад худалдааны алдагдал буурахад экспорт 25 хувиар буюу 586.8 сая ам.доллараар өсч, импорт 11 хувиар буюу 345.1 сая ам.доллараар буурсан нь нөлөөлөв. Тухайлбал зэсийн баяжмалын экспорт өнгөрсөн оны мөн үеэс 152 хувиар буюу 715 сая ам.доллараар өсч, машин механизм, тоног төхөөрөмж, барилгын материал зэрэг үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалт бүхий импортын хэмжээ 12 хувиар буурчээ.

Зураг 20. Төлбөрийн тэнцэл (сая \$)




Эх сурвалж: Монголбанк

Зураг 21. Урсгал тэнцэл (сая \$)




Зураг 22. Төлбөрийн тэнцэл (тэрбум ам.доллар)



Эх сурвалж: Монголбанк


Зураг 23. Урсгал тэнцэл (тэрбум ам.доллар)




Урсгал тэнцлийн алдагдал 2009 он хүртэл харьцангуй тогтвортой бага түвшинд буюу дунджаар ДНБ-ий 6 хувьтай тэнцүү хэмжээнд байсан бол 2010 оноос эхлэн өсч, 2010 онд ДНБ-ий 14 хувь, 2011 онд 31 хувь, 2012 онд 33 хувь, 2013 онд 28 хувьд тус тус хүрсэн. Харин гадаад худалдааны алдагдал буурснаас шалтгаалан 2014 оны эхний хагас жилийн байдлаар 14.4 хувьд хүрч буураад байна.

Үйлчилгээний гадаад худалдааны алдагдал тогтвортой. Үйлчилгээний гадаад худалдааны орлого өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 5.4 хувиар буюу 21.5 сая ам.доллараар, зардал нь 1.6 хувиар буюу 18.5 сая ам.доллараар буурснаас шалтгаалан үйлчилгээний дансны алдагдал 3.0 сая ам.доллараар нэмэгдэв. Үүнд импортын бууралтаас шалтгаалан тээврийн зардлын гарах урсгал 143.2 сая ам.доллараар буурсан ч, бусад үйлчилгээний зардал 145.2 сая ам.доллараар өссөн нь голчлон нөлөөлжээ. Бусад үйлчилгээний зардлууд өссөн нь Оюутолгой ХХК-ийн зүгээс эдийн засгийн харьяат бусаас авсан үйлчилгээний төлбөрүүд нэмэгдэж, бизнесийн зөвлөх үйлчилгээний зардал 191 сая ам.доллараар өссөнтэй холбоотой байна.

Зураг 24. Барааны гадаад худалдаа (сая \$)



Зураг 25. Үйлчилгээний гадаад худалдаа (сая \$)



Эх сурвалж: Монголбанк

Орлогын дансны алдагдал тогтвортой. Монгол Улсын Засгийн газар, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж /ААН/, иргэд нь эдийн засгийн харьяат бусаас авсан гадаад зээл, өрийн бичиг болон харилцах, хадгаламжийн хүүний төлбөр, ногдол ашигт төлсөн төлбөр нь өнгөрсөн оны мөн үеэс 36 хувиар өсч 297.1 сая ам.доллар, Монгол Улсын ААН-үүдэд ажиллаж буй харьяат бус иргэдэд төлсөн цалин хөлс болон түүнтэй адилтгах орлого нь 49 хувиар буурч 79.9 сая ам.доллар болсноор орлогын дансны алдагдал цэвэр дүнгээр 1 хувиар буурч 341.2 сая ам.долларт хүрэв.

Урсгал шилжүүлгийн данс цэвэр дүнгээр өсчээ. Гадаад улс орнуудад ажиллаж, амьдарч буй иргэдээс хүлээн авсан гуйвуулга, гадаадын Засгийн газар, олон улсын байгууллагын шилжүүлсэн хандив тусламжийн дүн өмнөх оны мөн үеэс 12.9 сая ам.доллараар өсч, гадаадын улс орнууд руу шилжүүлсэн хувийн гуйвуулга, олон улсын байгууллагын гишүүнчлэлийн зардлын дүн 18.9 сая ам.доллараар буурсан нь урсгал шилжүүлгийн дансны ашиг цэвэр дүнгээр 44 хувиар өсч 105.0 сая ам.долларт хүрэхэд нөлөөлжээ.

Хөрөнгө, санхүүгийн данс. 2014 оны эхний 7 сарын урьдчилсан гүйцэтгэлээр хөрөнгө ба санхүүгийн дансны ашиг өмнөх оны мөн үеэс 87.3 хувиар буурч 123.1 сая ам.долларт хүрэв. Үүнд гадаадын шууд хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 60.1 хувиар буурч 551.1 сая ам.долларт, бусад хөрөнгө оруулалтын дансны алдагдал 81.0 хувиар өсч 841.6 сая ам.долларт хүрсэн нь голчлон нөлөөлсөн байна. Харин багцын хөрөнгө оруулалт 2014 оны эхний 7 сард 332.0 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 358.0 сая ам.доллараар өссөн хэдий ч, цаашид багцын хөрөнгө оруулалт нэмэгдэх боломж хумигдсаар байна. Учир нь олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч Стандарт энд Пүүрс, Мүүдиз агентлагууд Монгол Улсын зээлжих зэрэглэлийг 2014 оны 5, 7 дугаар сард бууруулсан. Энэ нь багцын хөрөнгө оруулалтын өртөг зардлыг нэмэгдүүлж байна. Хэдийгээр экспортын голлох бүтээгдэхүүний биет хэмжээ, мөнгөн дүн ихэссэн хэдий ч, экспортын худалдааны зээлээрх борлуулалт өмнөх оны мөн үеэс 253.8 сая ам.доллараар нэмэгдсэн, бэлэн мөнгө ба харилцах дансны алдагдал 86.7 сая ам.доллараар өссөн зэргээс шалтгаалан бусад хөрөнгө оруулалтын дансны алдагдал өмнөх оны мөн үеэс 81 хувиар өсч 841.6 сая ам.долларт хүрчээ.

Гадаад валютын нөөц. Төлбөрийн тэнцлийн алдагдлаас шалтгаалан 2014 оны 7 сарын байдлаар гадаад валютын албан нөөцийн хэмжээ 1349.2 сая ам.доллар болж, оны эхнээс 40 хувиар буурсан байна. Энэ нь валютын төлбөртэй импортын 12.1 долоо хоногийн хэрэгцээг хангахаар байгаа нь олон улсын жишиг түвшин болох 12 долоо хоногийн үзүүлэлтийг хангаж байгаа үзүүлэлт юм.

Экспорт. Өмнөх оны мөн үеэс 32.3 хувиар буюу 873.1 сая ам.доллараар өссөн. Үүнд ашигт малтмалын экспорт 33.1 хувиар, ялангуяа Оюутолгойн алт, зэсийн үйлдвэрлэл тогтворжсоноор зэсийн баяжмалын экспорт 2.1 дахин өссөн нь голлон нөлөөлсөн. Бүтээгдэхүүний тоо хэмжээний өсөлтөөс шалтгаалж экспорт 932.7 сая ам.доллараар өссөн бол үнийн бууралтаас шалтгаалж 59.6 сая ам.доллараар буурснаар нийт 873.1 сая ам.доллараар өссөн байна. Чулуун нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр, баяжмал, боловсруулаагүй нефть гэсэн голлох 4 түүхий эдийн экспорт тоо хэмжээний өсөлтөөс шалтгаалж 906.5 сая ам.доллараар өсч, үнийн бууралтаас шалтгаалж 131.6 сая ам.доллараар буурснаар цэвэр дүнгээр 774.9 сая ам.доллараар өсчээ.

Хүснэгт 9. Гадаад худалдааны эргэлт /сая ам.доллар/

	Эхний 8 сар			Өөрчлөлт	
	2014	2013	2012	14/'13	13/'12
Эргэлт	7 176	6 960	7 531	3.1%	-7.6%
Экспорт	3 576	2 703	2 872	32.3%	-5.9%
Импорт	3 599	4 257	4 660	-15.4%	-8.6%
Тэнцэл	-23	-1 554	-1 788	-98.5%	-13.1%

Зураг 29. Худалдааны нөхцөлийн индексийн жилийн өөрчлөлт /3 сарын гулсах дунджаар/



Хүснэгт 10. Экспортын барааны гүйцэтгэл - эхний 8 сар (сая ам.доллар)

	2014		2013		Өөрчлөлт	
	Тоо/хэм (мян.тн,кг)	Дүн	Тоо/хэм (мян.тн,кг)	Дүн	Дүн	%
1. Ашигт малтмал		3,126		2,348	777 ↑	33%
Чулуун нүүрс	12,225	588	9,593	693	(105) ↓	-15%
Зэсийн баяжмал	844	1,450	395	563	887 ↑	158%
Төмрийн хүдэр/баяж.	3,761	289	4,327	442	(153) ↓	-35%
Боловсруулаагүй нефть	4,441	443	3,052	298	146 ↑	49%
Цайрын хүдэр ба баяж.	69	76	86	80	(4) ↓	-5%
Мөнгөжөөгүй алт	5,126	214	4,727	195	19 ↑	10%
Жонш, лейцит, нефелинт	207	47	221	56	(10) ↓	-17%
Молибдений хүдэр/баяж	2	18	3	21	(3) ↓	-13%
2. Ноос, ноолуур		247		211	36 ↑	17%
Ямааны угаа.ноолуур	3,834	213	3,915	181	32 ↑	18%
Ямааны сам.ноолуур	347	34	309	30	4 ↑	14%
3. Бусад		204		144	59 ↑	41%
Нийт дүн		3,576		2,703	873 ↑	32%


Эх сурвалж: Монголбанк

Эдгээр 4 бүтээгдэхүүний экспорт ашигт малтмалын экспортын 88.6 хувь, нийт экспортын 77.5 хувийг бүрдүүлсэн байна. Сүүлийн жилүүдэд дунджаар 20 хувийн өсөлттэй байсан БНХАУ-ын коксжих нүүрсний импорт 2014 оны эхний 6 сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 12 хувиар буурсан. Тайлант хугацаанд БНХАУ-ын коксжих нүүрсний эрэлт өмнөх онтой ижил түвшинд байсан ба тус улс нь дотоодын коксжих нүүрсний үйлдвэрлэлээ нэмэгдүүлснээр импорт ийнхүү буурсан байна.

Хэдийгээр БНХАУ-ын коксжих нүүрсний нийт импорт буурсан ч, үүнд эзлэх манай орны бүтээгдэхүүний хувь хэмжээ 2013 оны огцом буурсан түвшнээс эргэн өсч, 24.3 хувьд хүрлээ. Коксжих нүүрсний экспортын биет хэмжээ 2014 оны эхний 8 сарын байдлаар 27.4 хувиар нэмэгдсэн хэдий ч, экспортын орлого 15.1 хувиар буурсан.

Импорт. 2014 оны эхний 8 сарын байдлаар нийт импортын 25.5 хувийг хэрэглээний бүтээгдэхүүн, 41.8 хувийг хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн, 11.5 хувийг аж үйлдвэрлэлийн орц, 20.9 хувийг нефтийн бүтээгдэхүүн тус тус бүрдүүлж байна.

Зураг 30. Дэлхийн түүхий эдийн зах зээл дээрх үнэ



Эх сурвалж: Блумберг

Хүснэгт 11. БНХАУ-ын түүхий эдийн импорт

	Эхний 6 сар			2014/2013	2013/2012
	2014	2013	2012		
Нүүрс (сая тонн)	31.0	35.3	27.7	-12%	28%
Монгол	24%	17%	34%	7%	-17%
ОХУ	10%	12%	9%	-2%	3%
Зэс (сая тонн)	5.4	4.5	3.4	22%	32%
Монгол	6%	6%	8%	1%	-3%
Төмрийн хүдэр (мян.т)	457.4	384.5	367.0	19%	5%
Монгол	1%	1%	1%	0%	0%
Түүхий нефть (мян.т)	152.0	138.2	140.1	10%	-1%

Эх сурвалж: Блумберг, YCX

Хүснэгт 12. Импортын барааны гүйцэтгэл - эхний 8 сар (сая ам.доллар)

Төрөл	2014		2013		Өөрчлөлт	
	Дүн	%	Дүн	%	Дүн	%
Хэрэглээний бүтээгдэхүүн	918	26%	1,004	24%	(86) ↓	-9%
Түргэн эдэлгээтэй	486	14%	490	12%	(4) ↓	-1%
Удаан эдэлгээтэй	432	12%	514	12%	(82) ↓	-16%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	1,503	42%	2,022	48%	(519) ↓	-26%
Машин, механик тоног төхөөрөмж	791	22%	1,347	32%	(556) ↓	-41%
Барилгын материал	557	15%	508	12%	50 ↑	10%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	155	4%	168	4%	(13) ↓	-8%
Аж үйлдвэрлэлийн орц	415	12%	374	9%	41 ↑	11%
Хүнсний орц	25	1%	13	0%	11 ↑	84%
Химийн бүтээгдэхүүн	63	2%	66	2%	(3) ↓	-4%
Даавуу, утас, арьс, савхин эдлэл	10	0%	14	0%	(4) ↓	-30%
Цахилгаан эрчим хүч	104	3%	56	1%	48 ↑	85%
Металлын хүдэр, баяжмал болон хаягдал	0	0%	0	0%	0 ↑	69%
Бусад аж үйлдвэрлэлийн зориулалтат	213	6%	224	5%	(11) ↓	-5%
Нефтийн бүтээгдэхүүн	752	21%	853	20%	(102) ↓	-12%
Дизель түнш	421	12%	506	12%	(85) ↓	-17%
АИ-92, АИ-95	214	6%	197	5%	17 ↑	9%
А-80 болон бусад	117	3%	151	4%	(33) ↓	-22%
Бусад	11	0%	3	0%	9	
Нийт дүн	3,599		4,257		(658) ↓	-15%

Эх сурвалжууд: Монголбанкны тооцоолол, ГЕГ


Удаан эдэлгээтэй хэрэглээний бүтээгдэхүүний импорт өмнөх оны мөн үеэс 15.9 хувиар буурч, түүний дотор автомашин, түүний сэлбэг хэрэгсэл 23.9 хувиар, гэр ахуйн цахилгаан хэрэгсэл, тавилга 9.4 хувиар тус тус буурсан нь төгрөгийн гадаад валюттай харьцах нэрлэсэн үйлчилж буй ханш (NEER) оны эхнээс 7 хувиар суларсантай нийцтэй байна.

Нефтийн бүтээгдэхүүний импорт эхний 8 сарын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11.9%-иар буюу 102 сая ам.доллараар буурсан ба уг бууралтад дизель түлшний импорт буурсан нь голлон нөлөөлсөн. 2014 оны эхнээс ГШХО үргэлжлэн буурсан, экспортын бараа бүтээгдэхүүний хуримтлагдсан нөөц өндөр байсан зэрэг нь аж үйлдвэрлэлийн шинж чанартай гол нефтийн хэрэглээ болох дизель түлшний импорт буурахад нөлөөлжээ.

2014 он гарсаар гадаад, дотоод хүчин зүйлсээс шалтгаалан гадаадын шууд хөрөнгө оруулалт 70 хувиар буурсан, томоохон төсөл хөтөлбөрүүдийн импортод үзүүлэх нөлөө өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 дахин бага байснаас шалтгаалан хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 2014 оны эхний 8 сарын байдлаар 25.7 хувиар буурсан.

Харин аж үйлдвэрлэлийн орцын импорт 10.9%-иар буюу 41 сая ам.доллараар өссөн нь ерөнхий ангиллуудын хувьд өсөлттэй гарсан ганц бүлэг болж байна. Энэ нь цахилгаан эрчим хүчний импортын өсөлтөөр голлон тодорхойлогдож байна. Оюутолгойн зэс, алтны уурхайн үйл ажиллагаа жигдэрснээр 2013 оны 5 сараас эхлэн эрчим хүчний импорт огцом нэмэгдсэн байна.

Зураг 31. Импортын барааны задаргаа /улирлын нөлөөллийг засварласнаар/



Эх сурвалж: ГЕГ, Монголбанкны 2014 оны 5 сард шинэчилсэн ангилал

Манай орны импортын барааны бүтэц улирлын нөлөөллөөс шалтгаалан харилцан адилгүй байдаг тул уг нөлөөллийг засварлав. 2008-2009 оны хямралын үед төгрөгийн ам.доллартай харьцах ханш 3 сарын дотор 40%-иар суларсны зэрэгцээ гадаад цэвэр активын 2008 оны бууралтыг даган дотоод цэвэр актив 2009 онд буурч, 2009 онд ДНБ -1.3 хувиар унаж, эдийн засгийн хямрал болж байв. Харин 2013-2014 онд төгрөгийн ам.доллартай харьцах ханш 18 сарын хугацаанд 30 орчим хувиар суларсны зэрэгцээ гадаад цэвэр активын 2013 оны огцом уналтыг дагаж дотоод цэвэр активыг бууруулаагүй тул эдийн засгийн бодит өсөлт саарсан хэдий ч, эерэг утгатай хэвээр байна. Үүнтэй уялдан импорт 2009 оных шиг огцом бус алгуур буурч байгаа юм.

II.4.3 Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц

Монгол Улсын Гадаад хөрөнгө оруулалтын позиц (цэвэр) 2014 оны 2-р улирлын эцэст -22,785.8 сая ам.доллар болов. Энэ нь гадаадын шууд хөрөнгө оруулалт болон бусад хөрөнгө оруулалт, ялангуяа томоохон компаниудын хөрөнгө оруулагчаасаа авсан зээлээс голлон шалтгаалж байна.

Гадаад актив. Монгол Улсаас эдийн засгийн харьяат буст оруулсан хөрөнгө оруулалтын дүн 2014 оны 2 дугаар улирлын байдлаар 3,135.8 сая ам.доллар байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад энэхүү үзүүлэлт нь 32 хувиар буюу 1.5 тэрбум ам.доллараар буурсан бөгөөд үүнд нөөц болон багцын хөрөнгө оруулалтын активын бууралтууд голлох нөлөөг үзүүлж байна. Нийт гадаад активын 42 хувийг гадаад валютын улсын нөөц, 40 хувийг бусад хөрөнгө оруулалт, 9 хувийг багцын хөрөнгө оруулалт, үлдсэн 8 хувийг шууд хөрөнгө оруулалтын активууд тус тус бүрдүүлж байна.


Хүснэгт 13. Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц – 2014 оны 2-р улирлын байдлаар
(сая ам.доллар)

А. ГАДААД АКТИВ	3,135.8	Б. ГАДААД ПАССИВ	25,921.6
1. Шууд хөрөнгө оруулалт (гадаад руу)	265.5	6. Шууд хөрөнгө оруулалт (гадаадаас)	16,677.4
1.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө оруулалт	258.4	6.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө оруулалт	6,003.0
1.2 Бусад хөрөнгө	7.1	6.2 Бусад хөрөнгө	10,674.5
2. Багцын хөрөнгө оруулалт	291.0	7. Багцын хөрөнгө оруулалт	2,876.1
2.1 Хөрөнгийн хувьцаа	265.8	7.1 Хөрөнгийн хувьцаа	86.9
2.2 Өрийн бичиг	25.2	7.2 Өрийн бичиг	2,789.3
3. Санхүүгийн дериватив	4.9	8. Санхүүгийн дериватив	4.9
4. Бусад хөрөнгө оруулалт	1,256.8	9. Бусад хөрөнгө оруулалт	6,363.1
4.1 Худалдааны зээл	572.1	9.1 Худалдааны зээл	548.8
4.2 Зээл	6.3	9.2 Зээл	4,551.8
4.2.1 Төв банк	0.0	9.2.1 Төв банк	75.3
4.2.2 Засгийн газар	0.0	9.2.2 Засгийн газар	2,172.0
4.2.3 Банк санхүүгийн байгууллага	4.1	9.2.3 Банк санхүүгийн байгууллага	698.0
4.2.4 Аж ахуйн нэгж	2.3	9.2.4 Аж ахуйн нэгж	1,606.5
4.3 Бэлэн мөнгө ба харилцах	678.4	9.3 Бэлэн мөнгө ба харилцах	135.6
4.4 Бусад актив	0.0	9.4 Бусад пассив	1,127.0
5. Нөөц актив	1,317.5	В. ПОЗИЦ	(22,785.8)
5.1 Мөнгөжсөн алт	106.5	10. Шууд хөрөнгө оруулалт (цэвэр)	(16,411.9)
5.2 Зээлжих тусгай эрх	66.4	11. Багцын хөрөнгө оруулалт (цэвэр)	(2,585.2)
5.3 ОУВС-д байршуулсан хөрөнгө (цэвэр)	0.2	12. Санхүүгийн дериватив (цэвэр)	0.1
5.4 Бэлэн валют ба харилцах	820.9	13. Бусад хөрөнгө оруулалт (цэвэр)	(5,106.3)
5.5 Үнэт цаас	323.6	14. Нөөц актив	1,317.5
5.6 Санхүүгийн дериватив (цэвэр)	0.0		
5.7 Бусад нөөц актив	0.0		

Эх сурвалж: Монголбанк

Гадаад пассив. Монгол Улсын эдийн засгийн харьяатад гадаадаас оруулсан хөрөнгө оруулалтын дүн 25,921.6 сая ам.долларт хүрчээ. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 16 хувиар буюу 3.5 тэрбум ам.доллараар өссөн үзүүлэлт бөгөөд үүнд шууд хөрөнгө оруулалт болон бусад хөрөнгө оруулалтын өсөлт нь голлох нөлөөг үзүүлжээ. Нийт гадаад пассивын 64 хувийг гадаадын шууд хөрөнгө оруулалт, 25 хувийг бусад хөрөнгө оруулалт, үлдсэн 11 хувийг багцын хөрөнгө оруулалтын пассив тус тус эзэлж байна. Монгол Улс дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын 64 хувь буюу 10,674.5 сая ам.долларыг толгой компаниас авсан зээл, 36 хувийг буюу 6,003 сая ам.долларыг хувь нийлүүлэгчийн дүрмийн сан дахь хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

Зураг 32. Гадаад актив



Эх сурвалж: Монголбанк

Зураг 33. Гадаад пассив



II.4.4 Монгол Улсын нийт гадаад өр

Монгол Улсын нийт гадаад өр 2014 оны 2-р улирлын байдлаар 19,826.9 сая ам.долларт хүрч 2013 оны мөн үеэс 14%-иар буюу 2.4 тэрбум ам.доллараар өссөн байна. Үүнд банкны салбар болон бусад хөрөнгө оруулалтын гадаад зээлийн өсөлт голчлон нөлөөлж байна.

Хүснэгт 14. Нийт гадаад өрийн үлдэгдэл

Үзүүлэлт	6/30/2013	6/30/2014	YoY, %
Нийт гадаад өр	17,389.5	19,826.9	14%
I. Засгийн газар	4,212.1	4,488.7	7%
II. Төв банк	481.2	1,040.3	116%
III. Банк	1,212.9	1,458.5	20%
Богино хугацаат	61.3	214.6	250%
Урт хугацаат	1,151.5	1,244.0	8%
IV. Бусад сектор	1,653.2	2,164.9	31%
Богино хугацаат	457.3	457.0	0%
Урт хугацаат	1,195.9	1,707.9	43%
V. Хөрөнгө оруулагч зээл	9,830.1	10,674.5	9%

Эх сурвалж: Монголбанк

Зураг 34. Гадаад өрийн үлдэгдэл



Улсын салбар: 2014 оны 2 дугаар улиралд Засгийн газрын гадаад өр 4.5 тэрбум долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 7 хувиар буюу 277 сая ам.доллараар өссөн байна. Энэхүү өсөлтөд МУ-ын Засгийн газрын баталгаат Самурай бонд голлох нөлөөг үзүүлжээ. Харин Монголбанкны богино хугацаат гадаад өр өнгөрсөн оны мөн үеэс 559.1 сая ам.доллараар нэмэгдэж 1,040.3 сая ам.долларт хүрэхэд Хятадын Ардын банктай хийсэн своп хэлцлийн ашиглалт нөлөөлжээ. Засгийн газрын болон түүний баталгаатай гадаад өр 2013 оны ДНБ-ий 36 хувьтай тэнцүү байна.

Хувийн хэвшил: Банк, бусад сектор, хөрөнгө оруулагчийн зээлийг бүхэлд нь хувийн хэвшлийн салбарын гадаад өр гэж ойлгох бөгөөд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 13 хувиар буюу 1.6 тэрбум ам.доллараар нэмэгдэж 14,297.9 сая ам.долларт хүрсэн байна.

Банкны салбарын гадаад өр. Банкны салбарын гадаад пассивын үлдэгдэл 2014 оны 2-р улирлын байдлаар 1,458.5 сая ам.долларт хүрч, оны эхнээс 12 хувиар буюу 160.4 сая ам.доллараар нэмэгджээ. Уг салбарын гадаад пассивын 33 хувийг урт хугацаат зээл, 32 хувийг бонд, өрийн бичиг, 15 хувийг богино хугацаат зээл, 11 хувийг бусад өглөг, үлдсэн 9 хувийг оршин суугч бусын харилцах, хадгаламжийн дансны өглөг тус тус бүрдүүлж байна.

Бусад (банкны бус) салбарын гадаад өр. Бусад салбарын буюу аж ахуйн нэгж, иргэдийн гадаад пассив 2014 оны 2-р улирлын эцэст 12,839.3 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны эцсийн гүйцэтгэлээс 4 хувиар буюу 450 сая ам.доллараар нэмэгдсэн. Салбарын нийт зээлийн 83 хувь буюу 10,674.5 сая ам.долларын эх үүсвэр нь аж ахуйн нэгж, байгууллагуудын гадаадын хөрөнгө оруулагчаас авсан зээл (компани хоорондын зээллэг) байна. Энэ төрлийн зээлийн эх үүсвэр нь компанийн эргэлтийн хөрөнгө, мөнгөн урсгалыг дэмжих зорилгоор олгогддог урт хугацаат санхүүжилт бөгөөд ихэнх тохиолдолд хүүгүй, хатуу мөрдөх эргэн төлөлтийн хуваарьгүй, улмаар харилцан тохиролцсоны үндсэн дээр цаашид дүрмийн санд нэмж тооцогдох боломжтой байдгаараа бусад төрлийн зээлээс ялгаатай юм.

II.4.5 Гадаад секторын 2015 оны төлөв

АНУ-ын эдийн засаг 2014 оны 1 дүгээр улиралд өмнөх улирлаас 2.9%-иар буурч, 2 дугаар улиралд 3.9%-иар өслөө. Хэдийгээр тус улсын зарим нутгаар эрс хүйтэрснээр 1 дүгээр улиралд бизнесийн идэвхжил суларсан боловч 2-р улиралд сэргэж, 6 дугаар сард ажилгүйдэл 2008 оноос хойшхи хамгийн бага түвшин 6.1%-д хүрлээ. Улмаар ажлын байр нэмэгдэж, өрхийн орлого нэмэгдснээр хувийн хэрэглээг урамшуулах тул энэ оны сүүлийн хагаст эдийн засгийн өсөлт 3%-с буурахгүй, 2014 онд 1.9%, 2015 онд 3.1%-д хүрнэ хэмээн судлаачид¹² үзэж байна. Холбооны нөөцийн банкнаас (ХНБ) эдийн засгийг дэмжих QE3 хөтөлбөрийн хэмжээг аажмаар бууруулж 2014 оны эцэс гэхэд бүрэн зогсоох, харин бодлогын хүүг 2014 онд өөрчлөхгүй, 2015 онд ажилгүйдлийн түвшин үргэлжлэн буурсан тохиолдолд хүүг 1 хувьд хүргэж өсгөх таамаглалтай байна.

Төмөр зам, орон сууцанд оруулсан төсвийн хөрөнгө оруулалтын нөлөөгөөр Хятадын эдийн засаг 2014 оны 1, 2 дугаар улиралд 7.4, 7.5%-иар өслөө. Төрийн өмчит үйлдвэрүүдийн үр ашгийг нэмэгдүүлэх, банкны секторыг үл хөдлөх хөрөнгийн үнийн уналтаас хамгаалах зорилгоор зээл олголтыг хумьж байгаа нь өсөлтөд сөргөөр нөлөөлнө. 2014 оны хувьд Хятадын Төв банк банкуудын Заавал байлгах нөөцийн хувийг бууруулан, Засгийн газар нь шаардлагатай тохиолдолд хөрөнгө оруулалтыг өсгөхөд бэлэн тул эдийн засгийн өсөлт нь 7.3%-иас доош буухгүй хэмээн эдийн засагчид үзэж байна. Харин санхүүгийн зах зээлийг чөлөөлөх, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлж, үргүй зардлыг бууруулах зэргээр эдийн засгийг илүү тэнцвэртэй төлөвт хүргэх зорилтыг Хятадын төрийн удирдлага зарласан тул эдийн засгийн өсөлт нь 2015-2016 онд 7-7.1%-д хүрч ялимгүй саарахаар байна.

Ийнхүү (i) дэлхийн голлох эдийн засгуудын нэг АНУ 2015 оноос мөнгөний бодлогоо чангатгах төлөвтэй, (ii) манай орны экспортын бараа бүтээгдэхүүний гол зах зээл¹³ БНХАУ-ын эдийн засгийн өсөлт удааширч байгаа зэргээс үзэхэд гадаад эдийн засгийн орчин талаасаа 2015 онд манай улсыг чиглэх хөрөнгө оруулалт, экспортын бүтээгдэхүүний гадаад эрэлт 2014 онтой харьцуулахад сайжрахаргүй байна.

¹² Рубини, Блумберг, EIU

¹³ 2013 оны байдлаар нийт экспортын 86.6 хувийг БНХАУ руу хийсэн.

Хүснэгт 15. Түүхий эдийн үнийн төлөв:

Түүхий эдийн төрөл	Гүйцэтгэл			Төсөөлөл				Эх сурвалж
	2012	2013	2014H1	2014f	2015f	2014f / 2013	2015f / 2014f	
Алт (\$/унц)	1668	1412	1291	1283	1283	-9%	0%	EIU
				1283	1216	-9%	-5%	Блүмберг
Цэвэршүүлсэн зэс (\$/тонн)	7947	7326	6913	6994	7000	-5%	0%	EIU
				6880	6783	-6%	-1%	IMF
				6916	6919	-6%	0%	Блүмберг
Коксжих нүүрс (\$/тонн)	256	209	160			-23%		
Төмрийн хүдэр (\$/тонн)	129	135	112	104	105	-23%	1%	Блүмберг
Түүхий нефть BRENT (\$/баррель)	112	109	109	107	104	-2%	-3%	EIU
				108	105	-1%	-3%	Блүмберг

Эх сурвалж: Блүмберг, EIU судалгааны институт

Алт. 2014 оны 6 дугаар сард Украин, ОХУ-ын маргаан ширүүсч, Иракт үймээн дэгдсэний улмаас хөрөнгө оруулагчид эрсдэл багатай санхүүгийн хэрэгсэл, алтыг ихээр худалдан авсан тул 1 унц алтны үнэ 6 дугаар сарын эцэст 1327.3 ам.долларт хүрч өссөн. Цаашид голлох эдийн засгийн инфляци төдийлөн өсөхгүй, хөгжингүй орнуудын эдийн засгийн сэргэлттэй уялдан дэлхийн эдийн засаг 2014, 2015 онд сэргэх, Холбооны нөөцийн банк 2015 оноос богино хугацаат хүүг өсгөх төлөвтэй байгаа тул 2014 оны эцэст алтны үнэ 1255\$/унц-д хүрч, 2015 онд төдийлөн өсөхөөргүй байна.

Цэвэршүүлсэн зэс. Дэлхийн нийт цэвэршүүлсэн зэсийн хэрэглээний 45 орчим хувийг дангаараа бүрдүүлдэг БНХАУ-д анх удаа корпорацийн бондын төлбөр хугацаандаа төлөгдөөгүй нь үнэт металлын захад нөлөөлж Лондонгийн металлын бирж дээрх зэсийн үнэ 3 дугаар сард огцом унаж 6440 ам.доллар/тонн-д хүрсэн. Хэдийгээр 4 дүгээр сараас эхлэн зэсийн үнэ аажмаар өсч 8 дугаар сарын эцсийн байдлаар 7008 ам.доллар/тоннд хүрсэн боловч зах зээлд нийлүүлэлтийн илүүдэлтэй байх тул зэсийн үнэ 2014 онд 6850 ам.доллар/тонн, 2015 онд 6900 ам.доллар/тонн-оос төдийлөн өсөхгүй хэмээн судлаачид үзэж байна.


Коксжих нүүрс. БНХАУ-ын зах зээлд коксжих нүүрсний гадаад, дотоод нийлүүлэлт өндөр хэвээр байгаа боловч кокс, гангийн үйлдвэрлэлээр тодорхойлогдох коксжих нүүрсний эрэлт 2014 оны эхний 6 сарын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад зөвхөн 1.5 хувийн өсөлттэй байсан тул 2014 оны эхнээс коксжих нүүрсний үнэ тогтмол унасаар байна. Манай нүүрсийг импортлогч Хятадын боомтуудад нүүрсний нөөц хангалттай их байгаа нь Монголын нүүрсний эрэлтийг бууруулж, үнийг өсгөхөөргүй байна.

Түүхий нефть. 2014 онд түүхий нефтийн үйлдвэрлэл 2.5%, хэрэглээ 1.3-1.7%-иар өсөхөөр байна. Ойрхи Дорнодод үүсээд буй улс төрийн хурцадмал байдлын улмаас түүхий нефтийн үнэ сүүлийн саруудад өсч, ойрын хугацаанд дээрх асуудал нааштай шийдэгдэхээргүй байгаа тул 2014-2015 онд түүхий нефтийн үнэ 100\$-оос буухааргүй байна.

II.5 ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ

Ажил эрхлэлт: 2014 оны 2-р улиралд өмнөх оны мөн үеэс 2.9%-иар, ажиллах хүчний оролцооны түвшин 10%-иар буурсан нь эдийн засгийн мөчлөг буурах үед байгааг харуулж байна. Ажил эрхлэлт ийнхүү буурч байгаа нь хувийн хэрэглээнд сөргөөр нөлөөлнө. Үүнд үйлчилгээний салбар дахь ажил эрхлэлт 6.5%-иар буурсан нь голчлон нөлөөлөв. Аж үйлдвэрийн салбарын ажил эрхлэлт өмнөх оноос 0.4%-иар буурахад боловсруулах үйлдвэрлэлийн ажиллагсад 15.0 мянган ажилтнаар буурч, харин барилга, эрчим хүчний салбарын ажиллагсад өслөө. Ажилгүй иргэд өмнөх оны мөн үеэс 12.5 мянгаар өсч, ажилгүйдлийн түвшин 1.1 нэгж хувиар нэмэгдлээ. Эрэлт буурсаар байгаа нь ажлын байр цөөрч, ажилгүйдлийг улам эрчимжүүлж болзошгүй байна.

Зураг 35. Ажил эрхлэлт, салбараар



Эх сурвалж: УСХ


Хүснэгт 16. Хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүд

Он	2012				2013				2014	
Улирал	I	II	III	IV	I	II	III	IV	I	II
Ажиллагсад	1034.0	1058.4	1115.2	1018.2	1032.5	1135.3	1086.5	1038.2	1051.9	1102.8
өсөлт	0.9%	1.5%	5.5%	-0.8%	-0.1%	7.3%	-2.6%	2.0%	1.9%	-2.9%
Ажилгүй иргэд	118.8	96.9	75.3	87.8	106.1	88.9	89.5	87.2	108.7	101.4
өсөлт	22.3%	18.3%	-17.8%	13.4%	-10.7%	-8.3%	18.9%	-0.6%	2.5%	14.1%
Ажиллах хүчний оролцооны түвшин, %	64.6	63.6	64.3	61.6	61.5	63.7	62.1	60.9	56.4	57.3
өөрчлөлт	5.2	1.5	-0.5	-2.6	-3.1	0.1	-2.2	-0.7	-5.1	-6.4
Ажилгүйдлийн түвшин, %	10.3	8.4	6.3	7.9	9.3	7.3	7.6	7.8	9.4	8.4
өөрчлөлт	1.6	1.1	-1.7	0.9	-1.0	-1.1	1.3	-0.1	0.1	1.1

Эх сурвалж: УСХ

Цалин: Нэрлэсэн цалин 2014 оны 1-р улиралд 10.2%-иар өсч, бодит цалин 2%-иар буурлаа. Энэ нь иргэд хэрэглээгээ хумих, улмаар өсөлтөд сөргөөр нөлөөлөх хүчин зүйл болох юм. Улсын дундаж нэрлэсэн цалин 2014 оны 1-р улиралд өмнөх оноос 10.2%-иар өсч 762900 төгрөг болжээ. Үүнийг эдийн засгийн салбарын ангиллаар авч үзвэл хөдөө аж ахуй 155%, уул уурхай 62%, цахилгаан, хий, уур 67%-ийн өсөлттэй байгаа бол санхүү даатгалын үйл ажиллагаа 18%, мэдээлэл холбоо 6%, боловсрол 3%-ийн бууралттай байна. 2014 оны 2-р улиралд инфляцийн түвшин нэрлэсэн цалингийн өсөлтөөс давж гарахаар байгаа тул бодит цалингийн өсөлт дахин сөрөг гарч болзошгүй байна.

Зураг 36. Нэрлэсэн цалин, салбараар




II.6 БАНКНЫ САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Санхүүгийн салбар: Хөгжингүй орнуудтай харьцуулахад бага, дунд орлоготой улс орнуудын санхүүгийн систем нь ихэвчлэн банк төвтэй байдаг. Энэ нь ч тухайн улсын засаглал, институцийн чанар, эдийн засгийн бүтэц, хууль эрх, зүйн орчин зэрэг нийтлэг суурь шалтгаантай юм. Манай Улсын хувьд санхүүгийн системийн 90 гаруй хувийг банкны салбар дангаар бүрдүүлж, санхүүгийн зах зээл хөгжлийнхөө эхэн үед явж байна. Тухайлбал, 2014 оны эхний улирлын байдлаар нийт бүртгэлтэй 289 Банк бус санхүүгийн байгууллага, 140 Хадгаламж зээлийн хоршоо, 86 Брокер диллерийн байгууллага, 17 Даатгалын компани, 315 Хувьцаат компани үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тэдгээрийн тоо жил ирэх бүр нэмэгдэж, үйл ажиллагааных нь цар хүрээ тэлсээр байгаа ч, санхүүгийн зах зээлд банкны салбартай харьцуулахад бага хувийг эзэлсэн хэвээр байна.

Санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх, зохистой хэм хэмжээнд төлөвшүүлэх нь урт хугацаанд тогтвортой бөгөөд тэнцвэртэй эдийн засгийн өсөлтийн суурийг бүрдүүлэхэд шийдвэрлэх үүрэгтэй юм. Цаашид санхүүгийн тогтвортой байдлыг хангах асуудалд дан ганц мөнгөний бодлого, банкны салбарыг тойрсон асуудлаар хандах бус санхүүгийн дэд салбарууд дахь тэнцвэртэй хөгжил, урт хугацаанд эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад чиглэсэн үр ашигтай, харилцан уялдаатай макро болон микро түвшний бодлогууд, нийгэм, эдийн засгийн хөгжлийн зорилттой уялдсан санхүүгийн институци, дэд бүтцийн оновчтой шаг дараалсан реформ, олон нийтийн санхүүгийн салбарын талаарх ойлголт, төлөвшилийг хамарсан санхүүгийн тогтвортой байдлын ерөнхий хүрээ байдлаар авч үзэх нь зүйн хэрэг юм. Дэлхий нийтэд ч энэ хандлага хүрээгээ тэлсээр байна.

Санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилтын хүрээнд тодорхой арга хэмжээнүүдийг Монголбанк бодлогын шийдвэртээ тусгахын зэрэгцээ нийт санхүүгийн системийн хувьд тулгамдаж буй зарим асуудлыг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн хурлаар тухай бүрт нь авч хэлэлцэн, зохих шийдвэр, зөвлөмжийг гарган ажилласаар байна.


Зураг 37. Нийт хөрөнгийн хэмжээ (тэрбум төгрөг) ба хөрөнгөөр тооцсон салбарт эзлэх хувь хэмжээ



Эх сурвалж: Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо.

Тэмдэглэл: Үнэт цаасны оролцогч компаниудын хөрөнгийг тооцохдоо андеррайтерын үйл ажиллагаа явуулж буй Голомт банкны хөрөнгийг хасч тооцсон.

Зураг 38. Азийн бүрэлдэж буй болон хөгжиж буй эдийн засагтай зарим орнуудын санхүүгийн гүнзгийрэлт (хувиар)¹⁴



Эх сурвалж: Дэлхийн банк, ОУВС.

Тэмдэглэл: Хувийн сектор олгосон зээл/ДНБ, мөнгө (M2)/ДНБ харьцааг тус бүр тооцохдоо харгалзан 2011 ба 2012 оны эцсийн байдлаарх тоог ашигласан.

Олон нийтийн санхүүгийн салбарын талаарх ойлголтыг гүнзгийрүүлэх, санхүүгийн

¹⁴ M2/ДНБ, хувийн салбарт олгосон зээл/ДНБ нь санхүүгийн гүнзгийрэлтийг хэмжихэд түгээмэл ашиглагддаг үзүүлэлтүүд юм. BGD-Бангладеш, BTN-Бутан, BRN-Бруней, KHM-Камбож, CHN-БНХАУ, FJI-Фижи, IND-Энэтхэг, IDN-Индонез, MYS-Малайз, MDV-Мальдив, MNG-Монгол, NPL-Непал, PNG-Папуа-Шинэ Гвиней, PHL-Филиппин, WSM-Самоа, SLB-Соломоны арлууд, LKA-Шри-Ланка, TNA-Тайланд, TMP-Тимор-Лесте, TON-Тонга, VUT-Вануату, VNM-Вьетнам.

салбарын талаарх бодит мэдээллийг нийтэд тэгш, цаг тухайд нь хүргэж, бодит хүлээлтийг төлөвшүүлэх замаар санхүүгийн салбарт итгэх итгэлийг нэмэгдүүлэх, түүний тогтвортой байдлыг хангах зорилтын хүрээнд Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс “Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлын тайлан”-г хагас жил тутам гаргахаар шийдвэрлэсний дагуу эхний гурван дугаарыг бэлтгэж, олон нийтийн хүртээл болгоод байна.

Банкны салбарын тогтвортой байдлын хүрээнд:


Банкны системийн өнөөгийн байдал

Банкны системээр нийт активын хэмжээ 2014 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар 19.6 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 19.6 хувиар өссөн бөгөөд нийт активын 60.7 хувийг зээл, 18.4 хувийг мөнгөн хөрөнгө, 8.9 хувийг урт хугацаат хөрөнгө оруулалт, 6.4 хувийг богино хугацаат хөрөнгө оруулалт, үлдэх 5.6 хувийг бусад хөрөнгө тус тус бүрдүүлжээ.


Банкны системийн голлох актив болох зээлийн хэмжээ 2014 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар 11.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 26 хувиар өсчээ. Нийт зээлийн 92.5 хувь болох 11.2 их наяд төгрөгийн зээл хэвийн ангилалд, 4.3 хувь болох 524.3 тэрбум төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн ангилалд, 3.2 хувь болох 384 тэрбум төгрөгийн зээл чанаргүй ангилалд ангилагдсан байна.

Зээлийн чанар банкны системийн хэмжээнд 2011 оноос эхлэн сайжирч, чанаргүй зээлийн хэмжээ тогтвортой буурч байсан бол 2013 оны дунд үеэс эхлэн зээлийн чанар муудах хандлага ажиглагдаж байна. Тухайлбал, нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 90.9 хувь буюу 182.8 тэрбум төгрөгөөр, өмнөх сараас 23.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Зээлийн чанарт нөлөөлж буй гол шалтгаан нь төлбөрийн тэнцлийн хямралт нөхцөл байдлаас шалтгаалж төгрөгийн гадаад валюттай харьцах ханш суларсантай холбоотой бөгөөд тайлант сарын эцсийн байдлаар валютын чанаргүй зээл 5.7 хувьд хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 2.0 нэгж хувиар нэмэгдсэн байна. Төгрөгөөр олгосон зээлийн чанарын үзүүлэлт харьцангуй тогтвортой буюу 2.4 хувьтай байна. Түүнчлэн чанаргүй зээлийн жилийн өсөлт харьцангуй өндөр гарсан шалтгаан нь 2013 оны 7 дугаар сарын 22-ны өдөр Хадгаламж банкинд эрх хүлээн авах арга хэмжээ авч тодорхой хэмжээний зээл чанаргүйд ангилагдсантай холбоотой.


Зураг 39. Зээлийн өрийн үлдэгдэл (салбараар)



Зураг 40. Чанаргүй зээлийн хувийн жин




Зураг 41. Чанаргүй зээлийн хувийн жин (салбараар)



Эх сурвалж: Монголбанк

Зээлийн үлдэгдлийг эдийн засгийн салбараар авч үзвэл үл хөдлөх хөрөнгийн салбарт 19.2 хувь буюу 2.3 их наяд төгрөг, бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарт 15.5 хувь буюу 1.9 их наяд төгрөг, барилгын салбарт 14.2 хувь буюу 1.7 их наяд төгрөг, уул уурхайн салбарт 10.7 хувь буюу 1.3 их наяд төгрөгийн үлдэгдэлтэй байна. Зээл олгосон гол салбаруудын чанарын үзүүлэлтээс дүгнэхэд гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын орчноос шалтгаалан уул уурхайн болон боловсруулах салбарын чанаргүй зээлийн хувь бусад салбаруудтай харьцуулахад харьцангуй өндөр буюу харгалзан 7.6 болон 5.1 хувьд хүрчээ. Харин нийт зээлийн 20 орчим хувийг бүрдүүлж буй үл хөдлөх хөрөнгийн салбарт олгосон орон сууцны зээлийн чанар сайн байна.


Зураг 42. Банкны салбарын эх үүсвэрийн бүтэц




Эх сурвалж: Монголбанк

Банкны салбарын нийт эх үүсвэрийн 17.0 хувийг харилцах, 41.0 хувийг хадгаламж, 28.4 хувийг банк санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр, 13.5 хувийг бусад эх үүсвэр бүрдүүлж байна. Харилцах, хадгаламжийн үлдэгдэл 2014 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар 10.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 10.0 хувиар буюу 923.9 тэрбум төгрөгөөр нэмэгджээ. Нийт харилцах, хадгаламжийн 54.6 хувийг хугацаатай хадгаламж, 16.0 хувийг хугацаагүй хадгаламж, 29.4 хувийг харилцах тус тус эзэлж байна. Нийт хадгаламжийн 65.7 хувийг бүрдүүлж буй иргэдийн хадгаламжийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 567.7 тэрбум төгрөг буюу 13.7 хувиар нэмэгдэж 4.7 их наяд төгрөгт хүрсэн бол хувийн хэвшлээс бүрдүүлсэн хадгаламжийн хэмжээ 411.1 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 56.4 тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

Зураг 43. Банкны салбарын өөрийн хөрөнгийн хүрэлцээ



Зураг 44. Банкны салбарын ТТГЧ-ын харьцаа



Эх сурвалж: Монголбанк

Банкны салбарын эрсдэл даах чадварыг тодорхойлдог өөрийн хөрөнгийн хэмжээ 2014 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар 2.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 36.9 хувь буюу 550.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн. Банкны салбарын нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 12.2 хувь, нийт өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 16.8 хувь байгаа нь Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтээс харгалзан 3.2 нэгж хувь болон 4.8 нэгж хувиар тус тус дээгүүр байгаа бөгөөд эдгээр үзүүлэлтүүд өнгөрсөн оны мөн үеэс харгалзан 1.0 нэгж хувь болон 1.2 нэгж хувиар нэмэгдсэн байна.

Банкны системийн төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа 2014 оны эхний хагас жилийн байдлаар 36.5 хувьд хүрсэн нь Монголбанкнаас тогтоосон шалгуур үзүүлэлтээс 11.5 нэгж хувиар дээгүүр байна. Банкууд хөрвөх чадвар сайтай эрсдэлгүй санхүүгийн хэрэгсэлд хийх хөрөнгө оруулалтын хэмжээгээ нэмэгдүүлсэнтэй уялдан тус үзүүлэлт 2012 оны эцсээс тогтвортой нэмэгдэж, харин 2014 оны 1 дүгээр улирлаас эхлэн аажмаар буурах хандлагатай болж байна. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлтийн өөрчлөлтөд Төв банкны үнэт цаасны худалдан авалт буурсан нь нөлөөлсөн болно.

Банкны системийн тогтвортой байдал, төлбөрийн чадварыг хадгалах хүрээнд банкуудын актив, зээлийн өсөлттэй уялдуулах арга хэмжээг Монголбанкнаас үргэлжлүүлэн авч хэрэгжүүлж байна. Тухайлбал, 2013 оны 6 дугаар сард банкуудад тавигдах өөрийн хөрөнгийн хүрэлцээний шаардлагыг нэмэгдүүлэн нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцааг 9 хувь, нийт өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцааг 12 хувиар тогтоон хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна. Банкны системийн нийт өөрийн хөрөнгө 2014 оны 8 дугаар сарын эцэст 2 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 36.9 хувиар өссөн нь эрсдэлтэй актив болох зээлийн өсөлтөөс илүүтэйгээр нэмэгдсэн байна. Үүнээс гадна системд нөлөө бүхий банкны нэмэлт өөрийн хөрөнгийн шаардлагыг 2 нэгж хувиар дээгүүр тогтоон нийт өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцааг 14 хувьд хүргэж, хэрэгжилтэд нь тогтмол хяналт тавин ажиллаж байна. Системд нөлөө бүхий банкуудаар 2014 оны хоёрдугаар улирлаас эхлэн Төрийн банк болон Улаанбаатар хотын банкуудыг шинээр тодорхойлсноор нийт зургаан банк (ХААН банк, Худалдаа хөгжлийн банк, Голомт банк, Хасбанк, Төрийн банк болон Улаанбаатар хотын банк) энэхүү ангилалд хамрагдаад байна. Эдгээр системд нөлөө бүхий банкууд системийн 90-ээс дээш хувийг эзэлж байгаа бөгөөд нийт активын 93.5

хувийг, пассивын 93.4 хувийг, зээлийн 93.7 хувийг, салбар нэгжийн тооны 91.2 хувийг, ажилтан албан хаагчдын тооны 91.4 хувийг тус тус бүрдүүлж байна.

Банкны системд валютаар олгосон зээлийн эрсдэл нэмэгдэж байгаатай холбогдуулан банкны төлбөрийн чадварыг хадгалах, системд үүсч болзошгүй эрсдэлийг бууруулах, гадаад валютын орлогогүй зээлдэгчийг ханшийн эрсдэлээс хамгаалах зорилгоор Монголбанкнаас тодорхой арга хэмжээ хэрэгжүүлж эхлээд байгаа бөгөөд 2014 оны 7 дугаар сард “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-д нэмэлт өөрчлөлт оруулсан болно. Энэхүү өөрчлөлтөөр ханшийн эрсдэлтэй зээлдэгчийг тодорхойлон, түүнд олгосон зээлийн эрсдэлээр жигнэх хувийг 20 нэгж хувиар нэмэгдүүлэхээр шийдвэрлэж, 2015 оноос мөрдүүлэхээр зохицуулсан. Дээрх арга хэмжээний үр дүнд банкны системийн эрсдэл даах чадвар нэмэгдэхийн зэрэгцээ банкуудын ханшийн эрсдэлтэй зээлдэгчид зээл олгох сонирхлыг бууруулж, төгрөгийн орлоготой зээлдэгчдийг валютын ханшийн эрсдэлээс хамгаалах зохицуулалт бий болно. Мөн валютын захад оролцогчдыг ханшийн эрсдэлээс хамгаалах санхүүгийн үүсмэл хэрэгслийн хэлцлийг идэвхжүүлэх давуу талтай.

Зээлийн чанар муудах эрсдэлээс урьдчилан сэргийлж, банкны системийн эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх зорилгоор Монголбанкнаас “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулах, зарцуулах журам”-д нэмэлт өөрчлөлт оруулан, шинээр олгосон зээлд 1 хувийн эрсдэлийн сан байгуулах зохицуулалтыг нэмж орууллаа. Ингэснээр банкуудын эрсдэл даах чадварыг банкуудын үйл ажиллагаанд хэт дарамт учруулахгүйгээр нэмэгдүүлэх, үүсч болзошгүй гэнэтийн алдагдлын тодорхой хэсгийг барагдуулах боломж бүрдсэн. Одоогоор эрсдэлийн санд хуримтлуулсан хөрөнгө нь нийт чанаргүй зээлийн 63 орчим хувь байгаа бөгөөд ирэх 1 жилийн хугацаанд тус санд хуримтлагдах хөрөнгө нь чанаргүй зээлийн хэмжээг бүрэн хангана гэж тооцоолсон болно.

Банкууд Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг цаашид хэрхэн хангах, банкны үйл ажиллагаа болон эдийн засгийн нөхцөл байдлаас үүсч болзошгүй эрсдэлийг урьдчилан илрүүлэх зорилгоор Монголбанк зээл, зээлийн төвлөрөл, ханш, хөрвөх чадварын эрсдэлийн мэдрэмтгий байдлын шинжилгээг нийт банкны систем болон банк тус бүрийн хувьд тогтмол гүйцэтгэн, банкуудын санхүүгийн байдал, эрсдэл даах чадварт тогтмол үнэлгээ хийж, шинжилгээний үр дүнг цаашид баримтлах бодлогод тусган ажиллаж байна. Түүнчлэн банкуудын эрсдэлийн удирдлагыг сайжруулах зорилгоор Монголбанкнаас мэдрэмтгий байдлын шинжилгээний загвар болон аргачлалыг боловсронгуй болгох талаар ажиллаж байна.

Шигтгээ 3. Эрсдэлийн үнэлгээнд суурилсан хяналт шалгалтын талаар

Санхүүгийн байгууллагуудад хийх хяналт шалгалтыг тухайн улсын холбогдох эрх бүхий байгууллага гардан хэрэгжүүлдэг бөгөөд хэлбэрийн хувьд *газар дээрх* болон *зайны* гэж ангилдаг бол аргачлалын хувьд *гүйцэтгэлд суурилсан* болон *эрсдэлд суурилсан* байдлаар хэрэгжүүлдэг. Газар дээрх шалгалт нь тухайн банкны өмнөх хугацаанд гаргасан алдааг нээн илрүүлэх буюу *гүйцэтгэлд суурилсан* шинж чанартай байх бол зайнаас тавих хяналт шалгалт нь *гүйцэтгэлд суурилсан* аргачлалаас гадна банкны ирээдүйд хүлээж болзошгүй эрсдэлийг нээн илрүүлэхэд чиглэгдсэн байна. Түүнчлэн дээрх хоёр нэгж нь үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор тусгай боловсруулсан журмын дагуу хамтран ажиллах, мэдээлэл солилцох үйл ажиллагааг тогтмол зохион байгуулна.


Өмнөх хугацаанд дэлхийн улс орнууд голчлон гүйцэтгэлд суурилсан аргачлалыг ашиглан хяналт шалгалтын үүргээ гүйцэтгэж ирсэн боловч байгууллагуудад нэгэнт бий болсон алдагдал, хохирлыг нөхөж илрүүлдэг шинж чанар нь дэлхий нийтийг хамарсан санхүүгийн хямралаас сэргийлэх, төрд учруулах хохирлыг бууруулахад хангалттай нөлөө үзүүлж чадаагүй. Энэхүү дутагдалтай талыг арилгаж, хяналт шалгалтын байгууллагуудын хараат бус байдал, эрсдэлээс сэргийлэх чадамжийг сайжруулах зорилгоор дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын санхүүгийн хяналтын байгууллагууд болон Базелийн банкны хяналт шалгалтын хорооноос *эрсдэлд суурилсан* хяналт шалгалтын аргачлалыг шинээр нэвтрүүлэх шаардлагатай талаар онцолж, эрх бүхий байгууллагуудыг энэ аргачлалыг ашиглаж хэвшихийг уриалж, тодорхой стандарт, зөвлөмжүүдийг гаргажээ.

Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг оновчтой нэвтрүүлснээр хяналтын байгууллагуудын хязгаарлагдмал санхүүжилт, ажиллах хүчний нөөцийг нийт хяналтанд хамрагдаж буй санхүүгийн байгууллагуудаас төлбөрийн чадвар муудах магадлал өндөр, санхүүгийн системд үзүүлэх нөлөөлөл ихтэй байгууллагууд, тэдгээрийн үйл ажиллагааны чиглэл, салбар нэгжүүдэд илүүтэйгээр хуваарилах, хяналтын үйл ажиллагааг голчлон хэрэгжүүлэх боломж бүрдэнэ. Өөрөөр хэлбэл, эрсдэл өндөртэй байгаа хэсэгт илүү анхаарал хандуулснаар цаашид үүсч болзошгүй системийн шинж чанартай эрсдэлээс сэргийлэх, санхүүгийн байгууллагын төлбөрийн чадвар алдагдаж системийн бусад хэсэгт тархаахаас өмнө яаралтай зохицуулалтын арга хэмжээг авч санхүүгийн тогтвортой байдлыг хангах боломжтой.

Түүнчлэн өмнө нь эрх бүхий байгууллагуудын зүгээс тус тусдаа бие даан хэрэгжүүлж ирсэн макро бодлогуудыг хослуулах замаар бодлогын оновчтой хэрэгслүүдийг ашиглаж санхүүгийн тогтвортой байдлыг хангах ойлголтод тулгуурлан хэрэгжүүлж буй макро зохистой бодлого нь мөн Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын үйл ажиллагаатай салшгүй холбоотой.


Монголбанкнаас энэ хүрээнд банкны хяналт шалгалтын чиглэлээр 2013-2019 онд хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийн баримт бичгийг боловсруулсан бөгөөд эрсдэлд суурилсан хяналт шалгалтын аргачлалыг гүйцэтгэлд суурилсан хяналтын аргачлалтай оновчтойгоор хослуулах замаар банкны хяналт шалгалтын үйл ажиллагааг олон улсад мөрдөгдөх *үр нөлөөтэй хяналт шалгалтын үндсэн зарчмуудтай* нийцүүлэн хэрэгжүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Зураг 45. Зээл, хадгаламжийн харьцаа



Эх сурвалж: Монголбанк

Зураг 46. Зээлийн үзүүлэлтүүд



Ханшийн эрсдэлээс санхүүгийн салбар болон харилцагчийг хамгаалах системийг сайжруулах талаар: Өнгөрсөн 3 жилийн хугацаанд зээлийн чанарын динамикаас харахад гадаад валютаар олгосон зээлийн эрсдэл нь эдийн засгийн байдал, ханшийн хэлбэлзэл, гадаад худалдааны орчноос хамааран төгрөгийн зээлийн эрсдэлээс харьцангуй их байна. Тухайлбал, энэхүү хугацаанд эргэн төлөлтийн доголдол үүссэн төгрөгийн зээлийн хувь дунджаар 3.2 хувь байсан бол валютын зээлийн хувьд түүнээс

3.9 нэгжээр илүү буюу 7.1 хувь байжээ. Өөрөөр хэлбэл, валютын зээл нь нэг талдаа санхүүгийн системд хохирол ихтэй, нөгөө талдаа зээлдэгч, харилцагчдад учруулах эрсдэл нь өндөр байна.

Тиймээс банкны системийн тогтвортой байдлыг хадгалж, түүний эрсдэл даах чадварыг оновчтой тогтоох үүднээс банкны үйл ажиллагааны зохистой харьцаа тооцох аргачлалд өөрчлөлт оруулан ханшийн эрсдэлтэй зээлдэгчид валютын зээл олгох үйл ажиллагааг бууруулах, эдийн засаг дахь долларжилтыг багасгах, хэрэглэгчийг ханшийн савалгаанаас хамгаалах арга хэмжээ авсан. Цаашид банкуудыг үйл ажиллагаа, удирдлага зохион байгуулалтын онцлогтой уялдсан эрсдэлийн удирдлагын системийг нэвтрүүлж, боловсронгуй болгох, санхүүгийн үүсмэл хэрэгслийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэх шаардлага тулгарч байна.

Нэгдсэн хяналт шалгалтын орчинг сайжруулах талаар: Санхүүгийн салбарын хөгжилтэй уялдан банк нь санхүүгийн нэгдэлд оролцогч хэлбэрээр зохион байгуулагдах нь түгээмэл болж байна. Энэхүү нэгдэлд оролцогч бусад нэгжүүд тухайн банкны үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар нөлөөлж байдаг тул нэгдсэн хяналт шалгалтын эрх зүйн орчинг бүрдүүлж, техник аргачлалыг сайжруулах ажлыг Монголбанк холбогдох бусад төрийн байгууллагуудтай хамтран оны эхнээс хэрэгжүүлж байна.

Цаашид энэхүү үйл ажиллагааг үргэлжлүүлэн гүйцэтгэж төрийн хяналт шалгалтанд хамрагддаггүй нэгдлийн оролцогчдоос санхүүгийн салбарт үзүүлж болзошгүй эрсдэлийг хязгаарлах, бууруулах, тэдгээрийн санхүүгийн тайлан, холбогдох бусад мэдээллийг нэгтгэн үнэлгээ дүгнэлт өгөх, хяналт шалгалтын тэргүүн туршлагыг нэвтрүүлэх, ажилтан албан хаагчийн мэдлэгийг энэ чиглэлд нэмэгдүүлэх тодорхой ажлыг гүйцэтгэх шаардлагатай. Ингэснээр банкны нэгдэл, түүний оролцогчдод хийх нэгдсэн хяналт шалгалтын эрх зүйн орчин сайжирч, төрийн байгууллагуудын ажлын уялдаа сайжран, санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангах чиглэлд томоохон дэвшил гарах юм.

Зээлийн мэдээллийн сангийн бүтцийг өргөтгөх талаар: Санхүүгийн системийн зээлийн эрсдэлийг бууруулах зорилгоор Монголбанк зээлийн мэдээллийн түүхийг агуулсан сан бүрдүүлж, зээл олгогч байгууллагуудыг холбогдох мэдээллээр ханган ажиллаж байна. Хэдийгээр харилцагчийн өнгөрсөн хугацааны санхүүгийн хариуцлагын талаарх мэдээлэл нь зээлдэгчийн зээл эргүүлэн төлөх магадлалд нөлөөлөгч чухал хүчин зүйл боловч бүхэлдээ зээлийн эрсдэлийг тодорхойлдоггүй.

Харин зээлдэгчийн одоогийн санхүүгийн чадвар, түүний ирээдүйн хандлага нь зээлийн эргэн төлөлтөд чухал нөлөөтэй үзүүлэлтүүд болдог. Тиймээс зээлийн багцын төлөөлөл болгож ойролцоо хугацаанд гаргасан, ижил шинж чанартай тодорхой тооны зээлийг агуулсан сан үүсгэж, түүнд зээлдэгчийн санхүүгийн чадварын мэдээллийг багтааснаар нийт багцын эрсдэлийг тооцох, өгөөжийг үнэлэх, зээлийн бодлогын үр ашигт байдлыг хэмжих зэрэг үйл ажиллагааг шуурхай, зардал багатай хийх бололцоог бүрдүүлнэ. Өөрөөр хэлбэл, зээлдэгчийн зээл эргэн төлөлтийн динамикийг түүний санхүүгийн чадвартай нь холбосноор анхнаасаа, эсвэл явцын дунд одоогоор төлбөрийн чадвартай байгаа аль зээлдэгч нь зээлээ хугацаа хэтрүүлэх, чанаргүй болгох магадлал өндөр байгааг тодорхойлох боломж бүрдэх юм.

Чанаргүй активын удирдлагыг сайжруулах талаар: Санхүүгийн салбарын, ялангуяа зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг бизнест тодорхой хэмжээний чанаргүй актив тогтмол хуримтлагдаж байдаг. Гэвч тус чанаргүй активуудын эргэн төлөлтийг гүйцэтгүүлэх

чиглэлд мэргэшсэн, идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй байгууллага манай орны санхүүгийн системд байхгүйгээс банк бүр өөрийн чанаргүй активыг удирдах нэгжийг байгуулан, тэдгээрийг эргүүлэн төлүүлэх, барьцаа хөрөнгийг худалдан борлуулах үйл ажиллагааг тус тусдаа гүйцэтгэж байна. Энэхүү чанаргүй активыг төрийн дэмжлэгтэй, мэргэжлийн байгууллагад хариуцуулан хохирлыг барагдуулах, эсвэл түүнд зохистой үнээр худалдах нь банкинд зардал багатай, ашигт ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх давуу талыг бүрдүүлдэг. Үүнээс гадна системийн хэмжээнд активын чанар алдагдаж, чанаргүй активын хувийн жин нэмэгдэх хямралын үед банкны систем чанаргүй активаасаа шуурхай шилжүүлэх нь санхүүгийн зуучлалыг цаашид хэвийн үргэлжлүүлэх боломжийг бүрдүүлдэг онцгой ач холбогдолтой.

Тиймээс чанаргүй активын эргэн төлөлтийг хангах үйл ажиллагаагаар төрөлжсөн Активын удирдлагын тусгай компанийг байгуулж, санхүүгийн системд чанаргүй активын оновчтой удирдлагын аргачлалыг нэвтрүүлэх нь зүйтэй юм.

Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийг бэхжүүлэх хүрээнд:

Хяналт шалгалтын аргачлалыг сайжруулах талаар: Монголбанк олон улсад түгээмэл мөрдөгддөг санхүүгийн хяналт шалгалтын талаар баримтлах үндсэн зарчмууд, өөрийн хөрөнгө болон бусад зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдэд тавигдах нэгдсэн стандартыг Монголын банкны системд шат дараатайгаар нэвтрүүлэх ажлыг тасралтгүй гүйцэтгэж байна. Энэхүү ажлын үргэлжлэл болгож хяналт шалгалтын чиглэлээр 2013-2019 онд хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги төлөвлөгөөний хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгэх болно. Үүнд:

- Базелийн цуврал стандартын дараагийн алхам болох эрсдэл тооцох чанарын үнэлгээний аргачлалыг (**pillar II, III**) судалж банкуудад мөрдүүлэх ажлыг хэрэгжүүлнэ.
- Үр дүнгийн биелэлтэд (**compliance-based supervision**) суурилсан өнөөгийн хяналт шалгалтын тогтолцооноос эрсдэлийн үнэлгээнд суурилсан аргачлалд шилжих ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэнэ.
- Банкны зохистой засаглалын зарчмуудыг шинэчлэн, оновчтой аргачлалд үндэслэн үнэлгээ дүгнэлт өгөх, турших ажлыг үргэлжлүүлэн, үнэлгээний үнэн зөв байдлыг газар дээрх хяналт шалгалтаар давхар баталгаажуулах ажлыг эхлүүлнэ.

Дээрх арга хэмжээг авснаар Монголбанкны хяналт шалгалт банкуудад ирээдүйд хүлээж болзошгүй эрсдэл, түүнээс үүсэх хохирлыг урьдчилан тооцох арга барил, банкны үйл ажиллагааны зохистой харьцаа, ерөнхий эрсдэлийг тооцохтой холбоотой тоон үнэлгээний механизм сайжран, банкны эрсдэлийн түвшин, түүнээс хамгаалах өөрийн хөрөнгө, эрсдэлийн сангийн хүрэлцээг үнэлэх арга хэмжээнд томоохон дэвшил гарах юм. Үүнээс гадна тоон үнэлгээгээр дүгнэхэд хүндрэлтэй зохистой засаглалын зарчмуудыг банкны бүхий л түвшинд нэвтрүүлж, хэрэгжилтийг хангуулах замаар хариуцлагатай, үр өгөөжтэй банкны системийн үйл ажиллагааг дэмжих болно.

Банкны системийн хамтын ажиллагааны орчинг сайжруулах талаар: Санхүүгийн салбарын хөгжилтэй уялдуулан системийн хил дамнасан хамтын ажиллагааг эрчимжүүлэх, үйл ажиллагааны болон хяналт шалгалтын эрх зүйн орчинг тодорхой болгох чиглэлд гадаадын хяналтын эрх бүхий байгууллагуудтай хийх хамтын

ажиллагааг эрчимжүүлэх шаардлага тулгарч байна. Тухайлбал, Монгол улсад үйл ажиллагаа явуулдаг дотоодын банк гадаад оронд салбар, нэгж байгуулах, гадаадын санхүүгийн байгууллагаас Монгол улсад банкны үйл ажиллагаа явуулах хүсэлт тавих тохиолдолд тусгай зөвшөөрөл олгох, тэдгээрийн үйл ажиллагааг бодлогоор дэмжих, хязгаарлах, өрсөлдөөнийг нэмэгдүүлэх, тайлан бүртгэл, хяналт шалгалтын цар хүрээг нарийн тодорхойлох нь дээрх үйл ажиллагааны суурь болох юм. Тиймээс гадаадын санхүүгийн хяналтын эрх бүхий байгууллагуудтай Харилцан ойлголцлын санамж бичгийг байгуулах, хянан шалгагчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлж, харилцан туршлага солилцох, хил дамнасан банкинд хийх хяналт шалгалт, зохицуулалтын бодлогыг боловсронгуй болгох, харилцан мэдээлэл солилцох арга хэмжээг эхлүүлнэ.

Санхүүгийн зах зээлийн дэд бүтэц, институцийг бэхжүүлэх хүрээнд:

Иргэдийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх талаар: Монголбанк хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, харилцагчийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх чиглэлд тодорхой ажлуудыг өнгөрсөн хугацаанд гүйцэтгэсэн болно. Тухайлбал, банкуудын үйл ажиллагааны шударга, зохистой байдлыг хангуулах, банкуудын мөнгөн хадгаламж, үнэт цаас, зээлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа хууль тогтоомж, заавар журам, тэдгээрийн хэрэгжилт, банкнаас үзүүлсэн үйлчилгээний шимтгэл, хураамжийн нөхцөл, хүү бодох аргачлал зэргийг газар дээр нь шалгаж, түүний үр дүнд үндэслэн 2013 оны 12 дугаар сард “Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журам”-ыг батлан гаргасан. Дээрх журмыг баталснаар зээл, хадгаламжийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа хууль тогтоомж, заавар журмыг мөрдөх, хүүг нэгдсэн аргачлалаар тооцдог болох, хадгаламж, үнэт цаас, зээлийн үйл ажиллагаатай холбоотой шимтгэл, хураамжийг ил тод байлгах, харилцагчдыг зөв сонголт хийх боломжоор ханган банкуудын өрсөлдөөнийг нэмэгдүүлсэн арга хэмжээ болсон.

Цаашид иргэдийн санхүүгийн салбарын мэдлэгийг дээшлүүлж, санхүүгийн оновчтой шийдвэр гаргах чадвар, санхүүгийн сахилга батыг сайжруулах, банкны салбарын бүтээгдэхүүн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлд дараах тодорхой ажлууд хийх шаардлагатай байна. Үүнд:

- Иргэдийн санхүүгийн боловсролын түвшинтэй уялдсан, өөрийн орны зах зээлийн нөхцөлд тохирсон “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийг холбогдох бусад байгууллагуудтай хамтран боловсруулж цогц байдлаар хэрэгжүүлэх,
- Банк, санхүүгийн байгууллагаас үзүүлж буй үйлчилгээний хүртээмжийг сайжруулахад шаардагдах суурь нөхцөл, эрсдэлийн судалгааг гүйцэтгэх.


Ингэснээр иргэдийн ижил төстэй санхүүгийн үйлчилгээнээс өөрийн хэрэгцээ шаардлагад нийцсэн оновчтой сонголт хийх чадвар нэмэгдэж, өрхийн санхүүгийн хариуцлага сайжран, улмаар санхүүгийн системийн тогтвортой байдлыг хадгалах чиглэлд томоохон алхам болох юм.

II.7 ЗЭЭЛ


Банкны салбараас олгосон нийт зээлийн үлдэгдэл 2014 оны 8 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 2179.4 тэрбум төгрөг буюу 26.1 хувиар өсч **12.3** их наяд төгрөгт

хүрчээ. Зээлийн өрийн үлдэгдэл¹⁵-ийг салбаруудаар нь авч үзвэл хэрэглээ, цалин болон тэтгэврийн зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 22.5 хувь, үл хөдлөх хөрөнгийн буюу орон сууцны ипотекийн зээл 18.9 хувь, худалдааны салбар 16.0 хувь, барилгын салбар 14.0 хувь, уул уурхайн салбар 11.5 хувь, боловсруулах үйлдвэр 8.6 хувь, бусад салбарууд 8.5 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 47. Зээлийн үлдэгдлийн хэмжээ



Зураг 48. Шинээр олгосон зээлийн өсөлт, салбараар



Эх сурвалж: Монголбанк

Хөрөнгийн гадагшлах урсгалтай орчинд зээлийн хэмжээ Монголбанк Засгийн газартай хамтран хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдийн нөлөөгөөр 2013 онд өсч байсан бол он гарсаар өсөлт нь алгуур саарч байна. Энэ оны 2 дугаар улирлын байдлаар нийт зээлийн өрийн үлдэгдлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 43.1 хувиар өссөн. Энэхүү өсөлтийн гуравны нэг хэсгийг үл хөдлөх хөрөнгийн салбарын зээл дангаараа бүрдүүлжээ. Үнэ тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрийн хүрээнд олгогдсон зээлийн нөлөөгөөр шинээр олгосон зээлийн жилийн өсөлт 2013 онд дунджаар 57.2 хувь, энэ оны 1 дүгээр улиралд 32.7 хувийн өсөлттэй байсан бол 2 дугаар улиралд 4 хувь болж огцом буураад байна. Хэдийгээр ипотекийн болон иргэдийн зээл нэмэгдэж байгаа ч, уул уурхай, барилга, худалдаа болон бусад салбарт олгогдох зээлийн хэмжээ буурч байгаагаас тухайн улиралд шинээр нэмж олгосон зээлийн жилийн өсөлт ийнхүү буурахад хүрч байна.


2014 оны эхний хагасын байдлаар нэг иргэний дундаж зээлийн хэмжээ 7 орчим сая төгрөгт хүрч, өрхийн өр, орлогын харьцаа нэмэгдэж байгаа нь иргэдийн хэрэглээний зээлийг бууруулах, өрхийн хэрэглээ өсөх боломжийг хязгаарлах нөлөөтэй байна.

Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр (8 хувийн орон сууцны зээл)-ийг 2013 оны 6 дугаар сараас эхлэн хэрэгжүүлсэн нь өнгөрсөн хугацаанд иргэдийн зээл хурдтай өсөхөд нөлөөлсөн. Нэг талаас орон сууцны ипотекийн зээлдэгчдийн тоо 60 мянгаас давж, 8 хувийн зээлийн шалгуурыг хангаж буй иргэдийн дийлэнх нь уг хөтөлбөрт хамрагдсан. Нөгөө талаас эдийн засгийн өсөлт эрс удааширч байгаа нөхцөл байдалтай уялдан банкууд зээлийн шалгуураа чангатгаж, зээл олгох хурдаа сааруулж байгаа нь орон сууцны ипотекийн зээлийн өсөлт саарахад нөлөөлөв.

Иргэд хэрэглээний зээлээс илүүтэй орон сууцны ипотекийн зээл авах эрмэлзэлтэй болж байгаа, эдийн засгийн идэвхжил суларч, улмаар зарим салбарт ажил эрхлэлтийн түвшин буурч байгаа болон улирлын онцлог зэрэг нь цалингийн зээлийн өсөлтийг буурахад голлон нөлөөлөв.

¹⁵ 2014 оны 2 дугаар улирлын зээлийн тайлан. Зээлийн үлдэгдэл 12.2 их наяд төгрөг байв.

Зураг 49. Иргэдийн зээлийн өсөлт, салбараар




Эх сурвалж: Монголбанк


Энэ оны эхний хагас жилийн байдлаар чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 4.6 хувь (Анод, Зоос, Хадгаламж банкны зээлийг хасч тооцвол 2.7 хувь)-тай байна. Харин 2014 оны 8 дугаар сарын байдлаар уг үзүүлэлт 5 хувь (Анод, Зоос, Хадгаламж банкны зээлийг хасч тооцвол 3.2 хувь) байна. Гадаадын шууд хөрөнгө оруулалт он дамжин огцом буурч байгаа нь уул уурхайн салбарын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлсөөр байна. Улмаар уг салбарт чанаргүй зээлийн хэмжээ өсч байна. Түүнчлэн эдийн засгийн идэвхжил саарч байгаагаас худалдааны салбарт зээлийн чанар муудаж байна. Тухайлбал 2014 оны 2 дугаар улирлын байдлаар худалдааны салбарын чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны дүнгээс 2.6 дахин нэмэгдсэн байна.

Нийт банкны салбарын чанаргүй зээлийн дийлэнх буюу 83.9 хувийг уул уурхай (40.2%), худалдаа (24.7%), боловсруулах (9.4%), барилгын (9.6%) салбарын чанаргүй зээл бүрдүүлж байна. Иймд эдгээр салбаруудад олгосон зээлийн чанар цаашид үргэлжлэн муудах эрсдэлийг бууруулах, улмаар санхүүгийн салбарыг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд төлбөрийн тэнцлийг хямралт нөхцөл байдлаас гаргаж, макро эдийн засгийн гадаад тэнцвэрийг хангах нь туйлын чухал байна.

Зураг 50. Чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлийн хувь, ам.долларын ханш



Зураг 51. Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь, салбараар



Эх сурвалж: Монголбанк

II.8 ИНФЛЯЦИ, ТҮҮНИЙ ХҮЛЭЭЛТ БОЛОН ОЙРЫН ТӨЛӨВ

Инфляци, бүрэлдэхүүн хэсгээр


2014 оны 8 дугаар сарын байдлаар хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнийн жилийн өсөлт улсын хэмжээнд 13.7 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд 13.6 хувь гарлаа. Улсын хэмжээнд тооцсон жилийн инфляци өнгөрсөн оны мөн үеэс 4.9 нэгж хувиар, Улаанбаатар хотын жилийн инфляци 5.2 нэгж хувиар өндөр гарсан. Хэрэглээний сагснаас өндөр хэлбэлзэлтэй бараа, бүтээгдэхүүнүүдийг хасч тооцдог суурь инфляци 2014 оны эхний 8 сарын туршид ерөнхий инфляциас өндөр гарав. Энэ нь дараах 3 хүчин зүйлсээс шалтгаалж байна:

- Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш суларсан нь хэрэглээний сагсны гуравны нэг хэсгийг бүрдүүлж байдаг импортын барааны үнэд шууд, дотоодын зарим бараанд шууд бусаар нөлөөлж байна.
- Суурь инфляцийн тооцоонд ордоггүй мах, сүү, хүнсний ногооны үнийн өсөлт хэрэглээний сагсны бусад бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс бага байна.
- 2013 онд дотоод эрэлт төдийлөн буураагүй нь суурь инфляци өндөр байх бас нэг шалтгаан болсон.

2014 оны 8 дугаар сарын байдлаар Улаанбаатар хотын оны эхнээс тооцсон инфляци 7.4 хувь гарлаа. Үүний 0.8 нэгж хувийг мах, махан бүтээгдэхүүн, 1.4 нэгж хувийг махнаас бусад хүнсний бүтээгдэхүүн, 0.1 нэгж хувийг шатахуун, 1.2 нэгж хувийг төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээ, 3.9 нэгж хувийг бусад бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт тайлбарлаж байна.


Оны эхнээс тооцсон инфляци сүүлийн саруудад өссөний гол шалтгаан нь бусад бараа, бүтээгдэхүүн, төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээ болон махнаас бусад хүнсний бүтээгдэхүүний үнэ өссөн явдал юм. Монголбанк Засгийн газартай хамтран нийлүүлэлтийн гаралтай инфляцийн нөлөөллийг бууруулах зорилгоор хэрэгжүүлж буй “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөр”-ийн хүрээнд зорилтот

Зураг 52. Улсын болон Улаанбаатар хотын инфляци



Эх сурвалж: УСХ

Зураг 53. Улаанбаатар хотын оны эхнээс тооцсон инфляци (бүтцээр нь задалсан)




Эх сурвалж: УСХ

бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлтийг сааруулж чадсан ч, төлбөрийн тэнцлийн хүндрэлээс шалтгаалж төгрөгийн гадаад валюттай харьцах ханш суларсан нь бусад бараа, бүтээгдэхүүний үнэ өсөхөд нөлөөлсөн.

Үнэ тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрт хамрагдсан¹⁶ мах, шатахуун, цементний (нийт жин 11.8 хувь) үнийн өсөлт сүүлийн саруудад эрс буурч байна. Энэхүү бүлгийн жилийн инфляцид үзүүлэх нөлөө 2012 онд дунджаар 5.8 нэгж хувь байсан бол 2013 онд 1.8, 2014 оны эхний 8 сарын дунджаар 0.3 нэгж хувь болж буурчээ. Хөтөлбөрт хамрагдсан бүтээгдэхүүнүүдийн үнийн өөрчлөлт 2014 оны 7, 8 дугаар саруудад жилийн инфляцийг бууруулах нөлөө үзүүлсэн ба үүний дийлэнх хэсгийг махны үнийн бууралт тайлбарлажээ.


Инфляцид гол нөлөөтэй бүтээгдэхүүн болох махны үнийн жилийн өсөлтийн түвшин 2012 оны туршид өмнөх онуудаас өндөр байсан. Энэхүү бүтээгдэхүүний жилийн инфляци 2013 онд буурч, оны сүүлийн 10 сар болон 2014 оны туршид олон жилийн дунджаас бага түвшинд байна. Махны үнийн жилийн өсөлт 2012 онд дунджаар 60.6 хувь, 2013 онд дунджаар 5.6 хувь байсан бол 2014 оны 8 дугаар сарын байдлаар -2.3 хувь байна.

Зураг 54. Жилийн инфляци, хөтөлбөрт хамрагдсан бараа болон бусад бараа



Эх сурвалж: УСХ

Зураг 55. Махны үнийн жилийн өсөлт



Эх сурвалж: УСХ


Шигтгээ 4. Төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээний инфляцид үзүүлэх нөлөө

2012 оны эцсээс Төв банк Засгийн газартай хамтран хэрэгжүүлж буй “Үнэ тогтворжуулах хөтөлбөр”-ийн нөлөөгөөр хөтөлбөрт багтсан бараа, бүтээгдэхүүний жилийн инфляцид үзүүлэх нөлөө мэдэгдэхүйц багасч, харин сүүлийн саруудад төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээний үнийн өсөлтийн нөлөө нэмэгдсээр байна. 2014 оны 8 дугаар сарын байдлаар Улаанбаатар хотын жилийн инфляци 13.6 хувь гарсны 1.4 нэгж хувийг төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээний үнийн өсөлт дангаараа бүрдүүлж байгаа бол үнэ тогтворжуулах хөтөлбөрт хамрагдсан барааны үнийн бууралт инфляцийг 0.2 нэгж хувиар бууруулахад нөлөөлөв. Төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээний жилийн инфляцид үзүүлэх нөлөө 2012 онд дунджаар 1.0 нэгж хувь, 2013 онд дунджаар 0.8 нэгж хувь байсан


¹⁶ Хэрэглээний сагсанд гурилын бүтээгдэхүүнүүдийг зөвхөн “Алтан Тариа” ХХК-ын бүтээгдэхүүнүүдээр төлөөлүүлж авдаг ба тус компани хөтөлбөрт хамрагдаагүй учир бүлэгт оруулаагүй.

бол 2014 оны эхний 8 сард дунджаар 1.9 нэгж хувь болж нэмэгдээд байна. Энэ нь голчлон боловсрол болон зорчигч, тээврийн үйлчилгээний үнийн өсөлтөөс шалтгаалав.

Зураг 56. Улаанбаатар хотын жилийн инфляци




Зураг 57. Төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээ



2013 онд төрийн өмчийн их, дээд сургуулийн 1-р дамжааны сургалтын төлбөр 33.2 хувиар нэмэгдэж, 2014 оны 1, 2 дугаар саруудад автобус болон таксины үнэ харгалзан 25, 14.2 хувиар нэмэгдсэн. Үүнээс шалтгаалан төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээний үнэ огцом нэмэгдэж, жилийн өсөлт нь 2014 оны эхний 7 сард дунджаар 18.7 хувь байв. Харин 8 дугаар сард төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээний үнийн жилийн өсөлт буурч 12.1 хувь болсон. Уг бууралт нь төрийн өмчийн их, дээд сургуулиудын 1-р дамжааны сургалтын төлбөрийн өсөлт өнгөрсөн жилийн өсөлтөөс 4.4 дахин бага байсантай холбоотой. 2014 оны 8 дугаар сарын байдлаар зорчигч тээврийн үйлчилгээний үнэ 17.7 хувиар нэмэгдсэн нь 4.6 нэгж хувь, усан хангамжтай холбогдох үнэ 23.0 хувиар өссөн нь 3.7 нэгж хувийн, төрийн өмчийн их, дээд сургуулиудын 1-р дамжааны сургалтын төлбөр 7.6 хувиар нэмэгдсэн нь 2.5 нэгж хувь, цахилгаан хангамжтай холбогдох үнэ 5.8 хувиар өссөн нь 1.1 нэгж хувийн, төмөр замын зорчигч тээврийн үйлчилгээний үнэ 8.5 хувиар өссөн нь 0.1 нэгж хувийн нөлөө тус тус үзүүлжээ.

Зураг 58. Боловсролын үнийн өсөлт



Эх сурвалжууд: УСХ

УСХ-оос хэрэглээний сагсан дахь боловсролын бүлгийн үнийн индексийн тооцоонд төрийн өмчийн¹⁷ болон хувийн их, дээд сургуулийн 1-р дамжаа, хувийн бага сургуулийн төлбөрийг авч үзэж тооцдог. Хичээлийн шинэ жил эхэлсэнтэй холбоотойгоор боловсролын үнийн индекс 8 дугаар сард 17.7 хувиар өссөн. 2014 оны 8 дугаар сард төрийн өмчийн сургуулиудын 1-р дамжааны сургалтын төлбөр дунджаар 7.6 хувиар өссөн нь боловсролын үнийн өсөлтөд 3.9 нэгж хувийн нөлөө үзүүлэв. Харин хувийн их, дээд сургууль болон хувийн бага сургуулийн төлбөрийн өсөлт харгалзан 5.9, 7.9 нэгж хувийн нөлөө үзүүлэв. Боловсролын салбарын үнийн энэхүү өсөлт 2014 оны эцэст жилийн инфляцид 1.3 нэгж хувийн нөлөө үзүүлэхээр байна.


Инфляцийн хүлээлт

Иргэдийн инфляцийн хүлээлтийн судалгааг 2008 оны IV улирлаас авч эхэлсэн. Тухайн үед Улаанбаатар хотын инфляцийн түвшин жилийн 23.1%-тай байсан бол харин иргэд инфляцийг 18.9%-тай хүлээж байсан. Иргэдийн инфляцийн хүлээлт ингэж өндөр гарахад төгрөгийн ханшийн сулралт болон мах махан бүтээгдэхүүн, сүү сүүн бүтээгдэхүүний үнийн өсөлт гол нөлөөг үзүүлж байв.

¹⁷ Төрийн өмчийн их, дээд сургуулиудыг МУИС болон ШУТИС-аар төлөөлүүлэн авдаг.

Харин 2009 оны IV улиралд инфляцийн түвшин жилийн 4.1%-тай гарсан бөгөөд тухайн үед иргэдийн инфляцийн хүлээлт 5.0%-тай байжээ. Талх, гурил, будаа, мах, жимс, хүнсний ногоо зэрэг өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ буурсан нь инфляцийн түвшин буурч, иргэдийн хүлээлт бага гарахад гол нөлөө үзүүлэв.

Зураг 59: Иргэдийн инфляцийн хүлээлтийн харьцуулалт



Эх сурвалж: Монголбанкны түүвэр судалгаа

Зураг 60: Иргэдийн инфляцийн хүлээлтийн чиглэлийн индекс



Монголбанк болон Засгийн газар хамтран 2012 оны сүүлээс үнэ тогтворжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд үүний үр дүнд 2013 онд инфляцийн түвшин дунджаар жилийн 9.1%-тай гарч, улмаар 2013 оны IV улирлын инфляцийн хүлээлтийн судалгаагаар иргэд жилийн дараа инфляцийн түвшинг 11.3% болно гэсэн хүлээлттэй байсан.

2014 оны II улирлын түүвэр судалгаанд Улаанбаатар хотоос 1001 иргэнийг санамсаргүй түүврийн аргачлалаар сонгож хамруулсан. Судалгааны дүнгээр 2014 оны IV улиралд иргэдийн инфляцийн хүлээлтийн түвшин 16.8%-тай байна. Иргэдийн инфляцийн хүлээлтэд мах махан бүтээгдэхүүн, бүх төрлийн хувцас, сүү сүүн бүтээгдэхүүн болон орон сууцны түрээслэх үнэ зэрэг өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт гол нөлөөг үзүүлсэн байна.


Энэ удаагийн судалгаагаар (2014 оны II улирал) иргэдийн инфляцийн хүлээлтийн индекс өмнөх судалгааны дүнгээс огцом өсч “инфляци одоогийнхоос хурдан өснө” гэсэн мужид хэвээр хадгалагдан үлдсэн байна. Иргэдийн инфляцийн хүлээлт өсч, инфляцийн хүлээлтийн судалгаа явуулж эхэлсэн үеүдийнхээс хамгийн дээд цэгтээ хүрэхэд төлбөрийн тэнцлийн хүндрэлээс шалтгаалж төгрөгийн гадаад валюттай харьцах ханш суларснаар импортын барааны үнэ өсч байгаагаар голлон тайлбарлагдаж байна.

Дээрх дурьдсан инфляцийн хүлээлтийн судалгааны үр дүнгээс харахад иргэд, аж, ахуй нэгжийн инфляцийн хүлээлт адагтив буюу өнгөрсөн үеийн инфляцийн гүйцэтгэлд голчлон суурилдаг хандлагатай байгаа ба иргэдийн инфляцийн хүлээлтийг бага, тогтвортой түвшинд төлөвшүүлэх асуудал Монголбанкны хувьд сорилт хэвээр байна.

Инфляцийн богино хугацааны төлөв

Улаанбаатар хотын жилийн инфляци 3 дугаар улиралд 14.3 хувь, 4 дүгээр улиралд 11.4 хувь байх урьдчилсан төсөөлөлтэй байна. Хүнснээс бусад бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт инфляцийн дийлэнхийг бүрдүүлсэн хэвээр байх хандлагатай байна.

Жил бүрийн 7, 8, 9 дүгээр саруудад зарим төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээний үнэ нэмэгддэг. 2014 оны 7 дугаар сард цэвэр болон бохир усны үнэ өмнөх сараас 40 хувиар, халуун усны үнэ 50 хувиар нэмэгдсэн бол төмөр замын зорчигч тээврийн үйлчилгээний үнэ 8.5 хувиар нэмэгдсэн. Харин 8 дугаар сард төрийн өмчийн их, дээд сургуулиудын 1-р дамжааны сургалтын төлбөр дунджаар 7.6 хувиар өссөн. Түүнчлэн өрхүүдийн эрчим хүчний төлбөр 1 кВт/цаг хэрэглээ тутамдаа 5 төгрөгөөр буюу 5.8 хувиар өслөө.

Зураг 61. Инфляцийн богино хугацааны төсөөлөл

Эх сурвалж: Монголбанк

Хүснэгт 17. Төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлт

№	Бараа, үйлчилгээний нэр	Өсөлт	Сар
1	Цэвэр болон бохир ус	40%	7
2	Халуун ус	50%	7
3	Төмөр замын зорчигч тээврийн үйлчилгээ	8.5%	7
4	Төрийн өмчийн их, дээд сургуулиудын 1-р дамжааны сургалтын төлбөр	7.6%	8
5	Эрчим хүчний төлбөр	5.8%	8

Шигтгээ 5. Төгрөгийн ханшийн сулралт болон инфляци¹⁸

Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн инфляцид үзүүлэх нөлөөг энгийн тоон шинжилгээ (non-parametric approach) болон эконометрик аргаар (Mark-up equation, SVAR) шинжилж үзэхэд дараах гол үр дүн гарав:

- Худалдааны түнш орнуудын бага түвшний инфляциас шалтгаалан доллараар илэрхийлэгдэх импортын үнэ буурч байгаа ч, төгрөгийн ханшийн сулралтаас хамааран төгрөгөөр илэрхийлэгдэх импортын үнэ өсч байгаа нь бараа, үйлчилгээний үнэд өсгөх дарамт учруулж байна.
- Энгийн тоон шинжилгээгээр төгрөгийн ханшийн сулралтын инфляцид үзүүлэх шууд¹⁹ нөлөөллийн хувьд 2013 оны байдлаар 9 хувийн ханшийн дундаж сулралт нь 9 хувийн жилийн дундаж инфляцийн 3.3 нэгж хувь буюу 35.2 хувийг дангаараа бүрдүүлсэн байна.
- Төлбөрийн тэнцлийн он дамжсан хүндрэлээс хамаарч 2013 оны 2 дугаар хагасаас хойш төгрөгийн ханшийн сулралтын инфляцид үзүүлэх нөлөө мэдэгдэхүйц нэмэгдэж байна. Тухайлбал, 2014 оны 1 дүгээр улирлын байдлаарх жилийн инфляци (12.8 хувь)-ийн 47.8 хувийг буюу 6.1 нэгж хувийг бий болгоход төгрөгийн ханшийн шок нөлөөлсөн байх тооцоо²⁰ гарч байна.


¹⁸ Дэлгэрэнгүйг Б.Даваадалай (2014), Монголбанк, “Төгрөгийн ханшийн сулралт болон Инфляци” судалгааны ажлаас харах боломжтой.

¹⁹ Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн өөрчлөлт нь дотоодын инфляцид импортын бараа, бүтээгдэхүүн, түүхий эд, тоног төхөөрөмжийн үнэ болон үйлдвэрлэлийн орцоор дамжин шууд нөлөөлдөг.

²⁰ Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн өөрчлөлтийн өнгөрсөн үеийн жилийн инфляцид хэрхэн нөлөөлсөнийг харах зорилгоор энгийн Mark-up тэгшитгэл болон SVAR загвар ашиглан тэдгээрийн түүхэн задаргааг хийж үзэхэд Mark-up тэгшитгэлийн үр дүн бодит байдалтай илүү нийцтэй гарсан бөгөөд уг загвараар тооцсон задаргааг зурагт харуулав.

- Төгрөгийн ам.доллартай харьцах ханш 1, 5 болон 8 дугаар саруудад тус тус 10 хувиар сулрах тохиолдолд ХҮИ суурь утгаасаа харгалзан 2.0, 4.0 болон 5.5 нэгж хувиар өсөхөөр байна.
- Хамгийн хүчтэй нөлөө нь 8 сарын дараа буюу мэдрэмж нь **0.52** байгаа бөгөөд энэ үр дүн нь өмнөх судалгаануудын үр дүнтэй нийцтэй ч, хугацааны хувьд 2 сараар хойно, хүчийн хувьд ялимгүй бага гарсан нь сүүлийн 2 жилийн хугацаанд Төв банк Засгийн газартай хамтран хэрэгжүүлж буй нийлүүлэлтийн гаралтай инфляцийн дарамтыг бууруулахад чиглэсэн хөтөлбөрүүд нөлөөлсөн байх боломжтой. Ялангуяа төгрөгийн ханшийн өөрчлөлтийн шатахууны импортоор дамжих нөлөө нь жижиглэнгийн үнэ тогтвортой байгаагаас шалтгаалж саарсан байх талтай.
- Дээрх үр дүнд дээр үндэслэвэл импортын үнэ тогтмол байхад төгрөгийн ханш ам.долларын эсрэг 10 хувиар сулрахад 5.2 нэгж хувийн инфляцийг бий болгоно гэсэн дүгнэлт хийж болохоор байна. Төгрөгийн ханшийн сулралтын бараа бүтээгдэхүүний импортын орцын үнийн өсөлтөөр дамжин инфляцид үзүүлэх нөлөөллийн²¹ коэффициент нь ойролцоогоор 0.17 ($=0.52-0.30$) байхаар байна.

Зураг 62. Инфляци дахь төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн нөлөөлөл



Эх сурвалж: Статистикийн бюллетень, Монголбанк

Иймд төгрөгийн ханшийн сулралтын сөрөг нөлөөг саармагжуулах нь инфляци, улмаар нийгмийн амьжиргааны түвшинг хамгаалахад чухал юм. Гэхдээ нөгөө талдаа бодлогын түвшинд төгрөгийн ханшийн сулралтыг мөнгөний бодлогын аливаа хэрэгслээр хүчээр барих гэсэн оролдлого нь эдийн засгийн бусад хувьсагчдад очих сөрөг шокийн хэмжээг нэмэгдүүлснээр эцэстээ макро эдийн засгийн тогтворгүй байдлыг үүсгэх, улмаар илүү сөрөг үр дагаварт хүргэх эрсдэлтэй юм. Гадаад валютын орох урсгал үлэмж хэмжээгээр хумигдаж буй өнөөгийн нөхцөлд ханшийн сувгаар дамжин инфляцийг өсгөж буй үзэгдэл тод ажиглагдах боллоо. Ийм нөхцөлд Монголбанк нэг талаас инфляцийг 8 хувьд барих, нөгөө талаас эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих гэсэн зорилтууд өөр хоорондоо зөрчилдөхөд хүрээд байна. Одоогийн эдийн засгийн орчинд Төв банкны мөнгөний бодлого нь эдийн засгийн өсөлтийг хадгалах гэхээсээ илүүтэй макро эдийн засгийн гадаад тэнцвэрийг хангах, санхүүгийн салбарт учирч болзошгүй эрсдэлийг бууруулах хүрээнд мөнгөний бодлогыг хатууруулах чиглэлд шилжиж байна. Өөрөөр хэлбэл төлбөрийн тэнцэл сайжраагүй нөхцөлд мөнгөний бодлогоор эдийн засгийн бодит секторыг дэмжих боломж улам бүр хязгаарлагдав. Цаашилбал, хэрэв төлбөрийн тэнцэл мэдэгдэхүйц сайжрахгүй бол төгрөгийн өгөөжийг өсгөн, төлбөрийн тэнцлийн хүндрэлийг зөөллөх замаар төгрөгийн ханшийн сулралтыг сааруулж, мөнгөний

²¹ Total effect буюу the second round effect-ийг оруулж тооцсон болно.

бодлогыг төсвийн зохистой бодлоготой уялдуулах, эдийн засгийн гадаад, дотоод тэнцвэртэй орчинг бүрдүүлэх, макро эдийн засгийн болон санхүүгийн тогтвортой байдлыг хадгалах нь чухал болж байна.

III. ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2014 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ БАТЛАХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН 62 ДУГААР ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ (2014 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар)

2. Эдийн засгийн бодит салбарыг мөнгөний бодлоготой уялдуулан дэмжиж ажиллах

2013 оноос эхлэн инфляцийн хэтийн хандлага нь зорилтот түвшинтэй нийцтэй байсан үед Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөл мөнгөний бодлогын хүүг 2013 оны 1, 4, 6 дугаар сард, нийт 2.75 нэгж хувиар бууруулж, 2013 оны 6 дугаар сараас хойш 10.5 хувьд өөрчлөлгүй хадгалан, эдийн засгийн бодит секторын идэвхжилийг дэмжсэн. Энэ нь ДНБ-ий бодит өсөлт 2013 онд 11.7 хувьтай гарч 3 жил дараалан хоёр оронтой тоонд, 2014 оны 1 дүгээр улиралд 7.4 хувьтай гарч 2013 оны эхний улирлаас 0.3 нэгж хувиар өндөр байхад эерэгээр нөлөөлсөн. Монголбанк 2012 оны 11 дүгээр сараас эхлэн эдийн засгийг тогтворжуулах, санхүүгийн салбарыг системийн шинжтэй болзошгүй эрсдэлээс сэргийлэх бодлого хэрэгжүүлж, эдийн засагт зайлшгүй шаардлагатай мөнгөний нийлүүлэлтийг хувийн хэвслээр дамжуулан бодит секторт эргэлтийн хөрөнгийн зээл олгох хэлбэрээр нэмэгдүүлсэн. Эдгээр нь сүүлийн 18 сарын хугацаанд хөдөө аж ахуйн салбарын өсөлт тогтвортой өндөр түвшинд хадгалагдах, барилга угсралт, тээвэр ба агуулахын салбарын өсөлтийг нэмэгдүүлэх, ажлын байрыг хамгаалахад чухал нөлөө үзүүлсэн юм.

Гэвч гадаад валютын орох урсгал тасралтгүй буурч, төлбөрийн тэнцлийн хүндрэлтэй нөхцөл байдал удаан үргэлжлэн, Монгол Улсын гадаад цэвэр актив сүүлийн 17 сарын турш буурсны нөлөөгөөр нийт эрэлт буурч, эдийн засгийн өсөлт 2014 оны 2 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс 5.4 нэгж хувиар саарч 3.8% болоод байна.


Хүснэгт 18. ДНБ-ий бодит өсөлт (%)

Бодит ДНБ	2013 оны эхний хагаст	2014 оны эхний хагаст
ДНБ-ий бодит өсөлт* (%)	8.4	5.3
Хөдөө аж ахуй	20.1	16.3
Уул уурхай	5.6	16.1
Боловсруулах	8.1	0.3
Цахилгаан, хий, уур	7.5	1.3
Барилга	69.1	-1.8
Худалдаа (бөөний, жижиглэн)	-12.2	-12.3
Тээвэр ба агуулах	5.1	11.9
Мэдээлэл, холбоо	15.7	2.5
Үйлчилгээ	8.2	7.2
Бүтээгдэхүүний цэвэр татвар	17.3	-3.3

*2010 суурьт шилжүүлсэн

Эх сурвалжууд: УСХ


Зураг 63. Улирлын ДНБ-ий бодит өсөлт (%)



2013 оны ДНБ-ий 11.7%-ийн бодит өсөлтийн 8.6 нэгж хувь нь мөнгөний уламжлалт бус тэлэх бодлого буюу хувийн хэвслээр дамжуулан эдийн засгийн бодит секторт олгосон зээлийн нөлөөгөөр, 2.7 нэгж хувь нь улсын төсвөөс гадуурх төсөвтэй адилтгах

хөрөнгө оруулалтын нөлөөгөөр, 0.4 нэгж хувь нь улсын төсвийн нөлөөгөөр тус тус бий болжээ²².

Зураг 64. Гадаад, дотоод цэвэр актив (тэрбум төгрөг)



Зураг 65. ГЦА, ДЦА-ын жилийн өөрчлөлт (%)



Эх сурвалж: Монголбанк

2014 оны 8 дугаар сарын байдлаар Монгол Улсын гадаад цэвэр актив (ГЦА)-ын хэмжээ оны эхнээс 1836 тэрбум төгрөгөөр буюу 197 хувиар, өнгөрсөн оны мөн үеэс 3163 тэрбум төгрөгөөр буюу 140 хувиар буураад байна. Гадаад цэвэр активын хэмжээ ийнхүү сүүлийн 2 жилийн туршид огцом буурсан нь эдийн засагт орж ирэх гадаад валютын урсгал, төлбөрийн нийт тэнцэл оны эхнээс сайжрахгүй байгаатай шууд холбоотой. Ийнхүү гадаад валютын орох урсгал сайжрахгүй, төлбөрийн тэнцэл урьдчилсан гүйцэтгэлээр оны эхний 7 сард 978 сая ам.долларын алдагдалтай гарсан нь эдийн засгийн бодит секторыг мөнгөний бодлоготой уялдуулан дэмжих боломжийг хязгаарлаж, мөнгөний бодлогын хүүг бууруулах, мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, улмаар бодит секторын идэвхжилийг дэмжих нөхцөлийг бүрдүүлсэнгүй. Харин ч, төлбөрийн тэнцлийн 2013 оны “хямрал”-ын нөхцөл байдал сайжрахгүй, төлбөрийн тэнцэл дэх дарамт арилахгүй хэвээр байгаа нь 2014 оны сүүлийн хагаст макро эдийн засгийн бодлогыг хумих, тэр дундаа төсвийн зардал болон төсөвтэй адилтгах зарцуулалтыг эрс бууруулах шаардлагыг бий болгосон. Гэвч улсын төсвийн зардал болон төсөвтэй адилтгах хөрөнгө оруулалтын зарцуулалтууд нь макро эдийн засгийн гадаад тэнцвэрийг хангахад нөлөөлөхүйц хэмжээнд буураагүй тул Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөл төлбөрийн тэнцлийн хүндрэлийг зөөлрүүлэх, инфляцийг эрчимжүүлэхгүй байлгах, дунд болон урт хугацаанд санхүүгийн тогтвортой байдлыг хангах, макро эдийн засгийн тогтвортой байдалд учирч болзошгүй эрсдэлээс сэргийлэх, иргэдийн бодит орлогыг хамгаалах зорилгоор 2014 оны 7 дугаар сарын 31-ний өдөр мөнгөний бодлогын хүүг нэмэгдүүлэх шийдвэр гаргасан юм.

Хэдийгээр макро эдийн засгийн төлөв байдал, төлбөрийн тэнцлийн хүндрэл нь эдийн засгийн бодит секторыг мөнгөний бодлоготой уялдуулан дэмжих боломжийг эрс хязгаарласан ч, Монголбанк эдийн засагт орж ирэх гадаад валютын урсгалыг нэмэгдүүлэхэд эерэгээр нөлөөлөх зарим арга хэмжээг Засгийн газартай хамтран боловсруулж, хэрэгжүүлэв. Үүнд:

1. Эдийн засгийг төрөлжүүлэх, уул уурхайн салбараас хараат байдлыг бууруулах замаар эдийн засгийн урт хугацааны өсөлтийг хангах зорилтын хүрээнд Монголбанкнаас **“Монгол Улсын хөдөө аж ахуйн салбарыг тогтвортой хөгжүүлэх, санхүүжилтийн зохистой тогтолцоог бүрдүүлэх”** бодлогын судалгааг мал аж ахуй, газар тариалан,

²² Эмпирик судалгааны үр дүн (Монголбанк).

хүнсний үйлдвэрлэл, арьс шир, ноос, ноолуур боловсруулах үйлдвэрлэлийн салбарыг хамруулан 2014 оны 1 дүгээр улиралд гүйцэтгэсэн. Судалгааны үр дүнд ноос ноолуур, арьс шир боловсруулах, хүнсний үйлдвэрлэлийн салбарт эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг дэмжих замаар ашигт малтмалын бус салбарын экспортын тогтвортой орлогыг бий болгох нь нэн тэргүүний зорилт гэж тодорхойлсон болно.

Энэ хүрээнд Монголбанкнаас ҮХААЯ, СЯ-тай хамтран ноолуурын үйлдвэрлэлийг дэмжих, экспортыг нэмэгдүүлэх (НҮДЭН) арга хэмжээний схем, НҮДЭН арга хэмжээг хэрэгжүүлэх журам, Засгийн газрын батлан даалтын гэрээ, Монголбанкнаас банкттай байгуулах зээлийн гэрээ, зээлийн эх үүсвэрийг олгох, буцаан төлүүлэх, хяналт тавих механизм, аргачлалыг тус тус боловсруулан баталж, Засгийн газар холбогдох шийдвэрийг гаргасан. Энэхүү арга хэмжээ нь дараах схемээр хэрэгжинэ:

- ҮХААЯ-тай гэрээ байгуулсан үндэсний үйлдвэрүүд өөрийн эх үүсвэрээр, эсвэл өөрийн хөрөнгийг барьцаалж авсан зээлээр түүхий эдийн эхлэлийн нөөцийг ХАА-н биржээр дамжуулан бүрдүүлэх,
- Монголбанк зээлийн эх үүсвэрийг үйлдвэрийн худалдан авсан, сертификатаар баталгаажсан түүхий ноолуурын агуулахын нөөцөд тулгуурлан банкинд хэсэгчлэн олгоно. Энэ нь зөвхөн түүхий ноолуур худалдан авч, боловсруулан экспортлоход зориулагдах бөгөөд нийт санхүүжилтийн 70% байх,
- Үйлдвэрүүд түүхий эдийн баталгаажсан агуулах дахь нөөцийн үлдэгдлийг барьцаалж, дараагийн түүхий эд бэлтгэлд зориулан банкуудаас эргэлтийн хөрөнгийн зээл авах,
- Үйлдвэрүүд түүхий эдийг боловсруулж, самнасан ноолуур үйлдвэрлэн экспортлох, банкнаас авсан зээлээ 2014 онд багтаан бүрэн төлж дуусгах,
- Хэрэв зээлийн эргэн төлөлт нь гэрээнд заасан тодорхой хугацаанаас хоцрох тохиолдолд зээлийн хүү нь өсөн нэмэгдэх зохицуулалт үйлчлэх,
- Арга хэмжээнд зориулан Монголбанкнаас гаргах эх үүсвэрт учирч болзошгүй гадаад зах зээлийн эрсдэлд Засгийн газрыг төлөөлж Сангийн яам батлан даалт гаргах.

Арга хэмжээний үр дүнд самнасан ноолуурын үйлдвэрлэл, экспортын орлого нэмэгдэж, 2014 оны төлбөрийн тэнцэлд эерэгээр нөлөөлөх, үйлдвэрүүдийн тогтвортой үйл ажиллагаа хангагдан ажлын байрууд хадгалагдах богино хугацааны үр дүн хүлээгдэнэ. Харин дунд хугацаанд хөдлөх хөрөнгийг барьцаалж, ноолуурын түүхий эдийн агуулахын үлдэгдлийг санхүүжүүлэх санхүүгийн шинэ бүтээгдэхүүн бий болох, үндэсний үйлдвэрүүдийн үйл ажиллагаа бэхжих, үйлдвэрлэлээ өргөтгөх, ашигт малтмалын бус салбарын экспорт өсөн нэмэгдэх үр дүн хүлээгдэхээр байна.

2. УИХ-аас Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, Монголбанк болон банкуудад тушаагдах алтны хувьд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг 2.5% болгон бууруулсан нь дотоодын алт олборлолт, тушаалтыг нэмэгдүүлэх эерэг өөрчлөлт болсон. Гэхдээ дэлхийн зах зээл дэх алтны үнэ буурсан, Монголд орж ирэх гадаадын шууд хөрөнгө оруулалт 2013 оноос эхлэн огцом багассан, төлбөрийн тэнцлийн 2013 оны хямралаас үүдэлтэй эдийн засгийн хүндрэлийн улмаас дотоодын аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн эх үүсвэрийн дутагдал бий болсон зэрэг нь алт олборлолтод сөргөөр нөлөөлж байна. Иймд алтны салбарын санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх, алтны үнийн эрсдэлийг санхүүгийн үүсмэл хэрэгсэл ашиглан бууруулах замаар 2014 онд алт олборлолтыг нэмэгдүүлэх, улмаар гадаад валютын улсын нөөцийг өсгөх зорилгоор Монголбанк,

УУЯ, ЭЗХЯ хамтран “Алтны салбарын санхүүжилтийн тогтолцоог оновчтой болгох арга хэмжээ”-г 2014 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр хамтарсан тушаалаар баталж, арга хэмжээг хоёр үе шаттайгаар хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн болно. Арга хэмжээний эхний шатны хүрээнд нийт 9 байгууллагаас 75 тэрбум төгрөгийн зээлийн хүсэлт банкуудад ирсэн бөгөөд одоогоор судлагдаж байна.

3. Нийлүүлэлтийн гаралтай инфляцийг үргэлжлүүлэн бууруулах, эдийн засгийн бодит секторын идэвхжилийг дэмжих зорилгоор “Тол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дунд хугацааны хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүллээ. Олгосон зээлийн 80%-ийг Монголбанкны, 20%-ийг банкууд өөрийн эх үүсвэрээр олгосон бөгөөд хөтөлбөрт анх төлөвлөсний дагуу нийт олгох зээлд Монголбанкны эх үүсвэрийн эзлэх хувь хэмжээ цаашид буурах, банкуудын өөрийн эх үүсвэрийн эзлэх хувь хэмжээ өсөн нэмэгдэх зохицуулалт 2014 оноос эхлэн үйлчилж байна. Дунд хугацаанд гол нэрийн бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн үр ашигтай, зах зээлийн зарчимд суурилсан тогтолцоог бүрдүүлснээр Монголбанк хөтөлбөрөөс үе шаттай гарах юм. 2014 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар “Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах (FPS) дэд хөтөлбөр”-ийн хүрээнд 356.0 тэрбум төгрөгийн зээл олгосноос 198.3 тэрбум төгрөг (56%)-ийн эргэн төлөлттэй байгаа бол “Барилгын салбарыг дэмжих, орон сууцны үнийг тогтворжуулах (HPS) дэд хөтөлбөр”-ийн хүрээнд нийт 322.6 тэрбум төгрөгийн зээлийг банкууд олгосноос 154.2 тэрбум төгрөгийн зээл (48%) эргэн төлөгдөөд байна. Орон сууцны ипотекийн зээлээс бусад бүх хөтөлбөрийн зээлийн үлдэгдэл 2013 оны эцэст 1640 тэрбум төгрөг байсан бол 2014 оны эцэс гэхэд эргэн төлөлтийн хуваарийн дагуу 603 тэрбум төгрөгөөр буурч, 1037 тэрбум төгрөг болохоор хүлээгдэж байна.

3.1. Санхүүгийн зах зээлийн бүтцийг олон тулгуур бүхий, зохистой болгох, чөлөөт өрсөлдөөний орчныг бүрдүүлэх, санхүүгийн олон төрлийн бүтээгдэхүүн бий болгох, санхүүгийн зуучлалыг гүнзгийрүүлэх чиглэлээр 2014-2016 онд хэрэгжүүлэх бодлогын баримт бичгийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх (Засгийн газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо)

Санхүүгийн салбарыг дунд хугацаанд хөгжүүлэх бодлогын баримт бичгийг олон улсын санхүүгийн байгууллагуудын техник туслалцаатайгаар, Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яам, Санхүүгийн зохицуулах хороо зэрэг холбогдох байгууллагатай хамтран боловсруулахаар ажиллаж байна. Энэ хүрээнд Монголбанкнаас Дэлхийн банкинд санал тавьж, хамтарсан ажлын хэсгийг СЯ, ЭЗХЯ, СЗХ-той хамтран байгуулах ажлыг эхлүүлээд байна. Түүнчлэн, үл хөдлөх хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх, мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг бий болгох чиглэлээр Монголын Ипотекийн корпорацитай хамтран ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд зээлийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасжуулах зорилгоор багцлан худалдах үед баримтлах зарчмыг “Орон сууцны ипотекийн зээлийн үйл ажиллагааны журам”-ын төсөлд тусгаж, мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг дэмжих, тэдгээрийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчинг бүрдүүлсэн.

Монголбанкнаас санхүүгийн зах зээлийн зохистой бүтэц, чөлөөт өрсөлдөөний орчин, санхүүгийн зуучлалыг гүнзгийрүүлэх талаар судалгаа хийж байгаа бөгөөд уг асуудалд Монголбанкнаас баримтлах бодлого, зарчмын байр суурь, оролцооны хэм хэмжээг тодорхойлох зорилгоор өндөр хөгжилтэй орны Төв банкны чиг үүрэг, туршлагыг судалж байна. Үүний зэрэгцээ даатгал болон хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжих

замаар санхүүгийн зах зээлийн олон тулгуурт бүтцийг бий болгох, улмаар санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, тэдгээрийг алслагдсан бүс нутагт хүргэх чиглэлийг энэхүү бодлогын баримт бичигт тусгахаар төлөвлөж байгаа болно.

Монголбанкнаас СЗХ-той хамтран кастодиан үйлчилгээг манай орны санхүүгийн зах зээлд нэвтрүүлэх зорилгоор “Кастодианы тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам”-ыг боловсруулж, Монголбанкны Ерөнхийлөгч болон СЗХ-ны даргын 85/А106 дугаар хамтарсан тушаалаар баталсан. Энэхүү үйлчилгээг нэвтрүүлснээр хөрөнгийн зах зээлийн арилжааны дараах үйлчилгээ үзүүлэх орчинг сайжруулж, хөрөнгө оруулагчийн үнэт цаасыг түүний зөвшөөрөлгүйгээр захиран зарцуулах боломжийг хязгаарлах давуу талтай юм. Үүнээс гадна дотоодын кастодиан үйлчилгээ үзүүлэгч нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн кастодиан үйлчилгээ үзүүлэгчийн дэд-кастодиан болох замаар Монгол Улс дахь гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх бололцоо бүрдэнэ. Өөрөөр хэлбэл, гадны хөрөнгө оруулагч нь олон улсад үйл ажиллагаа явуулдаг нэр хүнд бүхий кастодиан банкаар дамжуулан Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй дотоодын кастодиан банктай холбогдож, хөрөнгө оруулалт хийх бололцоотой болно.

Монголбанк санхүүгийн зуучлалыг гүнзгийрүүлэх хүрээнд банкуудын үйл ажиллагааны шударга, зохистой байдлыг хангуулах, банкуудын мөнгөн хадгаламж, үнэт цаас, зээлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа хууль тогтоомж, заавар, журам, тэдгээрийн хэрэгжилт, мөнгөн хадгаламж, үнэт цаас, зээлийн үйл ажиллагаатай холбоотой үйлчилгээний шимтгэл, хураамжийн нөхцөл, хүү тооцох аргачлалыг шалгах ажлыг газар дээр нь хийж гүйцэтгэсэн билээ. Уг шалгалтын үр дүнд Монголбанк санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах зорилтын хүрээнд хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, харилцагчийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж, банкуудын зээл, хадгаламжийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нөхцөл, зээлийн бодит өртөг зардал, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлыг хангуулах, санхүүгийн зах зээлд нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээг тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Иймд банкуудын хүү бодох аргачлалыг боловсронгуй болгож мөрдүүлэх, хадгаламж, зээлийн үйл ажиллагаатай холбоотой аливаа шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлыг хангуулж, олон улсын жишигт нийцүүлэх зорилгоор Монголбанк “Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журам”-ыг шинээр боловсруулан, Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх заалтад үндэслэн баталж, 2014 оны 1 дүгээр сараас эхлэн хэрэгжүүлж эхлээд байна. Энэхүү журамд зээлийн бодит өртөг, хадгаламжийн бодит үйлчилж буй хүүг тооцож мэдээлэх, зээл, хадгаламж, үнэт цаасны өдрийн хүү тооцох суурь хоногийг стандартчилах, нэмэгдүүлсэн хүү тооцох аргачлал, шимтгэл, хураамжийн нөхцөл, мэдээллийн ил тод байдлыг хангах асуудлыг тодорхой тусгасан болно. Журмыг хэрэгжүүлэх хүрээнд банкуудын хүү, шимтгэл, хураамжийн 2014 оны эхний 7 сарын мэдээллийг Монголбанкнаас нэгтгэн, цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд мэдээлээд байна.

Энэхүү журмыг баталж хэрэгжүүлснээр зээл, хадгаламжийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа хууль тогтоомж, заавар журмын хэрэгжилтийг хангуулах, хүүг нэгдсэн аргачлалаар тооцдог болох, хадгаламж, үнэт цаас, зээлийн үйл ажиллагаатай холбоотой шимтгэл, хураамжийг олон нийтэд ил тод байлгах, харилцагчдыг оновчтой, зөв сонголт хийх боломжоор хангах, банкуудын өрсөлдөөнийг нэмэгдүүлсний үндсэн дээр цаашид зээлийн хүү буурах нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг болох юм.

Түүнчлэн, банкны салбараас алслагдсан, санхүүгийн мэдлэг муутай, мэдээлэл багатай, ялангуяа хөдөө, орон нутгийн иргэд, хуулийн этгээдэд үзүүлэх санхүүгийн үйлчилгээг үр ашигтай болгох, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 2014 оны 5-6 сарын хооронд дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд: (i) орон нутаг дахь иргэд, аж ахуйн нэгжүүдээс түүвэрлэлт хийн, санхүүгийн хүртээмжийн судалгааг авав. (ii) дээр дурдсан журмын хэрэгжилт нийтэд ижил тэгш үйлчилж байгаа эсэхийг тодорхойлох, банкны зээлийн үйл ажиллагаанд шударга бус хэлцэл үүсэх боломжийг хязгаарлах зорилгоор хөдөө орон нутгийн (13 аймгийн) банкуудад хэсэгчилсэн шалгалтыг хийж, хөдөө, орон нутагт олгогдож байгаа зээлийн нөхцөлийг газар дээр нь шалгав. Шалгалт болон түүвэр судалгааны үр дүнг нэгтгэн, үнэлгээ дүгнэлт гаргах ажил одоо хийгдэж байна.

3.2. Эдийн засгийн бодит салбарын идэвхжилийг дэмжих зорилгоор “Зээлийн хүү буурах орчныг бүрдүүлэх” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх (Засгийн газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо)

Монголбанк зээлийн хүү өндөр түвшинд тогтоход нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлж, тэдгээр хүчин зүйлсийн нөлөөллийг бууруулах, эдийн засаг, санхүүгийн зах зээлийн таатай орчныг бий болгох замаар зээлийн хүү буурах зах зээлийн орчныг бүрдүүлэх зорилго бүхий хөтөлбөрийг анх Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн Сайд, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо (хуучин нэрээр)-ны даргын 2011 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 677/229/188/142 тоот хамтарсан тушаалаар баталж, 2013 оныг дуустал хэрэгжүүлсэн.

Энэ хугацаанд тус хөтөлбөрийн хүрээнд инфляцийг нам, тогтвортой түвшинд байлгах, банкуудын үйл ажиллагааны шударга, зохистой байдлыг хангуулах, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, хөрөнгийн зах зээлийн хөгжлийг түргэтгэх, санхүүгийн салбарын дэд бүтэц, хууль эрх зүйн орчныг сайжруулах зэрэг үндсэн 4 чиглэлээр тодорхой зорилтууд тавьж хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрсэн байна. Үүнд:

- **Зээл, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, эдийн засгийн бодит сектор, бизнесийн идэвхжилийг дэмжих зорилгоор Монголбанкнаас бодлогын дараах арга хэмжээг авсан.**

Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөл 2013 оны 1 дүгээр сарын 25, 4 дүгээр сарын 8, 6 дугаар сарын 25-ны өдрүүдэд тус тус хуралдаж мөнгө, зээлийн өсөлтийг тогтворжуулан, санхүүгийн салбарын хэвийн үйл ажиллагааг хангаж, эдийн засгийн идэвхжилийг дэмжих үүднээс мөнгөний бодлогын хүүг 13.25 хувиас шат дараалан (3 үе шаттай) бууруулан 10.5 хувьд хүргэсэн. Мөнгөний бодлогын зөвлөлийн 2014 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар макро эдийн засгийн болон санхүүгийн тогтвортой байдлын зорилтыг хангах хүрээнд мөнгөний бодлогын хүүг 10.5 хувьд хэвээр үлдээх, түүнчлэн олон улсын зах зээл дээрээс 3 болон түүнээс дээш жилийн хугацаатай бонд болон зээл хэлбэрээр банкны татсан гадаад валютын эх үүсвэрийг Заавал байлгах нөөцийн шаардлагаас чөлөөлөх шийдвэрүүдийг тус тус гаргасан. Эдгээр нь нэг талаас тогтвортой байдлыг хадгалах, эдийн засгийн тэнцвэртэй өсөлтийг дэмжих макро бодлогыг үргэлжлүүлж, эдийн засгийн бодит секторын идэвхжилийг дэмжих, нөгөө талаас эдийн засаг дахь урт хугацаатай гадаад валютын эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд чиглэсэн шийдвэрүүд байв.

Түүнчлэн, дотоодын макро эдийн засгийн орчин, мөнгөний зах зээлийн хөгжлийн шаардлага, мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх олон улсын шилдэг туршлагад суурилан хүүгийн коридорыг 2013 оны 2 дугаар сарын 27-ны өдөр шинээр нэвтрүүлснээр банк хоорондын зах илүү үр ашигтай ажиллах, хүүний хэлбэлзэл буурах, Төв банкны үнэт цаасны хэмжээ буурах суурь нөхцөл бүрдэхийн зэрэгцээ Монголбанкнаас банкуудын авах санхүүжилтийн хүү буурч, эдийн засгийн идэвхжилд эерэгээр нөлөөлж байна.

- **Хэрэглээний үнийн индекст голлох нөлөөтэй өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний нөөц бүрдүүлж, оновчтой хуваарилан, нийлүүлэлтийг жигд хангаж, үнийн хэлбэлзлийг бууруулах бодлогыг хэрэгжүүлсэн.**

Монголбанк эрэлтийн инфляцийг бага байлгахын зэрэгцээ Засгийн газартай хамтран нийлүүлэлтийн гаралтай буюу зардлын шалтгаантай инфляцийн дарамтыг бууруулах чиглэлд ажиллаж, нийлүүлэлтийн гаралтай инфляци үүсэх хүчин зүйлсийн үндсэн шалтгааныг арилгах, мах, гурил, жижиглэнгийн худалдааны шатахуун зэрэг хэрэглээний суурь барааны нийлүүлэлтийг сайжруулах замаар үнийн өсөлтийг нь тогтворжуулах, дунд хугацаанд гол нэрийн бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн үр ашигтай, зах зээлийн зарчимд суурилсан тогтолцоог бүрдүүлэх зорилго бүхий “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дунд хугацааны хөтөлбөрийг 2012 оны 10 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлсэн хугацаанд нийлүүлэлтийн гаралтай инфляци мэдэгдэхүйц буурч, хөтөлбөрт хамрагдаж буй бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт нь өмнөх онуудтай харьцуулахад үлэмж буураад байна.

- **Банкуудын зээлийн журам, түүний хэрэгжилтэд үзлэг шалгалт хийх, банкны зээлийн үйл ажиллагаанд шударга бус хэлцэл үүсэх боломжийг хязгаарлах болон зээлдэгчдэд учрах хүү, шимтгэлийн дарамтыг багасгах чиглэлээр холбогдох арга хэмжээ авсан.**

Монголбанкнаас ажлын хэсэг байгуулж, 2012 онд банкуудын мөнгөн хадгаламж, үнэт цаас, зээлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа хууль тогтоомж, заавар журам, тэдгээрийн хэрэгжилт, мөнгөн хадгаламж, үнэт цаас, зээлийн үйл ажиллагаатай холбоотой ажил үйлчилгээний нөхцөл, шимтгэл, хураамжийн байдал, хүү тооцох аргачлал зэргийг бүх банкууд дээр очиж шалгалт хийсэн. Шалгалтын дүгнэлтэд үндэслэн “Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журам” болон “Мөнгөн хадгаламж, зээлийн хүү болон үнэт цаасны өгөөж, хямдруулалтын хувь хэмжээг бодох ерөнхий аргачлал”-ыг тус тус боловсруулж, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2013 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн тушаалаар баталсан.

- **Зээлийн мэдээллийн санг өргөтгөх ажлын хүрээнд төрийн эрх бүхий байгууллагатай холбогдох, тэдгээрийн мэдээллийн сантай мэдээлэл солилцох, түүнд банк, санхүүгийн байгууллагууд нэвтрэх нөхцөлийг бүрдүүлсэн.**

Монголбанкнаас бичил санхүүгийн байгууллагуудыг зээлийн мэдээллийн санд бүрэн хамруулах ажлыг хийснээр одоогоор байдлаар нийт 13 банк, 150 банк бус санхүүгийн байгууллага, 48 хадгаламж зээлийн хоршоотой мэдээлэл солилцож байна.

- **Мөнгөний захын хөгжлийг түргэтгэж, дунд болон урт хугацаат эх үүсвэрийг нэмэгдүүлэх суурийг бүрдүүлэх, жишиг хүү болон өгөөжийн муруйг бий болгох**

үүднээс Засгийн газрын богино, дунд, урт хугацаат дотоодын үнэт цаасны арилжааг тогтмолжуулсан.

Засгийн газрын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлийг хөгжүүлж, арилжааг тогтмол хийх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2012 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 217/А-161 тоот хамтарсан тушаалаар “Засгийн газрын үнэт цаас гаргах, арилжаалах журам”-ыг, Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2013 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн 111/А-105/131 тоот хамтарсан тушаалаар “Засгийн газрын үнэт цаасыг хоёрдогч зах зээлд арилжих журам”-ыг тус тус баталсан. Улмаар Засгийн газрын үнэт цаасны арилжааны цахим систем (платформ)-ийг ашиглан 12, 28, 52 долоо хоногийн богино хугацаатай, 3, 5, 10 жилийн урт хугацаатай үнэт цаасыг шууд болон шууд бус оролцогчдод арилжаалж байгаа бөгөөд 2014 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар богино хугацаатай ЗГҮЦ-ны үлдэгдэл 629.2 тэрбум төгрөг, дунд, урт хугацаатай ЗГҮЦ-ны үлдэгдэл нийт 1206.5 тэрбум төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий ЗГҮЦ-ыг арилжаалжээ.

- **Хадгаламжийн даатгалын тогтолцоог нэвтрүүлсэн.**

"Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай" хуулийн үйлчлэх хугацаа 2012 оны 11 дүгээр сард дууссантай холбогдуулан Монголбанк, Засгийн газар, СЗХ-оос хамтран “Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай” хуулийг УИХ-аар 2013 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр шинээр батлуулсан.

- **Зээлийн эрсдэлийг бууруулах зорилгоор зээлийн даатгал, баталгаа, батлан даалтын тогтолцоог бий болгох эрх зүйн орчин бүрдсэн.**

Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийн боломжийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, иргэдийн орлогын тогтвортой эх үүсвэрийг хангах зорилго бүхий зээлийн батлан даалтын сангийн эрх зүйн үндсийг тогтоож, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд зээлийн батлан даалтын үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилт бүхий “Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль”-ийг 2012 оны 2 дугаар сарын 10-ны өдөр баталсан. Энэхүү хууль батлагдсанаас хойш зээлийн батлан даалтын сан байгуулах, үйл ажиллагааг нь тогтмолжуулж, жигдрүүлэх ажлууд хийгдсэн.

- **Хувь хүн болон компанийн зээлийн түүхийн мэдээллийн сангийн найдвартай байдал, үйл ажиллагааг сайжруулж, түүний ашиглалтыг нэмэгдүүлэх нөхцөл бүрдсэн.**

Зээлийн мэдээллийн чанар агууламжийг сайжруулах, зээлийн мэдээллийн лавлагааг түгээх сувгийн хамрах хүрээг өргөтгөх чиглэлээр тодорхой ажлууд хийгдэх нөхцөлийг бүрдүүлсэн “Зээлийн мэдээллийн тухай хууль” батлагдсан. Хуульд заасны дагуу зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагаа, мэдээллийг хадгалах, боловсруулах зэрэгт нууцлал, аюулгүй байдлын талаарх тодорхой шаардлагууд тавигдаж байгаа бөгөөд мэдээллийн аюулгүй байдалд тавих хяналт, хариуцлагыг тодорхой болгосон. Түүнчлэн, тус хуулийн хүрээнд зээлийн мэдээллийн үйлчилгээг хувийн байгууллага эрхлэх боломжтой болж байгаатай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2012 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн А-197 дугаар тушаалаар "Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгох тухай журам"-ыг баталсан.

• **“Зээлийн хүү буурах зах зээлийн орчныг бүрдүүлэхэд чиглэсэн 2013-2016 онд хэрэгжүүлэх дунд хугацааны шинэчилсэн хөтөлбөр”-ийн талаар**

2011-2013 онуудад хэрэгжсэн “Зээлийн хүү буурах зах зээлийн орчинг бүрдүүлэх хөтөлбөр”-ийн үргэлжлэл болгон “Зээлийн хүү буурах зах зээлийн орчинг бүрдүүлэхэд чиглэсэн 2014-2016 онд хэрэгжүүлэх дунд хугацааны шинэчилсэн хөтөлбөр”-ийн эхний найруулгыг Монголбанк анх 2013 оны эхний хагаст холбогдох байгууллага, газруудаас санал авсны үндсэн дээр шинэчлэн боловсруулж, түүнийг батлах тухай хамтарсан тушаалын хамт өргөн барьж, ЭЗХЯ-аас бусад хамтран хэрэгжүүлэгч байгууллагуудаар батлуулаад байсан ч хараахан албажаагүй байсан. Иймд 2014 оны 06 дугаар сард УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооноос өгсөн даалгаврын дагуу хөтөлбөрийн төсөлд зарим заалтуудыг нэмж тусган, шаардлагатай мэдээллийг шинэчлэн боловсруулсан бөгөөд “Зээлийн хүү буурах зах зээлийн орчинг бүрдүүлэхэд чиглэсэн 2014-2016 онд хэрэгжүүлэх дунд хугацааны шинэчилсэн хөтөлбөр” нь Монголбанкны Ерөнхийлөгч, Эдийн засгийн хөгжлийн сайд, Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2014 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн А-137/67/187/232 тоот хамтарсан тушаалаар батлагдаад байна.

Дээрх хөтөлбөрийн хүрээнд банкуудын өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэн салбарын эрсдэл даах чадварыг дээшлүүлэх, хязгаарлагдмал хадгаламжийн даатгалын тогтолцоог бэхжүүлэх, санхүүгийн бусад байгууллагыг хадгаламжийн даатгалын тогтолцоонд хамруулах эрх зүйн орчинг бүрдүүлэх, банк болон бусад санхүүгийн байгууллагын зээлийн барьцаа хөрөнгөтэй холбоотой хууль эрх зүйн орчинг сайжруулах, банкны зээл олгохтой холбоотой шимтгэл хураамжийн зардлыг бууруулах зэрэг ажлуудыг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

Монголбанк дээрх хөтөлбөрийн хүрээнд санхүүгийн зах зээлд оролцогчдын суурь мэдлэгийг дээшлүүлэх зорилготойгоор “Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журам”-ыг боловсруулан, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2013 оны 12-р сарын 13-ны өдрийн тушаалаар баталж, 2014 оны 1 дүгээр сараас эхлэн мөрдүүлж эхлээд байна. Уг журмын дагуу банкуудын зээл, хадгаламжийн хүү, шимтгэл хураамжийн мэдээллийг банк тус бүрээр харьцуулсан байдлаар сар бүр, бүтээгдэхүүний төрөл тус бүрээр Монголбанкны цахим хуудаст нийтэлдэг болсон. Ингэснээр банкны харилцагчдад банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний мэдээллийг ил тод байлгах, банкуудын зээлийн хүүг харьцуулах боломжийг харилцагчдад олгох, харилцагчийн эрх ашгийг хамгаалах, банкуудын хүүгийн өрсөлдөөнийг дэмжих замаар зээлийн хүү буурах орчинг сайжруулах арга хэмжээ авч ажиллаж байна.

Журмын хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор 2014 оны 3 дугаар сард банкуудын тэтгэврийн зээлийн нөхцөл, хүү тооцож буй аргачлалыг шалгаж, журмыг бүрэн мөрдөж ажиллаагүй зарим банкинд улсын байцаагчийн акт тогтоох, биелэлтийг хангуулах арга хэмжээ авч байна. Мөн энэхүү журам батлагдсантай уялдан банкуудын ажилтнууд, хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлчидтэй 2014 оны 2 дугаар сард зээлийн бодит өртгийн талаар ярилцлага, уулзалт, сургалтуудыг зохион байгуулж, арга зүйн зөвлөгөө өгснөөс гадна банкуудын хүү, шимтгэл өөрчилсөн шийдвэрт хяналт тавин ажиллаж байна.

Монголбанк хадгаламжийн даатгалын системийг бүрэн нэвтрүүлэх хүрээнд 2013 онд УИХ-аар батлуулсан “Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль”-ийн хэрэгжилтийг Хадгаламжийн даатгалын корпорацитай хамтран хангаж, тус системийг нэвтрүүлэх ажлыг хийж байгаа болно.

Банкуудын төгрөгийн жигнэсэн дундаж хүү 2014 оны 8 дугаар сарын байдлаар

Монголбанкнаас хэрэгжүүлж буй хөтөлбөрийн зээлийг оруулж тооцвол 15.7% байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 0.3 нэгж хувиар, 2013 оны 3 дугаар сард оргил түвшиндээ хүрч байсантай харьцуулахад 3.9 нэгж хувиар тус тус буурсан үзүүлэлт юм. Харин гадаад валютын зээлийн жигнэсэн дундаж хүү 2014 оны 8 дугаар сарын байдлаар 12.3% болж өмнөх оны мөн үеэс 0.2 нэгж хувиар, хамгийн өндөр түвшин буюу 2013 оны 3 дугаар сараас 1.9 нэгж хувиар тус тус буурсан байна.

3.3. Бичил, жижиг, дунд бизнесийн санхүүжилтийг дэмжиж ажиллах (Засгийн газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо)

Монголбанкнаас банкуудаар дамжуулан бичил, жижиг, дунд бизнесийн санхүүжилт хийх тохиолдолд энэ нь банкууд, банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)-уудын зах зээлийн чөлөөт өрсөлдөөнд сөргөөр нөлөөлж болзошгүй байна. Иймд, бичил, жижиг, дунд бизнесийн санхүүжилтийн асуудалд Төв банкны зүгээс баримтлах бодлого, зарчим, оролцооны хэм хэмжээний талаар олон улсын жишиг, практикт үндэслэсэн судалгааг Санхүүгийн зохицуулах хороо болон ББСБ-ын Холбоотой хамтран хийж дуусаад байна. Тус судалгаанд үндэслэн бичил, жижиг, дунд бизнесийн санхүүжилтэд учирч буй бэрхшээл, хүндрэлийг тодорхойлж, улмаар Монголбанкнаас баримтлах бодлого, зарчмын байр суурь, оролцооны хэм хэмжээг тодорхойлох болно. Түүнчлэн ББСБ-уудаар дамжуулан бичил зээл олгох асуудлыг 2014 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн СТБЗ-ийн хурлаар хэлэлцсэний үр дүнд энэ чиглэлд СЗХ болон ББСБ-ын холбоо санаачилга гарган ажиллахаар болсон бөгөөд Монголбанкны зүгээс дэмжин ажиллахаа мэдэгдсэн.

Тогтвортой болон оролцоотой санхүүжилт, байгаль орчин, ногоон бизнесийн санхүүжилтийн үйл ажиллагааны хүрээнд Монголын банкуудын холбоо, Байгаль орчин, ногоон хөгжлийн яамтай хамтран тогтвортой санхүүжилтийн хөтөлбөрийн ажлын хэсгийг байгуулсан бөгөөд уг ажлын хэсэг нь *“Монгол Улсын нийгэм, байгаль орчинд ээлтэй, тогтвортой санхүүжилтийн бодлогыг хөгжүүлэхийн төлөө хамтарсан тунхаг бичиг”*-ийг боловсруулж, банкуудтай хамтран ажиллан *“Монгол Улсын тогтвортой санхүүжилтийн зарчмуудын удирдамж”*-ын төслийг боловсруулсан бөгөөд түүнийг холбогдох байгууллагуудаар батлуулахаар ажиллаж байна.

Монголбанк бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийн саад хязгаарлалтуудыг арилгах замаар нийлүүлэлтийн гаралтай инфляцийн дарамтыг багасгах, бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийн үр ашигтай, байнгын, тогтвортой тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Засгийн газартай хамтран *“Тол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөр”*-ийг 2012 оны 11 дүгээр сараас хэрэгжүүлж байгаа бөгөөд энэ хүрээнд жижиг, дунд бизнесийн санхүүжилтийг мөн дэмжин ажиллаж байна. Тухайлбал, 5 дэд хөтөлбөрийн хүрээнд банкууд хөтөлбөрийг хэрэгжүүлэгч 240 орчим аж ахуйн нэгжид эргэлтийн хөрөнгийн зээл олгожээ. Мөн банкууд орон сууцны барилгын нийлүүлэлтийг нэмэгдүүлэхэд зориулж 114 компанид Монголбанкны эх үүсвэрээр зээл олгосон байна.

Монголбанкнаас банкуудаар дамжуулан олгох төслийн зээлүүдийн хүрээнд жижиг, дунд үйлдвэрүүдэд хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгон ажиллаж байна. Тухайлбал, ХБНГУ-ын Сэргээн босголт, хөгжлийн банк (КфВ)-ны санхүүжилттэй *“Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх”* төслийн хүрээнд Монголбанк 2014 оны 8 дугаар 31-ний өдрийн байдлаар 44 ЖДҮ эрхэлдэг аж ахуйн нэгжид 6.8 сая еврогийн зээл олгоод байна.

Мөн, Азийн хөгжлийн банкны “Ажлын байр нэмэгдүүлэх” төслийн хүрээнд 2014 он гарсаар 2 бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэдэд 1.04 тэрбум төгрөгийн зээлийг оролцогч банкуудаар дамжуулан шинээр олгосон бөгөөд 2014 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар банкуудад олгосон нийт зээлийн үлдэгдэл (7 аж ахуйн нэгжийн) 1.8 тэрбум төгрөг байна. Уг төслийн хүрээнд 2014 оны 2 дугаар улирлын эцсийн байдлаар нийт 283 ажлын байр шинээр бий болоод байна.


Монголбанкнаас хөдөө орон нутаг дахь бичил болон жижиг, дунд бизнесийн санхүүжилтийн хүртээмжийг сайжруулах боломжийн талаар 13 аймгийг хамарсан түүвэр судалгааг 2014 оны 5 дугаар сараас хийж байгаа бөгөөд судалгааны үр дүнг 3 дугаар улиралд тайлагнана.

3.4. Валютын захад тогтворгүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллах (Засгийн газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо)

Монголбанкнаас валютын зах дахь эрэлт, нийлүүлэлтийн богино хугацааны зөрүүг багасгах, ханшийн огцом хэлбэлзлийг зөөлрүүлэх зорилгоор оны эхнээс нийт 66 удаа валютын дуудлага худалдааг зохион байгуулж, шаардлагатай зохицуулалтыг тухай бүр хийсэн. Мөн шаардлагатай үед санхүүгийн үүсмэл хэрэгслийн захад оролцох нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж, төгрөг-ам.долларын, төгрөг-юанийн своп, форвард хэлцлүүдийг банкуудтай тогтмол хийж байгаа нь валютын захын тогтвортой байдлыг хангах, банкуудын валютаар төлбөр түргэн гүйцэтгэх чадварт дэмжлэг үзүүлэх, ханшийн эрсдэлийг бууруулахын зэрэгцээ санхүүгийн салбарыг бүхэлд нь системийн шинжтэй эрсдэлээс хамгаалах ач холбогдолтой болж байна. 2014 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар оны эхнээс өссөн дүнгээр нийт 2.99 тэрбум ам.доллартай тэнцэх хэмжээний төгрөгийн своп, 827 сая ам.долларын своп, 135 сая юанийн своп хэлцлийг банкуудтай байгууллаа.

Үүний үр дүнд оны эхнээс 2014 оны 8 дугаар сарыг дуустал хугацаанд төгрөгийн ам.доллартай харьцах ханш нэг өдөрт хамгийн ихдээ 1.97%-иар чангарч, 1.66%-иар суларч, нэг өдөрт ногдох дундаж хэлбэлзэл нь 0.20% байна. Мөн хугацаанд ханшийн өдрийн хэлбэлзэл нийт өдрийн 90%-д нь 0.4% дотор, үлдсэн 10%-д нь хамгийн ихдээ 1.97%-иар хэлбэлзжээ. Гэсэн хэдий ч ханшийн нэг өдөрт ногдох дундаж хэлбэлзэл 0.20% байгаа нь 2012, 2013 оны мөн үетэй ижил түвшинд байна.

Зураг 66. Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн өөрчлөлт (интервалаар)



Эх сурвалж: Монголбанк

Монголбанк төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцтэйгээр уян хатан тогтож байх зарчмыг баримталж байна. Манай

улсын төлбөрийн тэнцлийн урсгал данс 2011-2013 онуудад дунджаар ДНБ-ий 30 гаруй хувьтай тэнцэх хэмжээний буюу үлэмж хэмжээний алдагдалтай байсан бөгөөд уг алдагдлыг 2011-2012 онд хөрөнгө, санхүүгийн дансны ашгаар нөхөж ирсэн. Гэвч хөрөнгө, санхүүгийн дансны ашиг 2013 онд 3.5 тэрбум ам.доллараар буюу 71%-иар, 2014 оны эхний 7 сарын урьдчилсан гүйцэтгэлээр өмнөх оны мөн үетэй харьцуулахад 845 сая ам.доллараар буюу 87%-иар буурч, 123 сая ам.долларт хүрсэн байна. Энэ нь урсгал тэнцлийн алдагдал 947 сая ам.долларыг нөхөж чадахгүйд хүрснээр төлбөрийн нийт тэнцэл оны эхний 7 сард 978 сая ам.долларын алдагдалтай гарлаа. Ийнхүү төлбөрийн тэнцэл өндөр алдагдалтай хэвээр байгаа нь төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг сулруулах чиглэлд нөлөөлөв.

Хэдийгээр оны эхнээс гадаад худалдаа, урсгал тэнцлийн алдагдал эрс багассан ч, хөрөнгө, санхүүгийн дансны ашиг, түүний дотор гадаадын шууд хөрөнгө оруулалт огцом буурсны нөлөөгөөр төгрөгийн ам.доллартай харьцах ханш 8 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар оны эхнээс 9.1%-иар, төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханш (NEER) оны эхний 8 сард 7.2%-иар, бодит үйлчилж буй ханш (REER) оны эхний 7 сард 3.2%-иар тус тус суларсан үзүүлэлттэй байна. Энэ нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцэж байгаа бөгөөд Монголбанкнаас баримталж буй ханшийн бодлого нь гадаад зах зээлээс дотоодын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг зөөлрүүлж, гадаад худалдаа, эдийн засаг дахь зайлшгүй шаардлагатай тохиргоо хийгдэх нөхцөлийг бүрдүүлж байна.

Монголбанк гадаад валютын орох урсгалыг дэмжих, гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх, ханшийн эрсдэлийг бууруулах зорилгоор “Урт хугацаат своп хэлцэл”-ийг шинээр нэвтрүүллээ. Монголбанк банкуудтай урт хугацаат своп хэлцэл байгуулснаар банк, түүний харилцагчдын ханшийн эрсдэл буурч, валютын захын тогтвортой байдалд эергээр нөлөөлж байна. Түүнчлэн, Монголбанк валютын захад тогтворгүй байдал үүссэн буюу онцгой нөхцөлд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө (contingency plan)-г боловсруулан баталж ажиллав.

Гадаад валютын зээлийн эрсдэлийг бууруулах макро зохистой бодлогын хүрээнд ханшийн эрсдэлээс хамгаалагдаагүй гадаад валютын зээлийн эрсдэлийн жинг өсгөх замаар банкуудын төлбөрийн чадвар, өөрийн хөрөнгийн хүрэлцээг чангатгаж, зээлийн эрсдэлийг бууруулах асуудлыг судлан, “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-д Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн А-122 дугаар тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулж, гадаад валютын зээлийн эрсдэлээр жигнэх хувийг нэмэгдүүлсэн. Энэ нь долларжилтыг саармагжуулах, гадаад валютын зээлийн эрсдэлийг бууруулах, улмаар санхүүгийн тогтвортой байдлыг дунд хугацаанд хангах чиглэлд чухал алхам боллоо.

3.5. Валютын захад банк бус санхүүгийн байгууллага, санхүүгийн зах зээлийн бусад оролцогчийг идэвхтэй оролцуулах, ханшийн эрсдэлээс хамгаалах санхүүгийн үүсмэл хэрэгслийг зах зээлд нэвтрүүлэх зорилгоор валютын арилжааны тогтолцоог бий болгох (Засгийн газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо)

Валютын захад банк бус санхүүгийн байгууллагуудыг оролцуулах зорилгоор Санхүүгийн зохицуулах хороо, Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбооны холбогдох албан тушаалтнуудтай хэд хэдэн удаа уулзалт зохион байгууллаа. Тус уулзалтаар ББСБ-уудыг Монголбанкнаас зохион байгуулдаг валютын дуудлага

худалдаанд спот болон санхүүгийн үүсмэл хэрэгслийн (своп, форвард хэлцэл) захад одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж, журмын хүрээнд банкуудаар дамжуулан оролцуулах боломжтой талаар Монголбанкнаас мэдэгдсэн. Уг асуудлыг СТБЗ-ийн 2014 оны 6 дугаар сард болсон ээлжит хуралдаанаар хэлэлцсэний үр дүнд гадаад валютын дуудлага худалдааг банк бус санхүүгийн байгууллагууд болон санхүүгийн зах зээлийн бусад оролцогчдын хувьд нэвтрүүлэх чиглэлээр Санхүүгийн зохицуулах хороо, Банк бус санхүүгийн байгууллагын холбооноос санаачлага гарган ажиллах, энэ хүрээнд банк бус санхүүгийн байгууллагуудын хооронд валютын арилжаа, дуудлага худалдааны платформ бий болгох нь оновчтой гэж үзсэн бөгөөд Монголбанк энэ чиглэлээр хамтран ажиллах санамж бичиг байгуулах, уг асуудалд арга зүйн зөвлөмж өгөх чиглэлээр ажиллаж байна.

3.6. Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагааг төлөвшүүлэх, эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийн суурь нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор макро зохистой бодлогыг харилцан уялдаатай хэрэгжүүлэн, санхүүгийн салбарын байдлыг улирал бүр олон нийтэд мэдээлэх арга хэмжээ авч ажиллах (Засгийн газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо)

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ) нь макро эдийн засгийн төлөв байдал, эдийн засагт учирч буй хүндрэл бэрхшээл, тэдгээрийг шийдвэрлэх арга замууд, бодлогын харилцан уялдааг хангах тухай болон цаг үеийн шинжтэй бусад асуудлаар зөвлөлдөж, холбогдох шийдвэрийг гарган ажиллаж байна.

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ)-ийн 2014 оны 1 дүгээр улирлын ээлжит хуралдааныг 2014 оны 3 дугаар сарын 28-ны өдөр Монголбанкинд зохион байгуулсан бөгөөд тус хуралдаанаар: (i) 2014 оны эхний 2 сарын байдлаарх макро эдийн засгийн нөхцөл байдал, валютын ханшид нөлөөлсөн хүчин зүйлс, (ii) АНУ-ын иргэн, хуулийн этгээдийн “Гадаад дахь дансдын хөрөнгийг татварт хамруулах тухай” хуулийг хэрэгжүүлэх талаар АНУ-ын зүгээс тавьсан хүсэлтийн тухай, (iii) Урт хугацааны даатгалтай холбоотой эрх зүйн орчны зарим асуудлууд, (iv) Монголбанкнаас боловсруулдаг бусад санхүүгийн байгууллагын тоймын хамрах хүрээг сайжруулах санал зэрэг асуудлыг авч хэлэлцсэн болно. Хуралдаанаас гарсан шийдвэрийн дагуу Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс холбогдох газруудад хариуцсан чиглэлээр тодорхой үүрэг даалгавар өгсөн.

Тухайлбал, оны эхнээс гадаад худалдаа тэнцвэржиж байгаа хэдий ч, санхүүгийн дансны урсгал, түүний дотор гадаадын шууд хөрөнгө оруулалт мэдэгдэхүйц сайжраагүй, экспортод гаргасан нүүрсний орлогын зарим хэсэг нь орж ирээгүй зэргээс шалтгаалж төлбөрийн тэнцэл дэх дарамт арилахгүй байна. Ийм орчинд улсын төсвөөр дамжуулж буюу түүнээс гадуур төсөвтэй адилтгах төгрөгийн зарцуулалтыг Хөгжлийн банк, Төрийн банкнаас гэнэт хийх нь валютын захад сөргөөр нөлөөлөх, улмаар төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг богино хугацаанд сулруулахад нөлөөлж байгааг тогтоов. Энэ үндсэн дээр СЯ, ЭЗХЯ, Хөгжлийн банкнаас ирээдүйд хийх төгрөгийн зарцуулалтын мэдээг 7 хоног тутамд Монголбанкинд хүргүүлж, урьдчилан мэдээлж байх замаар макро бодлогын харилцан уялдааг хангаж байхаар тогтсон.

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ)-ийн 2014 оны 2 дугаар улирлын ээлжит хуралдаан 2014 оны 6 дугаар сарын 23-ны өдөр болсон бөгөөд тус хуралдаанаар (i) ББСБ-уудыг Монголбанкны гадаад валютын дуудлага худалдаанд оролцуулах, (ii) гадаад валютын своп, форвард хэлцэл байгуулах болон Монголбанкны үнэт цаас

худалдан авах, бичил санхүүгийн зээлийг дамжуулан зээлдүүлэх үйл ажиллагаанд хамруулах тухай, (iii) Монгол Улсын зээлжих зэрэглэл, түүнд нөлөөлсөн хүчин зүйлсийн шинжилгээ, (iv) Монгол Улсын гадаад секторын болон гадаад валютын дотоодын захын тойм, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн шийдвэр зэрэг асуудлыг авч хэлэлцсэн. СТБЗ нь улирал бүр хуралдах хуваарьтай бөгөөд шаардлагатай гэж үзсэн тухай бүр ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах боломжтой байна.

Монголбанк дахь Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн ажлын алба (СТБЗАА) нь тайлант хугацаанд “Монгол Улсын Санхүүгийн тогтвортой байдлын тайлан”-гийн 3 дахь дугаарыг нэгтгэн боловсруулж хэвлүүлэн, Монголбанкны цахим хуудаст байршуулж олон нийтийн хүртээл болгов. Санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй эрсдэлийг тодорхойлон, эдийн засгийн нөхцөл байдалд нийцсэн макро зохистой бодлогын арга хэмжээг судалж, бодлогын санал боловсруулах ажлын хүрээнд хагас жил тутам гардаг “Санхүүгийн тогтвортой байдлын тайлан”-д макро зохистой бодлогын арга хэрэгслүүдтэй холбоотой асуудлуудыг тусгаж оруулсан. Түүнчлэн, хэрэгжүүлэх боломжтой гэж үзсэн макро зохистой бодлогын арга, хэрэгслүүдийн талаар судалгаа хийж байна. 2014 оны 2 дугаар хагаст Санхүүгийн тогтвортой байдлын тайлангийн 4 дэх дугаарыг бэлтгэн гаргана.

СТБЗАА-наас “Макро эдийн засаг, санхүүгийн салбарын улирлын тойм”-ыг боловсруулж, улирал бүрийн дараа улиралд багтаан цахим хуудаст байршуулж, олон нийтэд мэдээлж байна. Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо нь өөрсдийн хариуцсан чиглэлээр санхүүгийн салбар, гадаад сектор, макро эдийн засгийн талаарх тайлан мэдээлэл, статистик мэдээ, судалгаа шинжилгээг боловсруулж, өдөр, сар, улирлын давтамжтайгаар, цахим хуудсаар дамжуулан олон нийтэд тогтмол түгээж байгаа болно.

5.1. Монгол Улсын зээлжих зэрэглэл, түүний өөрчлөлтөд нөлөөлсөн хүчин зүйлийн шинжилгээг тогтмол хийж, зээлжих зэрэглэлийг сайжруулах чиглэлээр зөвлөмж боловсруулан, УИХ-ын ЭЗБХ болон СТБЗ-д танилцуулж байх

Монгол Улсын зээлжих зэрэглэлийг олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч Стандарт энд Пүүрс агентлаг нь 2014 оны 4 дүгээр сард “ВВ- зэрэглэлийн сөрөг төлөв”-өөс “В+ зэрэглэлийн тогтвортой төлөв”-тэй болгон бууруулсан, харин Мүүдиз агентлаг 2014 оны 5 дугаар сард “В1 зэрэглэлийн тогтвортой төлөв”-ийг “В1 зэрэглэлийн сөрөг төлөв” болгон өөрчилсөн байна. Мөн энэ оны 7 дугаар сарын 17-ны өдөр Монгол Улсын зээлжих зэрэглэлийг В1-с В2 хүртэл дахин буурууллаа.

Стандарт энд Пүүрс агентлаг нь Монгол Улсын зээлжих зэрэглэлийг дараах үзүүлэлтэд үндэслэн бууруулсан. Үүнд: (i) гадаадын шууд хөрөнгө оруулалтын урсгал татарч, экспортын орлого буурснаар төлбөрийн тэнцэл ихээхэн алдагдалтай болж, гадаад валютын улсын нөөц буурсан, (ii) төсвөөс гадуурх зарцуулалт өссөн, (iii) төрийн байгууллагуудын бодлого боловсруулалт, шийдвэр гаргалт, засаглалын түвшин сул, төрийн бодлого тогтворгүй байгаа нь хөрөнгө оруулагчдад эргэлзээ төрүүлж байна гэсэн үндэслэлүүдийг дурджээ. Харин Мүүдиз агентлаг (i) Монгол Улсын гадаад өрийн дарамт нэмэгдсэн, (ii) гадаадын шууд хөрөнгө оруулалт буурч, улмаар гадаад валютын улсын нөөц буурсан, (iii) зээлийн өсөлт өндөр байгаа зэрэгт үндэслэн төлвийг бууруулжээ.

Монголбанкнаас зээлжих зэрэглэл тогтоогч дээрх байгууллагуудын үнэлгээний аргачлал, дүгнэлтэд үндэслэн “Монгол Улсын зээлжих зэрэглэл, түүнд нөлөөлсөн хүчин

зүйлсийн шинжилгээ”-г боловсруулсан. Энэхүү шинжилгээнд зээлжих зэрэглэлийг цаашид сайжруулахад чиглэсэн дараах санал, зөвлөмжийг тусгалаа. Үүнд:

- УИХ-ын 2014 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн 34 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах,
- Улсын эрсдэлд мэдрэмтгий байдлыг бууруулж, эрсдэл даах чадварыг сайжруулж, улмаар ГВУН-ийг нэмэгдүүлэх,
- Гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлэх, төлбөрийн тэнцлийг сайжруулах арга хэмжээ авах,
- ГШХО-ын бодлого, зохицуулалтын орчинг тодорхой, тогтвортой, урьдчилан тааварлахуйц байлгах,
- Уул уурхайн томоохон төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хурдасгах,
- Экспортын бүтээгдэхүүний тээвэрлэлтийн өртөг, зардлыг бууруулах дэд бүтцийг барьж байгуулах замаар экспортын өрсөлдөх чадварыг сайжруулах,
- Төсвөөс гадуурх зарцуулалтыг төсөвт оруулж тооцох, төсвийн тогтвортой байдлыг хангах, төсвийн орлогыг бодитой төлөвлөж, түүнтэй уялдуулан төсвийн зардлыг бууруулах,
- Банк санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх,
- Хөгжлийн санхүүжилтийн боломжийг нэмэгдүүлэх хууль, эрхзүйн орчинг бүрдүүлэх,
- Бодлогын тогтвортой байдлыг ханган, хуримтлалд суурилсан макро бодлогыг тууштай хэрэгжүүлж, эдийн засгийн бүтцийг дунд болон урт хугацаанд төрөлжүүлэх.

“Монгол Улсын зээлжих зэрэглэл, түүнд нөлөөлсөн хүчин зүйлсийн шинжилгээ №1”-г Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 2014 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн хуралд хэлэлцүүлсэн ба УИХ-ын Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлж, зөвлөмжийг олон нийтэд түгээхээр тогтсон. Түүнчлэн, Мүүдиз агентлаг зээлжих зэрэглэлийг бууруулсантай холбогдуулан шинжилгээний тайлангийн 2 дахь дугаарыг боловсруулав.

5.2. Монголбанкны хараат бус байдлыг бэхжүүлэх, засаглалын бүтэц, зохион байгуулалтыг олон улсын жишигт нийцүүлэх зорилгоор хараат бус гишүүд бүхий мөнгөний бодлогын зөвлөлийг бий болгох чиглэлээр Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд холбогдох өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах

Монголбанк Төв банкны хараат бус байдлыг бэхжүүлэх, засаглалын сайн туршлагуудыг Монголбанкны үйл ажиллагаанд нэвтрүүлэх үндэс суурийг бүрдүүлэх, хараат бус гишүүд бүхий Мөнгөний бодлогын зөвлөлийг бий болгох зорилгоор дэлхийн улс орнуудын төв банкны тухай хуулиудыг судалсан. Түүнчлэн, ОУВС-гийн мэргэжилтнүүд, “Төсөөлөл бодлогын шинжилгээний систем (FPAS)” төслийн зөвлөхүүдтэй уулзалт хийж, улс орнуудын төв банкны хараат бус байдлыг хэрхэн бэхжүүлэх, Мөнгөний бодлогын зөвлөлийн нийтлэг зарчмуудыг илүү сайн хангах чиглэлээр зөвлөлдөв. Дээрх зөвлөхүүд Мөнгөний бодлогын зөвлөлийн олон улсын сайн туршлагад хамаарах 5 зарчмыг²³ хуульдаа тусгахыг зөвлөмж болгосон. Эдгээр судалгаа, зөвлөмжид үндэслэн

²³ (i) Зөвлөлийн гишүүдийг 5-аас доошгүй жилээр томилж ажиллуулах, (ii) Засгийн газрын гишүүнийг тус зөвлөлд оруулахгүй байх, (iii) Гишүүнийг нэр дэвшүүлэх, батламжлах субъектүүд нь өөр өөр байх буюу “2 алхамт” системээр зохицуулагддаг байх, (iv) Гишүүдийн цалин нь гишүүнээр ажиллах хугацаанд буурдаггүй байх, (v) Гишүүдийг чөлөөлөх үйл явцыг нарийвчлан тусгах, зөвхөн ноцтой тохиолдолд гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлдөг байх гэх мэт.

Монголбанкнаас Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж эхлээд байна.

5.3. Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагааны үр дүн, шийдвэр гаргах механизм, хариуцлагын тогтолцоог сайжруулах, зөвлөлийн бүрэлдэхүүнийг өргөтгөх, санхүүгийн салбарт үүсч болзошгүй эрсдэлийг үнэлэх, түүнээс хамгаалах бодлогын уялдааг хангах үр дүнтэй институци болгох чиглэлээр Төв банк (Монголбанк)-ны тухай хууль болон холбогдох бусад хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах

Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар ажлын хэсэг томилон ажиллуулж байгаа бөгөөд тус ажлын хэсэг нь Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл болон түүний үзэл баримтлалыг боловсруулж байна. Хуулийн төсөл, түүний үзэл баримтлалыг боловсруулахад дэмжлэг болгох үүднээс Монголбанкин дахь Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн ажлын албанаас тайлант хугацаанд “Макро зохистой бодлогыг хэрэгжүүлэгч институцийн загвар: Олон улсын түвшинд харьцуулсан судалгаа”-г гүйцэтгэлээ. Энэхүү суурь судалгаа нь санхүүгийн тогтвортой байдлыг хангах чиг үүрэг бүхий институцид өөрийн орны онцлогт тохирсон эрх зүйн оновчтой зохицуулалтыг бий болгоход чухал алхам болов.

6. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотой хууль тогтоомжийг Олон улсын байгууллага /ФАТФ/-аас тогтоосон стандарт, зөвлөмжтэй нийцүүлэх, Монгол Улсын үнэлгээг дээшлүүлэх арга хэмжээг хамтран зохион байгуулах, холбогдох журмыг батлах, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах (Засгийн газар, Монголбанк)

Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага (ФАТФ)-аас Монгол улсад хэрэгжүүлсэн хяналтын хүрээнд УИХ-аар Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулга, Терроризмтэй тэмцэх тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт (2013.5.31), Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэмэлт өөрчлөлт (2014.1.16)-үүдийг, Засгийн газрын хурлаар Террористуудын жагсаалтыг гаргах, тэдгээрийн хөрөнгийг битүүмжлэх, хянах журам (2013.10.12)-ыг тус тус баталсан.


2014 оны 5 дугаар сарын 12-16-нд дээрх хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцах зорилгоор ФАТФ-ын хяналтын бүлгийн гишүүд Монголд хүрэлцэн ирж холбогдох байгууллагуудтай уулзалт хийсэн. Дээрх уулзалтад холбогдох яам, агентлагуудын эрх бүхий албан тушаалтнууд оролцож хяналтын бүлгийн төлөөлөгчдөд зориулж мэдээлэл хийж, биечлэн танилцуулга хийсэн. Дээрх уулзалтын үр дүнд 2014 оны 6 дугаар сарын 24-27-ны өдрүүдэд Францын Парис хотноо зохиогдсон ФАТФ-ын чуулга уулзалтын үеэр ФАТФ-ын хяналтын хүрээнд манай улс ФАТФ-аас зөвлөсөн ажлуудыг бүрэн гүйцэд хийсэнд тооцогдож, ФАТФ олон нийтэд хандаж гаргадаг өөрийн хар, саарал жагсаалтаас Монгол Улсыг бүрмөсөн гаргалаа. Эдгээр хууль тогтоомжийг боловсруулахад Монголбанк, Санхүүгийн мэдээллийн алба голлож оролцсон бөгөөд эрх зүйн бичиг баримтууд батлагдсанаар Монгол Улсаас ФАТФ-тай хийхээр тохирсон ажлууд бүрэн хийгдсэнд тооцогдсон болно.

IV. ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2014 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ (2014 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар)

1. МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:


1.1. Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг 2014 оны эцэст 8 хувь, 2015-2016 онд 7 хувиас хэтрүүлэхгүй түвшинд байлгана. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу инфляцийг хязгаарлах, мөнгө, төсвийн бодлогын харилцан уялдааг хангах чиглэлээр Засгийн газартай хамтран ажиллана. Эдгээрийн үр дүнд дунд болон урт хугацаанд макро эдийн засаг тогтвортой байх нөхцөлийг бүрдүүлнэ.

Зураг 67. УБ хотын сарын ба жилийн инфляци



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Зураг 68. Улаанбаатар хотын жилийн инфляци (бүтцээр)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2014 оны 8-р сарын байдлаар жилийн инфляци улсын хэмжээнд 13.7%, Улаанбаатар хотын хэмжээнд 13.6% байлаа. Харин өндөр хэлбэлзэлтэй бараа, бүтээгдэхүүнийг хасч тооцсон суурь инфляци 15.6% байжээ. Энэ оны 8-р сард хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнэ өмнөх сартай харьцуулахад улсын хэмжээнд 0.4%-аар, Улаанбаатар хотын хэмжээнд 0.7%-иар нэмэгдсэн байна. 2014 оны 8-р сарын Улаанбаатар хотын жилийн инфляци (13.6%)-ийг бүтцээр нь задлан үзвэл мах, махан бүтээгдэхүүн 0.29, махнаас бусад хүнсний бүтээгдэхүүн 3.29, төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээ 1.38, шатахуун 0.07, бусад бараа, үйлчилгээ 8.53 нэгж хувийг тус тус бүрдүүлж байна. Бараа, үйлчилгээний үнийн өсөлтийн инфляцид эзлэх хувийг өмнөх 7-р сартай харьцуулахад мах, махан бүтээгдэхүүн, махнаас бусад хүнсний бүтээгдэхүүн, төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээ, бусад бараа, бүтээгдэхүүний жилийн инфляцид үзүүлэх хувь хэмжээ харгалзан 0.24, 0.85, 0.39, 0.44 нэгж хувиар өсчээ.

Монголбанкнаас мөнгөний бодлогын уламжлалт бус арга хэрэгслээр инфляцийг нам, тогтвортой түвшинд байлгаж, Засгийн газартай хамтран нийлүүлэлтийн гаралтай инфляцийн нөлөөллийг бууруулах бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байгаа бөгөөд тэдгээрийг зах зээлийн механизмд суурилсан байнгын тогтолцоо руу шилжүүлэх зарчмыг баримтлан ажиллаж байна. “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөр”-ийн хүрээнд зорилтот бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлтийг эрс сааруулж чадсан ч, төлбөрийн тэнцлийн хүндрэлээс үүдэлтэйгээр

бусад бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс шалтгаалж ерөнхий инфляци сүүлийн 12 сарын хугацаанд өссөөр байна. Тухайлбал, хүнсний бараа, бүтээгдэхүүний инфляци 2012 онд 19.9% байсан бол 2013 онд 14.0%, 2014 оны 8-р сард 11.4% болж буурсан бол махны үнийн өсөлт 2012 онд 43.7% байсан бол 2013 онд 10.5%, 2014 оны 8-р сард -2.3% болж буураад байна. Харин 2012 оны төгсгөлд 13.7%, 2013 оны төгсгөлд 11.7% байсан бусад бараа бүтээгдэхүүний үнийн жилийн өсөлт 2014 оны 8-р сард 15.9% болж өсчээ. Энэ нь төлбөрийн тэнцлийн “хямрал”-т нөхцөл байдлаас шалтгаалсан импортын барааны үнийн өсөлтөөр голлон тайлбарлагдаж байна.

Зураг 69. Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах хөтөлбөрт хамрагдсан барааны инфляци болон бусад барааны инфляци (2008-2014 оны 8-р сар)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк

2014 оны 8-р сарын байдлаар Улаанбаатар хотын инфляци 13.6% гарсан нь инфляцийн зорилтот түвшнээс 5.6 нэгж хувиар өндөр байна. Энэ нь төлбөрийн тэнцлийн “хямрал”-аас шалтгаалсан импортын барааны үнийн өсөлт болон төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээний үнийн өсөлтөөс шалтгаалав. Тухайлбал, төрийн өмчийн их, дээд сургуулийн сургалтын төлбөр 7.6%-иар өссөн нь 0.3 нэгж хувийн, орон сууцны усан хангамжийн үнэ 23.0%-иар өссөн нь 0.4 нэгж хувийн, цахилгааны үнэ дунджаар 5.8%-иар өссөн нь 0.1 нэгж хувийн, авто замын зорчигч тээврийн үйлчилгээний үнэ дунджаар 17.7%-иар өссөн нь 0.5 нэгж хувийн буюу нийтдээ 1.4 нэгж хувийн инфляцийг бий болгожээ. Төлбөрийн тэнцлийн 2013 оны “хямрал”-т нөхцөл байдал 2014 онд мөн үргэлжилж байна. Үүний тусгал нь төгрөгийн гадаад валюттай харьцах ханш суларч буй хандлага юм. 2014 оны 9-р сарын 9-ний өдрийн байдлаар төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2013 оны 7-р сарын эхэн үетэй харьцуулахад 27%-аар суларчээ. Үүнтэй уялдан үнэ тогтворжуулах хөтөлбөрт хамрагдсан бараа, төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээний инфляцийг хасч тооцсон “Бусад” ангиллын бараа, үйлчилгээний үнийн өсөлтийн инфляцид эзлэх хувь өсч, жилийн өмнөх үеэс 6.0 нэгж хувиар өсөөд байна.

Өөрөөр хэлбэл хэрэглээний үнийн индексийн өсөлтөд нийлүүлэлтийн гаралтай буюу зардлын шалтгаантай инфляци эрс буурсан байгаа бол валютын ханшийн өсөлтөөс шалтгаалсан инфляци өссөн байна. Гэхдээ гадаад валютын орох урсгал, төлбөрийн нийт тэнцэл эрс сайжирснаар валютын ханш тогтворжиход түүний инфляци дахь нөлөөлөл нь буурах болно.

Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөл 2014 оны 2-р сарын 7-11-ний өдрүүдэд хуралдаж, Бодлогын хүүг 10.5%-д хэвээр үлдээх, олон улсын зах зээл дээрээс 3 болон түүнээс дээш жилийн хугацаатай бонд болон зээл хэлбэрээр банкны татсан гадаад валютын эх үүсвэрийг заавал байлгах нөөцийн шаардлагаас чөлөөлөх шийдвэрийг гаргасан. Бодлогын энэхүү арга хэмжээ нь нэг талаас эдийн засгийн бодит секторын идэвхжлийг дэмжих, нөгөө талаас гадаадын шууд хөрөнгө оруулалт, гадаад цэвэр актив огцом буурсан, төлбөрийн тэнцлийн дарамт өндөр байгаа орчинд гадаад валютын урт хугацаатай эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилготой байв. Суурь инфляцийн түвшин сүүлийн 11 сарын турш эрчимжиж, гадаадын шууд хөрөнгө оруулалт, гадаад цэвэр актив буурах хандлага үргэлжилж, төсөвтэй адилтгах хөрөнгө оруулалтын зарцуулалтууд буурахгүй байсан тул Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөл 2014 оны 7-р сарын 30-ны өдрийн ээлжит хуралдаанаар мөнгөний бодлогын хүүг 1.5 нэгж хувиар нэмэгдүүлэн, 12.0 хувь болгох шийдвэр гаргав. Энэхүү арга хэмжээ нь төлбөрийн тэнцлийн хүндрэлийг зөөлрүүлэх, инфляцийг эрчимжүүлэхгүй байлгах, дунд болон урт хугацаанд санхүүгийн тогтвортой байдлыг хангах, макро эдийн засгийн тогтвортой байдалд учирч болзошгүй эрсдэлээс сэргийлэх зорилготой юм.

Монголбанк Засгийн газартай хамтран ажиллах хүрээнд Засгийн газрын үнэт цаасыг анхдагч болон хоёрдогч зах зээлд арилжаалах нөхцөлийг бүрдүүлж, арилжааг тогтмол зохион байгуулав. Ингэснээр урт хугацааны зорилтот төсөл, хөтөлбөрийг эрсдэлийн боломжит түвшинд, хамгийн бага зардалтайгаар санхүүжүүлэх, Засгийн газрын үнэт цаасны зах зээл, улмаар хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, Засгийн газрын үнэт цаасны буюу төгрөгийн өгөөжийн муруйг бий болгох, төсөв, мөнгөний бодлогын харилцан уялдааг хангах зэрэг ач холбогдолтой юм. Түүнчлэн, гадаад валютын орох урсгал, төлбөрийн тэнцлийг сайжруулах, дотоодын аж ахуйн нэгжид учирч байгаа эрсдэл, ачааллыг бууруулах, санхүү, эдийн засгийн эрсдэлээс сэргийлэхэд чиглэсэн УИХ-ын тогтоол, шийдвэр гаргуулахаар Засгийн газартай хамтран ажиллаж, тодорхой чиглэлүүдээр санал боловсруулж хүргүүлэн, Ажлын хэсэгт орж ажиллалаа.

Мөнгөний болон төсвийн бодлогын харилцан уялдааг сайжруулах, санхүүгийн зах зээлийн хөгжлийг дэмжих зорилгоор Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2008 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 129/133 дугаар хамтарсан тушаалаар “Сангийн яам, Монголбанкны хооронд мэдээлэл солилцох журам”-ыг баталсан. Уг журамд Сангийн яам төсвийн гол үзүүлэлтүүдийн төсөөлөл болон Төрийн сангийн нэгдсэн данс (ТСНД)-ны орлого, зарлагын гүйлгээний таамаглал, бодит гүйцэтгэлийг 7 хоног, сар, улирлын давтамжтайгаар Монголбанкинд хүргүүлж байхаар заасан. Гэвч Сангийн яамнаас ирүүлж буй мэдээллийн чанар хангалттай бус, давтамж цөөн байснаас мэдээллийг мөнгөний бодлогын төсөөлөл, бодлогын шинжилгээнд ашиглахад хүндрэлтэй байв. Тухайлбал, ТСНД-ны мөнгөн хөрөнгийн урсгалын ажлын 5 хоногийн таамаглалыг 7 хоног бүр ирүүлээгүй, зарлагын бодит гүйцэтгэлийг 2014 оны эхний 3 сард огт ирүүлээгүй, түүнчлэн дээрх мэдээллийг валютын төрлөөр, томоохон бүлгээр ангилан авах тухай журмын заалтыг Сангийн яам мөрдөн ажиллахгүй байна. Иймд, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 2014 оны 3-р сарын 28-ны өдрийн хуралдаанаар Сангийн яам болон Монголбанкны хооронд байгуулсан мэдээлэл солилцох журмын хэрэгжилтийг Монгол Улсын Хөгжлийн банк (МУХБ)-ийг хамруулан сайжруулах, Эдийн засгийн хөгжлийн яам, МУХБ нь холбогдох мэдээллийг Сангийн яаманд хүргүүлж, нэгдсэн мэдээллийг Сангийн яамнаас Монголбанкинд хүргүүлж байхаар шийдвэрлэв. Энэ нь мөнгөний бодлогын шийдвэрт улсын төсөв,

МУХБ-ны мэдээллийг цаг алдалгүй авч ашиглах, мэдээллийн хоцрогдол, тодорхой бус байдлыг бууруулах боломжийг олгохоор байна.

1.2. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцэж, уян хатан тогтох, төгрөгийн тогтвортой байдал болон үндэсний эдийн засгийн тэнцвэртэй хөгжлийг дэмжих зарчим баримтална.


Монголбанк төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцтэйгээр уян хатан тогтож байх зарчмыг үргэлжлүүлэн баримталж байгаа бөгөөд валютын ханшийн огцом хэлбэлзлийг бууруулах зорилгоор валютын захад шаардлагатай тохиолдолд тухай бүр оролцож байна.

Эдийн засгийн нөхцөл байдлыг тоймлон үзвэл оны эхний 8 сард гадаад зах зээлийн нөхцөл байдлын өөрчлөлт, дэлхийн зах зээлд түүхий эдийн үнэ сэргэх хандлага ажиглагдахгүй байгаа, БНХАУ-ын эдийн засгийн өсөлт саарсан, гадаадын шууд хөрөнгө оруулалт сэргээгүй зэргээс шалтгаалан Монгол Улсын төлбөрийн тэнцлийн дарамт арилахгүй хэвээр байна. Алт, боловсруулаагүй нефть, зэсийн баяжмал зэрэг бүтээгдэхүүний экспорт 2014 он гарсаар нэмэгдсэн хэдий ч, чулуун нүүрсний экспортын орлого тодорхой хугацааны дараа орж ирэхээр байгаагаас шалтгаалан валютын зах дээр богино хугацааны эрэлт, нийлүүлэлтийн зөрүү үүсэх эрсдэлтэй байлаа. Түүнчлэн, 2014 он гарсаар жижиг, дунд хэмжээний төслүүдэд оруулж буй гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэж байгаа хэдий ч, Оюутолгой төслийн эхний шатны хөрөнгө оруулалт дууссантай холбоотойгоор оны эхний 7 сарын байдлаар Монгол Улсад оруулсан нийт гадаадын шууд хөрөнгө оруулалт өнгөрсөн оны мөн үеэс 60.5%-иар буураад байна.

Эдийн засагт үүсээд буй энэхүү нөхцөл байдлаас шалтгаалан төгрөгийн ам.доллартай харьцах ханш оны эхнээс 9.1%-иар сулраад байна. Ийм орчинд Монголбанк валютын захад тогтмол оролцож, спот болон своп хэлцлийн арилжаагаар захад валют нийлүүлэх замаар валютын захын эрэлт нийлүүлэлтийн хэт зөрүү, ханшийн огцом хэлбэлзлийг бууруулан ажиллаж байна.

Төгрөгийн ханш ийнхүү эдийн засгийн нөхцөл байдалтай нийцтэйгээр уян хатан тогтож байгаа нь богино хугацаанд тодорхой зардлыг дагуулж, хувийн хэвшилд ханшийн эрсдэлийг нэмэгдүүлж байгаа хэдий ч, төгрөгийн тогтвортой байдал буюу үнийн тогтвортой байдал (инфляци нам, тогтвортой түвшинд байх)-ыг хангах Монголбанкны үндсэн зорилттой нийцтэй бөгөөд дунд болон урт хугацаанд экспортыг урамшуулах, импортыг орлох дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, үр ашиггүй, тэвчиж болох импортын хэрэглээг бууруулах, гадаад худалдааны алдагдал болон төлбөрийн тэнцлийн дарамтыг багасгах, эдийн засгийн өрсөлдөх чадвар болон урт хугацааны дархлааг сайжруулах боломжийг бүрдүүлж байна. Тухайлбал 2014 оны эхний 8 сарын байдлаар валютын төлбөртэй гадаад худалдааны алдагдал 115%-иар буурч, валютын төлбөртэй гадаад худалдааны тэнцэл 183.5 сая ам.долларын ашигтай гарчээ. Энэ нь валютын төлбөртэй импортын дүн 15%-иар буурч, экспортын дүн 30%-иар өссөнөөс шалтгаалжээ.

Зураг 70. Төгрөгийн ам.доллартай харьцах ханш ба урсгал данс



Эх сурвалж: Монголбанк

1.3. Гадаад валютын ханшийн эрсдэлийг бууруулах тогтолцоог бүрдүүлнэ.

Төгрөгийн орлоготой зээлдэгчдийг валютын ханшийн эрсдэлээс хамгаалах нөхцөлийг бүрдүүлнэ: Монголбанкнаас валютын зээлийн эрсдэлийг бууруулах макро зохистой арга хэрэгслийн судалгааг гүйцэтгэсний үндсэн дээр Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн А-122 дугаар тушаалаар “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулан ханшийн эрсдэлээс хамгаалагдаагүй этгээдийн гадаад валютын зээлийн эрсдэлийн жинг нэмэгдүүлж, 2015 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдүүлэхээр боллоо.

Мөн тус тушаалын хавсралтаар валютын зээл хүссэн иргэд, аж ахуйн нэгжүүдэд ханшийн эрсдэлийг санхүүгийн үүсмэл хэрэгсэл ашиглан хаах зөвлөмж хүргүүлснээс гадна валютын зээл хүссэн иргэд, аж ахуй нэгжүүдэд зориулан валютын зээлийн эрсдэлийн талаар ойлголт олгох гарын авлагыг боловсруулан олон нийтэд банкуудаар дамжуулан хүргүүлжээ. Ханшийн эрсдэлээс хамгаалагдаагүй харилцагчид нь ханшийн хэлбэлзлээс шалтгаалан алдагдалд орох эрсдэлтэй төдийгүй чанаргүй зээлийн хэмжээг нэмэгдүүлэх, нийт санхүүгийн тогтвортой байдлыг алдагдуулах эрсдэлтэй. Иймд ханшийн эрсдэлийг бууруулахад санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийг өргөнөөр ашиглах шаардлага зайлшгүй тулгарч байна.

Банкуудтай ханшийн эрсдэлээс хамгаалах урт хугацаат своп хэлцэл байгуулж байна: Гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлэх, валютын зээлийн өсөлтийг бууруулах, ханшийн эрсдэлээс хамгаалах тогтолцоог бий болгох зорилтын хүрээнд “Урт хугацаат своп хэлцэл”-ийг шинээр нэвтрүүлээд байна. Энэхүү хэрэгслийг нэвтрүүлснээр урт хугацаат гадаад эх үүсвэрийн ханшийн эрсдэлээс банкууд Монголбанктай своп хэлцэл байгуулах замаар эрсдэлийг бууруулах, харилцагчиддаа валютаар бус төгрөгөөр зээл олгох боломжтой болсон нь системийн хэмжээнд ханшийн эрсдэлийг бууруулах ач холбогдолтой юм. Монголбанк 2014 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар нийт 176 сая ам.долларын урт хугацаат своп хэлцлийг банкуудтай байгуулаад байна.

Валютын дуудлага худалдаагаар санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийг идэвхтэй ашиглаж байна: Монголбанкнаас санхүүгийн үүсмэл хэрэгслийн хэрэглээг дэмжих зорилгоор банкуудтай своп хэлцлийг тогтмол хийж байна. Монголбанк 2014 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар банкуудтай оны эхнээс өссөн дүнгээр нийт 2.99 тэрбум ам.доллартай тэнцэх хэмжээний төгрөгийн своп, 728 сая ам.доллартай тэнцэх хэмжээний ам.долларын своп, 135 сая юанийн своп хэлцлийг байгуулаад байна.

Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах SIFS дэд хөтөлбөрийн хүрээнд форвард хэлцэл байгуулж байна: Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах дэд хөтөлбөрийн хүрээнд ханшийн эрсдэлээс хамгаалах зорилгоор форвард хэлцлийг байгуулж байна. 2014 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар 607.4 сая ам.долларын форвард хэлцлийн төлбөр тооцоог хийсэн бөгөөд 144.3 сая ам.долларын форвард хэлцэл идэвхитэй байна. Энэ нь валютын ханшийн өөрчлөлтөөс шалтгаалсан эрсдэлийг бууруулж, дотоодын зах зээлд шатахууны жижиглэнгийн худалдааны үнэ тогтвортой байхад эерэгээр нөлөөлөв.

2. БАНКНЫ САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД:

2.1. Банкуудын төлбөрийн чадварыг хадгалж, системийн шинжтэй эрсдэлээс хамгаалах чадавхийг нэмэгдүүлнэ.

Монголбанкнаас 2014 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 9 банкинд иж бүрэн, 1 банкинд газар дээрх хэсэгчилсэн шалгалтыг Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, Банкны тухай хууль болон бусад хууль тогтоомж, Монголбанкнаас баталсан журам, заавруудын хүрээнд хийж, илэрсэн зөрчилд Улсын байцаагчийн акт тогтоох, шийтгэвэр ногдуулах зэрэг арга хэмжээг авч ажиллав. Шалгалтын мөрөөр гарсан Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалын биелэлтэд тогтмол хяналт тавьж байна.

Мөн Банкны тухай хууль, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн 460 дугаар тушаалаар батлагдсан “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”, Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2010 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 475/182 дугаар тушаалаар батлагдсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам” болон холбогдох бусад хууль, тогтоомжуудын хүрээнд банкуудын үйл ажиллагаанд зайнаас тогтмол хяналт тавин ажиллаж байна.

2014 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар банкны салбарын I зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 12.1%, өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 16.8% байгаа нь Монголбанкнаас тогтоосон шалгуур үзүүлэлтүүдээс харгалзан 3.1 ба 4.8 нэгж хувиар тус тус өндөр байна. Үүнээс гадна банкны системийн төлбөртүргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа Монголбанкнаас тогтоосон шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж байна. 2014 оны 8 дугаар сарын эцэст тус харьцаа 36.5 %-д хүрсэн нь Монголбанкнаас тогтоосон шалгуур үзүүлэлтээс 11.5 нэгж хувиар өндөр байв. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа ийнхүү өндөр байхад банкуудын хөрвөх чадвар сайтай, богино хугацаат хөрөнгө оруулалтын тогтвортой өсөлт эерэгээр нөлөөлсөн.

Банк нь гадаад валютын нээлттэй позици, өөрийн хөрөнгийн харьцааг нэг валютын хувьд +/-15 хувийн дотор, нийт нээлттэй позицийн хувьд +/-40 хувийн дотор барьж байх шаардлагатай. 2014 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар банкны салбарын гадаад валютын зохистой харьцааны үзүүлэлт хамгийн өндөр нэгж валютын хувьд -3.1 хувь, нийт валютын хувьд -3.8 хувьтай байгаа нь Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны үзүүлэлтийг хангаж байна.

Банкууд Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны үзүүлэлтийг цаашид хэрхэн хангах, банкны үйл ажиллагаанаас болон нийт банкны систем, эдийн засгийн нөхцөл байдлаас үүсч болзошгүй эрсдэлийг урьдчилан таамаглах зорилгоор Монголбанкнаас

банкуудаар мэдрэмтгий байдлын шинжилгээг хийлгэж хэвшүүлэхээр ажиллаж байгаа билээ. Энэ хүрээнд банкны системийн эрсдэл даах чадварыг тодорхойлох үүднээс 2014 оны 1 дүгээр улиралд зээлийн эрсдэл, том зээлдэгч, ханшийн эрсдэл, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар гэсэн 4 чиглэлд мэдрэмтгий байдлын шинжилгээг хийж, гарсан үр дүнг цаашид баримтлах бодлогод тусган ажиллаж байна. Түүнчлэн зээлийн эрсдэлийн, гадаад валютын ханшийн, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын мэдрэмтгий байдлын шинжилгээний загварыг олон улсын зөвлөхтэй хамтран боловсруулж, системийн бүх банкуудаар гүйцэтгүүлж, үр дүнг танилцуулсан бөгөөд цаашид шинжилгээний загварыг улам боловсронгуй болгохоор банкуудтай хамтран ажиллаж байна.

Монголбанкны хяналт шалгалтын үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн актыг боловсронгуй болгох зорилгоор тэдгээрийн хоорондын уялдаа, хэрэгжилтэд учирсан хүндрэлийг тодорхойлж, шаардлагатай тохиолдолд өөрчилж шинэчлэх ажлын хүрээнд Монголын банкны холбоо, банкууд болон бусад холбогдох байгууллагаас ирүүлж буй банкны үйл ажиллагаатай холбоотой хууль, журмын саналыг нэгтгэн судалж байна. Мөн “Банкны зөвшөөрлийн журам” болон “Банкны нэгжийн журам”-д оруулах нэмэлт, өөрчлөлтийг боловсруулсан бөгөөд шинэчлэн батлуулахаар ажиллаж байна. Банкыг төрөлжүүлэн хөгжүүлэх зорилгоор үйл ажиллагаа явуулах хэлбэрээр нь ангилж, “Төрөлжсөн үйл ажиллагаатай банкны журам”-ын төслийг боловсруулан, “Банкны зөвшөөрлийн журам”-д холбогдох эрх зүйн зохицуулалтыг тусгахаар ажиллаж байна.

Монголын банкны салбарт үүсч болзошгүй эрсдэлүүд, ялангуяа ханшийн болон зээлийн эрсдэлээс сэргийлэх, нөлөөллийг бууруулах макро зохистой бодлогын боломжит хэрэгслүүдийн талаарх судалгааг хийсэн бөгөөд судалгаанаас гарсан үр дүнд үндэслэн “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-д активын эрсдэлийн жин болон өөрийн хөрөнгийн хүрэлцээтэй холбоотой нэмэлт өөрчлөлт оруулах саналыг боловсруулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн А-122 дугаар тушаалаар баталж, 2015 оноос эхлэн мөрдүүлэхээр тогтоосон. Түүнчлэн Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан 2014 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн А-136/184 дүгээр тушаалаар “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулах, зарцуулах журам”-д нэмэлт өөрчлөлт оруулж, хэвийн зээлд 1 хувийн эрсдэлийн сан байгуулах зохицуулалтыг бий болголоо.

2.2. Олон улсад мөрддөг зарчим, зохицуулалтын арга хэрэгслийг банкны салбарын үйл ажиллагаатай уялдуулан, эрсдэлийн үнэлгээнд суурилсан хяналт шалгалтыг сайжруулна.

Олон улсын жишгээр хяналт шалгалтын аргачлалыг гүйцэтгэлд суурилсан аргачлалаас эрсдэлийн үнэлгээнд суурилсан хяналт шалгалтын аргачлалд шилжих хандлагатай байгаа тул банкуудын ирээдүйд хүлээж болзошгүй эрсдэлийг урьтаж илрүүлэх, оновчтой тооцоолох, хяналт шалгалтын нөөц, чадавхийг эрсдэл өндөртэй байгаа үйл ажиллагааны чиглэлд түлхүү хуваарилах, улмаар системийн эрсдэл үүсэх сөрөг үр дагаврын далайцыг бууруулах зохицуулалтын дэвшилтэт аргачлалыг нэвтрүүлэхэд Монголбанкны зүгээс онцгой анхааран ажиллаж байна. Тус ажлын хүрээнд шинэ аргачлалыг хэрэгжүүлэхэд шаардлагатай журам, гарын авлага боловсруулахаар тус асуудлаар мэргэшсэн олон улсын зөвлөхтэй хамтран ажиллаж, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын журмын төслийг боловсруулж байна. Түүнчлэн одоо ашиглаж буй “Хянан шалгагчийн гарын авлага”-ыг эрсдэлийн үнэлгээнд суурилсан хяналт шалгалтын зарчимтай нийцүүлэх судалгааны ажил хийж байна.

“Банкны хяналт шалгалтын дунд хугацаанд хэрэгжүүлэх стратеги”-ийн төслийг боловсруулж, ойрын 5 жилд банкны хяналт шалгалтын хүрээнд хийгдэх онцлох арга хэмжээнүүдийг шат дараатайгаар авч хэрэгжүүлэхээр дунд хугацааны төлөвлөгөөнд тусгасантай холбогдуулан Базелийн цуврал стандартуудыг хэрэгжүүлэх ажлыг судалж байна. Энэхүү цуврал стандартыг нэвтрүүлснээр нийт банкны салбарын эрсдэл даах чадварыг сайжруулж, хяналт шалгалтын олон улсад мөрдөгдөх стандартад нийцсэн хяналт, зохицуулалтын аргачлалыг ашиглах боломж бүрдэнэ. Түүнчлэн банкуудад мөрдөгдөж буй Нягтлан бодох бүртгэлийн багц материалыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн шинэчлэн боловсруулж дууссан бөгөөд 2014 онд багтаан шинээр нэвтрүүлэхээр төлөвлөж байна.

Банкны үйл ажиллагаанд сайн засаглалын зарчмуудыг нэвтрүүлэх, нийт хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, хараат бус төлөөлөн удирдах зөвлөлийг төлөвшүүлэх зорилгоор “Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”-ыг Компанийн засаглалын хөгжлийн төв болон Азийн хөгжлийн банктай хамтран олон улсын стандартын үндсэн зарчмууд, “Монголын Компанийн засаглалын VII чуулган”-ы үеэр зохион байгуулагдсан “Банкны зохистой засаглалын зарчим” хэлэлцүүлэгт оролцогчдоос гаргасан санал, зөвлөмжид нийцүүлэн боловсруулсан бөгөөд Монголбанкны хяналтын зөвлөл, захирлуудын зөвлөлийн хурлаар тус тус хэлэлцсэн. Энэхүү журмыг энэ оны 9 дүгээр сард эцэслэн батална. Мөн банкны зохистой засаглалыг сайжруулах, хэрэгжилтийг үнэлэх талаар холбогдох байгууллагуудтай хамтран хэд хэдэн сургалт зохион байгуулж, журмын төслийн талаар танилцуулга хийсэн болно.

2.3. Банкны эрсдэл, зээлийн хүү буурах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор банкны зээлийн барьцаа хөрөнгийн болон зээл, хүүгийн зардлыг нэмэгдүүлж байгаа бусад хүчин зүйлийн нөлөөллийг бууруулах эрх зүйн орчныг шинэчилнэ.

Банкны салбараас алслагдсан, санхүүгийн мэдээлэл багатай, ялангуяа хөдөө, орон нутгийн иргэд, хуулийн этгээдэд үзүүлэх санхүүгийн үйлчилгээг үр ашигтай болгох, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журам”-ыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2013 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А-236 тоот тушаалаар баталсан. Энэхүү журмын дагуу банкуудын хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлыг хангаж, олон нийтэд шаардлагатай мэдээллийг тогтмол түгээж байна.

Уг журмын хэрэгжилт нь нийтэд ижил, тэгш үйлчилж байгаа эсэхийг тодорхойлох, банкны зээлийн үйл ажиллагаанд шударга бус хэлцэл үүсэх боломжийг хязгаарлах ажлуудыг шалгах, хөдөө, орон нутагт олгогдож байгаа зээлийн нөхцөлийг газар дээр нь шалгаж, үнэлгээ, дүгнэлт өгөх зорилгоор орон нутгийн банкуудад хэсэгчилсэн шалгалтыг 2014 оны 5, 6-р саруудад хийсэн. Мөн орон нутаг дахь санхүүгийн хүртээмж ямар түвшинд байгааг судлах зорилгоор 13 аймаг дахь иргэд, аж ахуйн нэгжүүдээс түүвэрлэлт хийн, санхүүгийн хүртээмжийн судалгааг авав. Шалгалт болон түүвэр судалгааны үр дүнг нэгтгэн, үнэлгээ дүгнэлт гаргах ажил хийгдэж байна.

Банкуудын үйл ажиллагааны зардалд дүн шинжилгээ хийх, хэрэв төр, захиргааны байгууллагаас шалтгаалж банкны үйл ажиллагааны зардал нэмэгдэж байгаа бол тэр чиглэлд холбогдох арга хэмжээг авах, банкуудад зөвлөмж өгөх чиглэлээр Монголбанк ажиллаж байна. Түүнчлэн, банкуудын үйл ажиллагааны зардлыг нэмэгдүүлж байгаа хүчин зүйлсийн талаар Монголын банкны холбооноос санал авах, банкнаас өөрөөс нь

шалтгаалж бий болдог зардал болон иргэд, харилцагчид дээр ирдэг зардлын бүтцэд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр шийдвэрлэх арга хэмжээ авахаар ажиллаж байгаа болно.

Монголбанк Хөдлөх хөрөнгө, эрхийн барьцааны тухай хууль, Үл хөдлөх хөрөнгийн барьцааны тухай хууль, Эрхийн улсын бүртгэлийн багц хуулийн төсөлд УИХ, Хууль Зүйн Яамтай хамтран ажилласан. Энэ хүрээнд Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн төслийг боловсруулан, Монголын банкны холбоо, банкууд болон холбогдох бусад байгууллагад хүргүүлж саналыг нэгтгэсэн. Мөн эдгээр хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулсантай холбоотойгоор уг төслийн үзэл баримтлалын төслийг 2014 оны 6 дугаар сард Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдсэн бөгөөд Засгийн газраас уг хуулийн төслийг УИХ-д өргөн бариад байна.

3. САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ДЭД БҮТЭЦ, ТҮҮНИЙ ИНСТИТУЦИЙГ БЭХЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД:

3.1. Монгол Улсын төлбөр тооцооны системийн найдвартай, тасралтгүй ажиллагааг ханган, төлбөр тооцооны системийн шинэчлэлийг 2014-2016 онд эрчимжүүлнэ.

• Төлбөр тооцооны системийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хангах:

Монголбанк их дүнтэй төлбөр тооцооны “Банксүлжээ” систем, бага дүнтэй төлбөрийн систем болон үнэт цаасны төлбөр тооцооны найдвартай, тасралтгүй ажиллагааг ханган ажиллаж байна. “Банксүлжээ” систем нь 2014 оны эхнээс 8 дугаар сарын 31-ний хугацаанд нийт 37.8 их наяд төгрөгийн дүнтэй 790.9 мянган ширхэг их дүнтэй гүйлгээг, Үндэсний цахим гүйлгээний төв (ҮЦГТ) нь нийт 1 их наяд төгрөгийн дүнтэй 19.4 сая ширхэг картын гүйлгээ, 488 тэрбум төгрөгийн дүнтэй 3.9 сая ширхэг бага дүнтэй гүйлгээг тус тус амжилттай дамжуулсан байна. Мөн хугацаанд банк хоорондын их, бага дүнтэй төлбөр тооцооны систем болон картын сүлжээний үйл ажиллагаа тасралтгүй, хэвийн явагдсан.

Банк хоорондын бага дүнтэй гүйлгээг 24/7 хуваариар онлайн горимд дамжуулах ажлын хүрээнд 12 оролцогчийн үйл ажиллагаанд газар дээрх хяналт шалгалтыг хийлээ. Шалгалтаар нийт оролцогчид “Банк хоорондын бага дүнтэй төлбөр тооцооны журам”-ын 4.1.3, 4.1.4, “Банк хоорондын бага дүнтэй гүйлгээний төлбөр тооцоог гүйцэтгэх ажлын гэрээ”-ний 1.2 дахь заалтыг мөрдөж ажиллаагүй, төлбөр тооцоог гар ажиллагаатай хийсэн, шалгалт хийсэн 1 өдрийн саатлын дансанд 354.7 сая төгрөгийн 2688 гүйлгээг саатуулсан болохыг шалгаж тогтоов. Мөн дээрх шалгалтын явцад зөвхөн ажлын өдөр 9-17 цагийн хооронд бага дүнтэй гүйлгээг илгээж, хүлээн авдаг гэх буруу ойлголт бүх шатанд байсан, үүний улмаас бага дүнтэй гүйлгээний талаар буруу мэдээлэл гарч байсныг илрүүллээ.

Монголбанкны удирдлагын түвшинд энэхүү шалгалтын тайланг хэлэлцэж, шалгалтын үр дүнд илэрсэн зөрчлийг арилгуулах тухай Улсын байцаагчийн мэдэгдлийг албан бичгийн хамт бүх оролцогчдод хүргүүлсэн бөгөөд 2014 оны 5 дугаар сарын 23-ны өдрөөс бүх банкууд 24/7 онлайн горимд шилжин ажиллаж байна. **Банк хоорондын гүйлгээ 24/7 онлайн горимд шилжсэнээр шилжүүлэг, банк хоорондын интернет, мобайл зэрэг гүйлгээнүүд онлайнгаар хийгдэж байна.**

Олон улсын төлбөр тооцооны банкнаас гаргасан “Санхүүгийн зах зээлийн дэд бүтэц /СЗЗДБ/-д зарчмын дагуу үнэлгээ хийх аргачлал”-аас банкуудын төлбөрийн системд үнэлгээ хийхтэй холбоотой хэсгийг тусад нь боловсруулах, “СЗЗДБ-ийг үнэлэх үнэлгээний аргачлал болон ил тод байдлыг хангах нь” баримт бичгийн орчуулгыг сайжруулах, үүнтэй уялдан заавар боловсруулах ажлыг гүйцэтгэж, ТТҮЗ-ийн ээлжит XIII хуралдаанаар нийт төлбөрийн системийн оролцогч нарт танилцуулсан болно.

2014 оны эхнээс Капитал банк, Үндэсний хөрөнгө оруулалтын банк, Эрэл, Чингис хаан банкинд дотоодын Мастеркарт төлбөрийн картыг хүлээн авах, Төрийн банкинд картын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлүүдийг тус тус олгов. Улаанбаатар хотын банкны зөвшөөрлийн хугацаа дууссан тул зөвшөөрлийг сунгаж, нэмэлт зөвшөөрөл олгосон.

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 394 дүгээр тогтоолоор батлагдсан “Хонины ноос, тэмээний ноос бэлтгэж үндэсний үйлдвэрт тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам”-ын дагуу Монголбанк, банкууд, Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Мал хамгаалах сан хамтран ажилласан. Монголбанк орон нутгийн хэлтэс, салбаруудад энэхүү журмыг хүргүүлж, шаардлагатай мэдээллээр хангасны зэрэгцээ иргэд, зарим банкуудаас ирүүлсэн гомдлын мөрөөр шалгалт хийж, маргаантай асуудлыг шийдвэрлэв.

Монгол Улсын Засгийн газрын 2012.09.02-ны өдрийн 70 дугаар тогтоолоор батлагдсан “Хүний хөгжил сангаас хүүхдэд мөнгө олгох журам”-д заасны дагуу хүүхдийн мөнгө олгох ажил хийгдэж байна. 2014 оны 8 дугаар сарын байдлаар нийт 157.8 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдэж, давхардсан тоогоор 8 сая хүүхдэд хуваарилагдаад байна. Мөн дээрх хугацаанд 62.7 мянган малчны 16.5 тэрбум төгрөгийн ноосны урамшууллыг олгожээ.

Нийслэлийн замын хөдөлгөөний удирдлагын төв, Монгол шуудан ТӨХК, Эрэл банк хамтран зөрчил гаргасан жолоочид ногдуулах торгуулийг бэлэн бусаар төлөх свайп/ swipe/ үйлчилгээг нэвтрүүлэхэд төлбөр тооцоог холбогдох хууль, журамтай нийцүүлэх асуудлын хүрээнд Монголбанкнаас уулзалт зохион байгуулсан.

Төлбөрийн картын журмын дагуу, гэнэтийн саатал их байгааг анхааруулсан албан бичгийг холбогдох банкуудад нь хүргүүлж, үйл ажиллагаанд нь хяналт тавин ажилласан болно.

• **“Төлбөр тооцооны системийн шинэчлэл”-ийг 2014-2016 онд эрчимжүүлэх:**

Төлбөр тооцооны системийг шинэчлэх зорилгоор Монголбанкнаас 2014-2016 онд Азийн хөгжлийн банк (АХБ)-ны санхүүжилтээр хэрэгжүүлэх “Монгол Улсын төлбөрийн системийн шинэчлэл” төслийн бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Төслийн зээлийн гэрээнд ЭЗХЯ болон АХБ, төслийн гэрээнд Монголбанк болон АХБ тус тус 2014 оны 2 дугаар сард гарын үсэг зурсан. ЭЗХЯ-наас хариуцан Зээлийн гэрээнд бүх яамдаас санал авч, Засгийн газрын 2014.05.21-ний хуралдаанаар хэлэлцүүлж, улмаар уг төсөл дэмжигдсэн болно. Гэвч УИХ-ын нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын ЗГ, АХБ хооронд байгуулсан “Төлбөрийн системийн шинэчлэл төсөл”-ийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлахыг дэмжээгүй болно.

Дотоодын банкуудын **e-commerce** буюу картын интернет гүйлгээг ҮЦГТ-ийн сүлжээгээр дамжуулах туршилтыг банк хооронд амжилттай хийж, уг гүйлгээг

ҮЦГТ-ийн сүлжээгээр дамжуулан гүйцэтгэх техникийн боломжийг бүрдүүллээ. Банкуудтай шимтгэлийн нөхцөлүүдийг тохирох, холбогдох журам, гэрээнд өөрчлөлт оруулахаар ажиллаж байна.

2012 оны 12 дугаар сараас эхлэн төлбөрийн картын нэгдсэн сүлжээг ашиглан UPI/Union Pay International/, 2014 оны 1 дүгээр сараас JCB /Japanese Credit Bureau/-с гаргасан олон улсын картыг хүлээн авах боломжтой болсон. Ингэснээр эдгээр картыг ашигладаг гадаадын иргэн, жуулчид Монгол Улсад дотоодын картаар үйлчилдэг худалдааны байгууллага, АТМ төхөөрөмжийг ашиглан гүйлгээ хийх боломжоор хангагдсан болно.

• **Төлбөрийн системийн хууль, эрх зүйн орчныг сайжруулах:**

Монголбанк Монгол Улсын төлбөрийн системийн үйл ажиллагааг бэхжүүлэх зорилгоор техник туслалцаа авах албан хүсэлтийг Дэлхийн банкинд хүргүүлж шийдвэрлүүлсэн. Энэхүү техник туслалцаагаар Монгол Улсын төлбөрийн системийн найдвартай, үр ашигтай ажиллагааг дэмжих үүднээс хууль, эрх зүйн орчныг сайжруулах, төлбөрийн системийн тухай тусгайлсан хуультай болох, урт хугацаанд баримтлан ажиллах төлбөрийн системийн стратегийн баримт бичгийг боловсруулж хэрэгжүүлэх юм.

Төлбөрийн системтэй холбоотой эрх зүйн дараах баримт бичигт шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг оруулан, шинэчлэн батлуулж, системийн нийт оролцогчдод мөрдүүлэн ажиллаж байна. Үүнд:

- o Монголбанкнаас төлбөрийн системийн талаар баримтлах бодлого
- o Төлбөрийн системийн хяналтын бодлого
- o Банк хоорондын их дүнтэй гүйлгээний төлбөр тооцооны журам, гэрээ
- o Банк хоорондын бага дүнтэй гүйлгээний төлбөр тооцооны журам, гэрээ
- o Төлбөрийн картын журам, гэрээ
- o Хөдөлгөөнт банкны үйлчилгээ, цахим мөнгөний талаар баримтлах бодлого

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн А-104 дүгээр тушаалаар төлбөр тооцооны системийн шинэчлэлийн хүрээнд холбогдох хууль тогтоомжийг судалж сайжруулах, санал боловсруулах ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Картын нэгдсэн сүлжээний хамтран ажиллах гэрээний хугацаа дууссантай холбогдуулан гэрээ болон хавсралтуудад холбогдох өөрчлөлтийг оруулж, “Банк хоорондын картын төлбөр тооцоо гүйцэтгэх ажлын гэрээ” болгон шинэчлэн боловсруулан, шууд оролцогч дөрвөн банктай гэрээ байгуулав.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2013.12.23-ны өдрийн “Үйлчилгээний шимтгэлийн ерөнхий нөхцөл батлах тухай” А-250 тоот тушаалаар банк хоорондын бага дүнтэй нэгж гүйлгээний шимтгэл 200 төгрөг байсныг 20 төгрөгөөр бууруулж, 180 төгрөг болголоо. Ингэснээр 2014 оны эхний 8 сарын байдлаар нийт 3.9 сая ширхэг банк хоорондын бага дүнтэй гүйлгээ боловсруулж, шинэ шимтгэлээр тооцсоноор банкуудад нийт 78.3 сая төгрөгийн хэмнэлт бий болсон нь нэг талаас банкны төлбөр тооцооны системийн үр ашгийг нэмэгдүүлэх, нөгөө талаас иргэдийн төлөх шимтгэлийн хэмжээг нэмэгдүүлэхгүй байх арга хэмжээ боллоо. Цаашид банкинд төлөх харилцагчийн шимтгэлийн хэмжээг бууруулах зорилгоор Монголбанкны зүгээс банк хоорондын цахим худалдан авалтын төлбөр тооцоо, хөдөлгөөнт банкны төлбөр тооцоо зэрэг шинэ үйлчилгээг нэвтрүүлэхээр ажиллаж байна. Монголбанк Үндэсний цахим гүйлгээний төвийн хувьчлалын бодлогыг тодорхойлж, энэ онд багтаан олон нийтэд ил тод болгоно.

3.2. Санхүүгийн зах зээлийн харилцагчдын эрх ашгийг хамгаалах, олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр боловсруулах ажлыг холбогдох байгууллагатай хамтран эхлүүлнэ.

Монголбанкнаас эрх бүхий бусад байгууллагатай санхүүгийн зах зээлийн харилцагчдын эрх ашгийг хамгаалах, олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр хамтран ажиллах, мэдээлэл солилцох “Харилцан ойлголцлын санамж бичиг” байгуулах, хөтөлбөр боловсруулах ажлын хүрээнд Сангийн яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Эдийн засгийн хөгжлийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын банкны холбоотой хамтарсан Ажлын хэсгийг байгуулсан бөгөөд хөтөлбөр боловсруулах ажилд Дэлхийн банкны техник туслалцааг авахаар болсон.

“Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлыг хангуулах журам”-ын хэрэгжилтэд Монголбанк тогтмол хяналт тавьж, газар дээрх шалгалтыг тухай бүр хийхийн сацуу журмын хэрэгжилтийн талаарх судалгааг хийж байна. Түүнчлэн судалгааны үр дүнд үндэслэн бүх банкуудад дээрх журмыг мөрдөн ажиллахыг анхааруулсан зөвлөмж хүргүүлснээс гадна банкуудын хүү, шимтгэлийн нөхцөл өөрчилсөн шийдвэрт хяналт тавин ажиллаж байна.

Дэлхийн банкны төслийн санхүүжилтээр “Санхүү, банкны нэр томъёоны гарын авлага”-ын төслийг эхний байдлаар үндэсний зөвлөхтэй хамтран боловсруулж дууссан бөгөөд Монголбанкны холбогдох газрууд болон Санхүүгийн зохицуулах хороо, Монголын банкны холбоонд хүргүүлж, санал авч байна.

3.3. Мөнгөний бодлогын шийдвэр гаргах үйл ажиллагаа, арга хэрэгслийн ил тод, нээлттэй байдлыг хангах, гаргасан шийдвэрийг олон нийт, бизнес эрхлэгчдэд хүртээмжтэй хүргэх замаар бодлогын үр нөлөөг сайжруулна.

Монголбанкны бие даасан байдлыг бэхжүүлэх, мөнгөний бодлого боловсруулах үйл ажиллагаанд хараат бус төлөөллийг оролцуулах, мөнгөний бодлогын шийдвэрийг оновчтой гаргах зорилгоор Монголбанкны Ерөнхийлөгчийн 2012 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А-160 тоот тушаалаар Мөнгөний бодлогын зөвлөл (МБЗ)-ийг байгуулж, “Мөнгөний бодлогын зөвлөлийн ажиллах журам”-ыг шинээр батлан, уг журамд зөвлөлийн шийдвэр гаргах үйл явц, гарсан шийдвэрийг олон нийтэд хүргэх арга хэлбэр зэрэг зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой асуудлуудыг тусгасан билээ.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2013 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн тушаалаар МБЗ-ийн бүрэлдэхүүнд хараат бус 2 гишүүнийг шинээр томилж ажиллуулах болсон. Одоогоор МБЗ нь 14 гишүүний бүрэлдэхүүнтэй бөгөөд Монголбанкнаас 7 гишүүн, төрийн болон хувийн байгууллага, их сургуулийн багш, судлаачдыг төлөөлсөн хараат бус 7 гишүүн ажиллаж байна. Тус зөвлөл нь мөнгөний бодлогын саналыг батлагдсан журмын дагуу 2-3 удаагийн хуралдаанаар хэлэлцэж, асуудлыг тал бүрээс нь авч үзсэн мэтгэлцээний үр дүнд бодлогын шийдвэр гаргадаг ба шийдвэрийг хэвлэлийн хурал, мөнгөний бодлогын мэдэгдлээр олон нийтэд мэдээлж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан гарсан шийдвэрийн үндэслэлийг нь тайлбарлан, хуралдааны тэмдэглэлийг цахим хуудаст байршуулж байна.

МБЗ-өөс тайлант улиралд бодлогын дараах шийдвэрийг гаргасан:

- 2014 оны 2-р сарын 7-11-ний өдрийн хурлаар Бодлогын хүүг 10.5 хувьд хэвээр үлдээх, Олон улсын зах зээл дээрээс 3 болон түүнээс дээш жилийн хугацаатай бонд болон зээл хэлбэрээр банкны татсан гадаад валютын эх үүсвэрийг Заавал

байлгах нөөцийн шаардлагаас чөлөөлөх.

- 2014 оны 07 дугаар сарын 31-ны өдөр мөнгөний бодлогын хүүг 1.5 нэгж хувиар нэмэгдүүлэн 12.0 хувь болгох шийдвэр гаргалаа.

Олон нийтийн мэдлэг, ойлголтыг сайжруулах зорилгоор Монголбанкнаас мөнгөний бодлогын үндсэн зорилт, чиглэл, үйл ажиллагаа, ил тод байдал, бодлогын харилцан уялдаа, макро эдийн засаг, санхүүгийн суурь ойлголт зэрэг өргөн хүрээтэй асуудлаар олон нийт болон хэвлэл, мэдээллийн ажилтнуудад зориулсан цуврал сургалт, эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөнийг тогтмол зохион байгуулж, хэрэгжүүлж буй бодлоготой холбоотой бүхий л эрх зүйн баримт бичиг, журам, заавар, судалгааны ажил, тайлан, мэдээлэл, статистик мэдээ, хэвлэмэл бүтээгдэхүүнийг Монголбанкны цахим хуудаст байршуулан нийтийн хүртээл болгов. Түүнчлэн эдгээр арга хэмжээнд ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг мөн хамрууллаа.

Дээрх арга хэмжээний хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ:

- Мөнгөний бодлогын зөвлөлийн шийдвэр гарсантай холбоотойгоор хэвлэлийн хурлыг 2014 оны 2 дугаар сарын 12-ны өдөр, 7 дугаар сарын 31-ны өдөр тус тус зохион байгуулж 40 гаруй хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд шуурхай мэдээллээ. Түүнчлэн хэвлэлийн хурлын протокол болон мөнгөний бодлогын мэдэгдлийг англи хэлнээ хөрвүүлж Монголбанкны цахим хуудаст байршуулав. Мөнгөний бодлогын зөвлөлийн гишүүд мөнгөний бодлогын зөвлөлийн шийдвэр гаргалтын талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр яриа, тайлбар, тодруулга өгөв.
- МБЗ-ийн ажиллах журамд заасны дагуу хэвлэлийн хурал болсноос хойш 14 хоногийн дотор мөнгөний бодлогын зөвлөлийн хурлын тэмдэглэлийн товчлолыг гарган Монголбанкны цахим хуудаст байршуулж нийтэд мэдээлэв.
- Монголбанкны цахим хуудсаар дамжуулан цаг үеийн болон графикт 420 гаруй мэдээ, мэдээллийг нийтэд мэдээлэв. Түүнчлэн, Монголбанкны статистикийн сарын бюллетень, тайлан, мэдээллийг УИХ, Засгийн газар, банкууд, харилцагч байгууллагуудын цахим хаягаар тухай бүр хүргүүлж байна.
- Монголбанкны бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, цаг үеийн асуудлаар давхардсан тоогоор хэвлэлд 560 гаруй ярилцлага, тодруулга, мэдээлэл өгөв.
- Улаанбаатар хотын Орон сууцны үнийн индексийн (ОСҮИ) мэдээлэл хийж, хэвлэлийн хурлаар сэтгүүлчдэд дэлгэрэнгүй тайлбар, яриа өгөв.
- Олон нийтийг Монголбанкны үйл ажиллагаатай танилцуулах экскурс болон “Монголбанкны үйл ажиллагаа, мөнгөний бодлого” сэдвээр лекц уншиж, мэдээлэл өгөх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж байна. СЭЗДС-ийн 350 оюутан, ХААИС-ийн 550 оюутан, Идэр дээд сургуулийн 100 оюутан, СУИС-ийн дэргэдэх РТДС-ийн 300 оюутан Монголбанкны үйл ажиллагаатай танилцлаа.
- Монголбанкны жилийн тайлан 2013, Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлын тайлангуудыг хэвлүүлж, УИХ-ын гишүүд, Эдийн засгийн байнгын хороо, холбогдох газруудад хүргүүлж Монголбанкны цахим хуудаст байршуулав.

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Макро эдийн засгийн гол үзүүлэлтүүд - 1	19
Хүснэгт 2. Макро эдийн засгийн гол үзүүлэлтүүд – 2	20
Хүснэгт 3. Эдийн засгийн бодит өсөлт (%), салбараар	21
Хүснэгт 4. 2014 оны эхний 8 сарын улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл (тэрбум төгрөг)	25
Хүснэгт 5. 2013, 2014 оны төсөв	26
Хүснэгт 6. МУХБ-ны зарцуулалт томоохон төслүүдээр	26
Хүснэгт 7. Төсвийн хүрээний мэдэгдэл (тэрбум төгрөг)	27
Хүснэгт 8. Мөнгөний үзүүлэлтүүд /2008-2015/*	29
Хүснэгт 9. Гадаад худалдааны эргэлт /сая ам.доллар/	38
Хүснэгт 10. Экспортын барааны гүйцэтгэл - эхний 8 сар (сая ам.доллар)	38
Хүснэгт 11. БНХАУ-ын түүхий эдийн импорт	39
Хүснэгт 12. Импортын барааны гүйцэтгэл - эхний 8 сар (сая ам.доллар)	39
Хүснэгт 13. Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц – 2014 оны 2-р улирлын байдлаар (сая ам.доллар)	41
Хүснэгт 14. Нийт гадаад өрийн үлдэгдэл	42
Хүснэгт 15. Түүхий эдийн үнийн төлөв:	44
Хүснэгт 16. Хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүд	45
Хүснэгт 17. Төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлт	61
Хүснэгт 18. ДНБ-ий бодит өсөлт (%)	63

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Инфляци	18
Зураг 2. Эдийн засгийн бодит өсөлт	18
Зураг 3. Үйлдвэрлэл талаас тооцсон ДНБ-ий өсөлт	21
Зураг 4. Эрэлт талаас тооцсон ДНБ-ий өсөлт	22
Зураг 5. Оюу толгой, Таван толгойн үйлдвэрлэл болон экспортын хэмжээ	23
Зураг 6. Үйлдвэрлэлийн зөрүү сөрөг хэвээр байна	23
Зураг 7. Төсвийн нийт орлого ба тусламж	25
Зураг 8. Төсвийн нийт зарлага ба цэвэр зээл	25
Зураг 9. Төсөвтэй адилтгах зардлыг оруулснаар	26
Зураг 10. М2 мөнгө болон зээлийн өсөлт, ГЦА, ДЦА-ын түвшин (тэрбум төгрөг)	28
Зураг 11. М2 мөнгөний өсөлт, бүрэлдэхүүнээр (актив)	28
Зураг 12. М2 мөнгөний өсөлт, бүрэлдэхүүнээр (пассив)	28
Зураг 13. Мөнгө, зээлийн өсөлт (орон сууцны ипотекийн зээлийг хассанаар)	28
Зураг 14. Банкуудын илүүдэл нөөцийн хэмжээ (сарын дундаж)	30
Зураг 15. Хадгаламж, зээлийн хүү	30
Зураг 16. БХЗ-ын жигнэсэн дундаж хүү	31
Зураг 17. Банк хоорондын захын арилжааны хэмжээ (тэрбум төгрөг)	31
Зураг 18. Төгрөгийн ам.доллартай харьцах Монголбанкнаас зарласан ханш	34
Зураг 19. Ханшийн өдрийн хэлбэлзлийн хистограм	34
Зураг 20. Төлбөрийн тэнцэл (сая \$)	35
Зураг 21. Урсгал тэнцэл (сая \$)	35
Зураг 22. Төлбөрийн тэнцэл (тэрбум ам.доллар)	35
Зураг 23. Урсгал тэнцэл (тэрбум ам.доллар)	35
Зураг 24. Барааны гадаад худалдаа (сая \$)	36
Зураг 25. Үйлчилгээний гадаад худалдаа (сая \$)	36
Зураг 26. Хөрөнгө, санхүүгийн данс (сая \$)	37
Зураг 27. Гадаад валютын улсын нөөц (сая \$)	37
Зураг 28. Хөрөнгө, санхүүгийн дансны төсөөлөл	37

Зураг 29. Худалдааны нөхцөлийн индексийн жилийн өөрчлөлт /3 сарын гулсах дунджаар ..	38
Зураг 30. Дэлхийн түүхий эдийн зах зээл дээрх үнэ	39
Зураг 31. Импортын барааны задаргаа /улирлын нөлөөллийг засварласнаар/.....	40
Зураг 32. Гадаад актив	42
Зураг 33. Гадаад пассив	42
Зураг 34. Гадаад өрийн үлдэгдэл	42
Зураг 35. Ажил эрхлэлт, салбараар.....	45
Зураг 36. Нэрлэсэн цалин, салбараар	45
Зураг 37. Нийт хөрөнгийн хэмжээ (тэрбум төгрөг) ба хөрөнгөөр тооцсон салбарт эзлэх хувь хэмжээ	46
Зураг 38. Азийн бүрэлдэж буй болон хөгжиж буй эдийн засагтай зарим орнуудын санхүүгийн гүнзгийрэлт (хувиар)	46
Зураг 39. Зээлийн өрийн үлдэгдэл (салбараар)	47
Зураг 40. Чанаргүй зээлийн хувийн жин	48
Зураг 41. Чанаргүй зээлийн хувийн жин (салбараар).....	48
Зураг 42. Банкны салбарын эх үүсвэрийн бүтэц.....	48
Зураг 43. Банкны салбарын өөрийн хөрөнгийн хүрэлцээ	49
Зураг 44. Банкны салбарын ТТГЧ-ын харьцаа.....	49
Зураг 45. Зээл, хадгаламжийн харьцаа	51
Зураг 46. Зээлийн үзүүлэлтүүд	51
Зураг 47. Зээлийн үлдэгдлийн хэмжээ	55
Зураг 48. Шинээр олгосон зээлийн өсөлт, салбараар	55
Зураг 49. Иргэдийн зээлийн өсөлт, салбараар	56
Зураг 50. Чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлийн хувь, ам.долларын ханш	56
Зураг 51. Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь, салбараар	56
Зураг 52. Улсын болон Улаанбаатар хотын инфляци.....	57
Зураг 53. Улаанбаатар хотын оны эхнээс тооцсон инфляци (бүтцээр нь задалсан)	57
Зураг 54. Жилийн инфляци, хөтөлбөрт хамрагдсан бараа болон бусад бараа	58
Зураг 55. Махны үнийн жилийн өсөлт.....	58
Зураг 56. Улаанбаатар хотын жилийн инфляци	59
Зураг 57. Төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээ.....	59
Зураг 58. Боловсролын үнийн өсөлт	59
Зураг 59: Иргэдийн инфляцийн хүлээлтийн харьцуулалт.....	60
Зураг 60: Иргэдийн инфляцийн хүлээлтийн чиглэлийн индекс	60
Зураг 61. Инфляцийн богино хугацааны төсөөлөл	61
Зураг 62. Инфляци дахь төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн нөлөөлөл	62
Зураг 63. Улирлын ДНБ-ий бодит өсөлт (%).....	63
Зураг 64. Гадаад, дотоод цэвэр актив (тэрбум төгрөг)	64
Зураг 65. ГЦА, ДЦА-ын жилийн өөрчлөлт (%)	64
Зураг 66. Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн өөрчлөлт (интервалаар)	73
Зураг 67. УБ хотын сарын ба жилийн инфляци	79
Зураг 68. Улаанбаатар хотын жилийн инфляци (бүтцээр)	79
Зураг 69. Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах хөтөлбөрт хамрагдсан барааны инфляци болон бусад барааны инфляци (2008-2014 оны 8-р сар)	80
Зураг 70. Төгрөгийн ам.доллартай харьцах ханш ба урсгал данс	83

ШИГТГЭЭНИЙ ЖАГСААЛТ

Шигтгээ 1. Боломжгүй гурвал юу өгүүлнэ вэ?	32
Шигтгээ 2. Гадаад худалдаа, түүхий эдийн зах зээл	37
Шигтгээ 3. Эрсдэлийн үнэлгээнд суурилсан хяналт шалгалтын талаар	50
Шигтгээ 4. Төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээний инфляцид үзүүлэх нөлөө	58
Шигтгээ 5. Төгрөгийн ханшийн сулралт болон инфляци	61

Тэмдэглэл

